

ДОТООД ХЭРГИЙН ИХ
СУРГУУЛЬ

МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО



ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2019 №4 (70)
17 дахь жилдээ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Батбуян БАТ-ЭРДЭНЭ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун Бат-Эрдэнэ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Насанжаргал ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Авирмэд ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ганбат ЭРДЭНЭБАТ
ДОКТОРАНТ

Батзэвэг ЭНХБОЛД
ДОКТОР (Ph.D)

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Сэнгээ ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН

Бэгзсүрэн Жамсран

ГАРЧИГ

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
The Sexual Abuse Crimes Against Children In Vietnam.....Nguyen Van Hung, Enkhbold Batzeveg	4
Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх гэмт хэргийн өнөөгийн байдал, анхаарах асуудал.....Г.Мөнгөншагай	9
Гэмт хэрэг, зөрчлийн хамаарал, урьдчилан сэргийлэх зарим асуудал.....Э.Дашгаадан	13
Тээврийн цагдаагийн албаны алба хаагчдын сэтгэл санааны байдал, ажлаас халшрах хам шинжийн түвшинг тодорхойлсон нь.....Э.Бямбажаргал	18
ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Хүн барьцаалахын эсрэг олон улсын эрх зүйн зохицуулалт.....Д.Сундуйсүрэн	23
Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, олон улсын жишиг.....Б.Досжан	31
Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах ойлголт, үндэслэл, онцлог.....Т.Еркебулан	38
ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Мөрдөн шалгах нууц ажиллагаа: үзэл баримтлалын зарим асуудал.....Н.Манлайбаатар	44
ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэл ба эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарах асуудал.....Б.Баянмөнх	48
Албаны нохойн үүсэл хөгжил, эрх зүйн зохицуулалт, ашиглах аргачлал, анхаарах зарим асуудал.....Ш.Чулуун	53
Төмөр замын салбар дахь гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэх үйл ажиллагааг сайжруулах зарим асуудал.....Р.Баяраа	62
ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ	
European Union Policy on Foreign Direct Investment.....Ninjin Bataa	65
Historic Traditions of Civil Law In Mongolia and Its Regulation and Principle.....Otgongerel Jantsan	76

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

THE SEXUAL ABUSE CRIMES AGAINST CHILDREN IN VIETNAM

Nguyen Van Hung
Master student, Graduate school, University of Internal Affairs in Mongolia
Enkhbold Batzeveg
Head of criminal law and Criminology Department, Police school,
University of Internal affairs in Mongolia

Abstract

The sexual offenses against children in our country are complicated and tends to increase. In Vietnam general crime situation and the situation of sexual offenses against children in particular have dramatically increased, causing many harmful consequences for children themselves, their families and society. Comes from the danger of acts of sexual abuse of children and the urgency of preventing this type of crime in the future, so in this article the author parse the crime's situation sexual abuse of children in Vietnam and forecasting of sexual offenses against children in Vietnam in the future.

Keywords: Sexual abuse against child, crime, Vietnam.

1. Background:

Child protection is the responsibility of the whole society, ensuring the comprehensive development of children, the future generation of the nation, the successors of national construction and defense. Article 65 of the 1992 Constitution of the Socialist Republic of Vietnam (amended and supplemented in 2013) states, "Children are protected, cared for and educated by the family, the state and the society". In recent years, Vietnam has carried out many practical activities with various measures to protect, care for and educate children. However, a worrying situation still exists, child sexual abuse is still complicated and tends to increase. In Vietnam, the situation of sexual offenses is complicated, leaving many unsettling consequences for children, their families and the society. Therefore, in addition to paying attention to the care, nurturing and education of children, it is necessary to pay attention to the protection of children from abuse and abuse, especially sexual abuse children.

2. Content

2.1. Situation of sexual abuse against children crimes in Vietnam

In order to accurately assess the situation of the situation of child sexual abuse crimes that have occurred, the author considers the following factors:

2.1.1. The extent of the situation of sexual abuse against children crimes in Vietnam

Table 2.1: Statistics of sexual abuse against child crimes in Vietnam from 2014 to 2018.


Year	Total number of criminal cases	Total number of cases of sexual abuse against children crimes	Total number of offenders	Total number of victims
2014	50.723	1544	1558	1555
2015	59.111	1262	1270	1274
2016	59.988	1321	1350	1329
2017	57.022	1370	1385	1380
2018	53.240	1269	1292	1280
Total	280.084	6.766	6855	6818

According to statistics from the Ministry of Public Security of Vietnam from 2014 to 2018, 280.084 criminal cases occurred in Vietnam, of which 6766 cases of child sexual abuse occurred (accounting for 2,41%), the number of offenders is 6855, the number of children as victims is 6818.

2.1.2. Evolution of sexual abuse against children crimes in Vietnam

The evolution of a criminal situation is the upward or downward trend of crime situation in a certain area, which is determined by many factors, of which the special factor is the condition and social situation or change of criminal law.

Table 2.2: Evolution of the situation of sexual abuse against children crimes in Vietnam from 2014 to 2018



The highest number of sexual abuse against child crimes in 2014 was 1544, accounting for 3.04% of the total number of criminal cases that occurred in Vietnam. Table 2.2 shows that the situation of sexual abuse against child crimes in Vietnam in the past 5 years has complicated changes, the number of crimes tends to increase and decrease abnormally. The uneven increase in the situation of sexual abuse against child crimes also shows us the complicated evolution of the crime situation, hiding the risks of increasing this crime group in the near future.

*** Situation of sexual abuse against children crimes under specific crimes**

Table 2.3: Statistics

Year	Total number of cases of sexual abuse against children crimes		Rape of children		Engaging in sexual intercourse with children		Molestation with children		Sexual abuse		Engaging in prostitution with a person under 18	
	Number of cases	Rate	Number of cases	Rate	Number of cases	Rate	Number of cases	Rate	Number of cases	Rate	Number of cases	Rate
2014	1544	100	902	58,4	318	20,5	300	19,4	8	0,51	16	1,19
2015	1262	100	745	59	271	21,4	234	18,5	5	0,39	7	0,71
2016	1321	100	446	33,7	677	51,2	189	14,3	3	0,22	6	0,58
2017	1370	100	170	12,4	885	64,5	306	22,3	5	0,36	4	0,44
2018	1269	100	425	33,4	606	47,7	232	18,2	4	0,31	2	0,39
Total	6.766	100	2.688	39,7	2757	40,7	1261	18,6	25	0,36	71	0,64

The highest rate of rape against children in Vietnam in 2015 was 59% and 58.4% in 2014. The situation of rape crime tends to decrease in 2016, 2017, 2018. However, reducing child rape crime will increase the crime rate in other crimes such as, the rate of engaging in sexual intercourse with children in the years 2016, 2017 and 2018, the trend increased, in 2016 accounted for 51.2%, up 29.8% compared to 2015, in 2017 accounted for 64.5%, up 13.3% compared to 2016. Meanwhile, the rate of molestation with children is relatively small and the increase and decrease of this type of crime is also uneven, the highest rate of molestation with children in 2017 was 22.3%, in 2014 was

19, 4%, 2015 was 18.5%. The crime of sexual abuse and engaging in prostitution with a person under 18 accounts for a small percentage of the total number of sexual abuse against child crimes cases every year.

The above table also shows that in the structure of sexual abuse against child crimes in Vietnam, the situation of rape of children crime and engaging in sexual intercourse with children crime is quite common. Therefore, the fight against this type of crime needs to have positive solutions, focusing primarily on child rape, sexual intercourse with children and other crimes in the group of sexual abuse against child crimes.

Table 2.4: Situation of sexual abuse against children crimes in some provinces and cities of Vietnam

No	Province/City	Total number of cases of sexual abuse against children crimes from 2014 to 2018
1	Ha Noi City	422
2	Ho Chi Minh City	398
3	Hai Phong City	278
4	Can Tho City	215
5	Da Nang City	189
6	Nghe An Province	202
7	Thanh Hoa Province	289

These are provinces and cities with the highest number of child abuse crimes according to statistics from the Ministry of Public Security of Vietnam over the past 5 years. Based on the above table, Hanoi and Ho Chi Minh City are the localities with the highest number of child sexual abuse cases. Hanoi and Ho Chi Minh City are two special cities and are the economic, cultural and political centers of Vietnam. As of 2019, the population living, working and studying in Hanoi is about 10 million people, in Ho Chi Minh City about 9 million people. The large population leads to complications in order and security, the number of criminal crimes always accounts for a high proportion of the whole country, including sexual abuse against child crimes.

2.1.3. Crime situation characteristics

***Characteristics of criminal tricks:** Taking advantage of the children's trust, using seductive material to commit criminal acts, accounting for 41.3% (2794/6766 cases); using force to make a crime accounted for 28.6% (1935/6766 cases); use of material to seduce 15.8% (1069/6766 cases) and other tricks such as taking advantage of children's ignorance, children too young, children with intellectual disabilities accounted for 14.3% (968/6766 cases).

***Characteristics of the location of the crime:** The object of the offense is mainly in the house of the victim, accounting for 35.2% (2381/6766 cases). The reason is partly due to the lack of care and attention from the family, parents do not have proper attention to their children, burdens and economic worries that make parents focus only on making money, do not care their children. The locations where the subjects choose to commit crimes in secret places also account for a high proportion of 33.7% (2280/6766), in these places the victims are hard to call for help, the deserted places are rarely visited; committing crimes at defendant's houses or inns, hotels accounting for 22.9% (1549/6766 cases); and in other areas accounted for 8.2% (556/6766 cases).

***Characteristics of time of committing crime:** The time of committing the crime is mainly the time from 6 hours to 18 hours, accounting for 47.9% (3240/6766 cases); followed by the period from 18 hours to 22 hours, accounting for 38.3% (2591/6766 cases); and the time from 22 hours to 6 hours, accounting for 13.8% (935/6766 cases).

***Occupation of offenders:** Statistics of sexual abuse against child crimes in Vietnam showed that the offenders highest mostly freelancers, career instability accounting for 55.4% (3797/6855); farmers accounting for 15.4% (1055/6855); workers accounting for 6.9% (473/6855); pupils and students accounting for 7.8% (535/6855); non-occupation accounting for 14.4% (987/8655); civil servant accounting for 0.1% (8/6855).

***Education level of offenders:** Among 6855 people who committed child sex offenses, illiterate subjects accounting for 17.6% (1206/6855); primary education accounting for 37.6% (2577/6855); secondary school accounting for 30.2% (2070/6855); high school level accounting for 12.4% (850/6855) and education level of College, University or higher accounting for 2.2% (152/8655).

***Age of offenders:** Research results show that the majority of children aged 18 to under 30 years old who committed sexually assaulted children accounting for 58% (3976/6855); the age of minors from full 14 to less than 18 years old accounting for 21.2% (1453/6855); and over 30 years old accounting for 20.8% (1426/6855).

***Relationship between the victims and the offenders:** In recent cases of child sexual abuse in Vietnam in the past years, between the offenders and the victims with a neighbor's relationship, there is a known acquaintance very high rate of 66.8% (4520 cases); relative relations, relatives accounting for 7.2% (487 cases); relationship 18.3% (1238 cases); only 5.1% of crimes between offenders and victims are unknown to each other.

***Age of the victims:** People aged from 13 to under 16 years of age who were most sexually abused, accounting for 49.5% (3375/6818); 6 to under 13 years old accounting for 37.3% (2544/6818); and the lowest is the age under 6 years old accounting for 13.2% (899/6818).

2.2. Predict the situation of sexual abuse against child crimes in Vietnam in the next 5 years.

2.2.1. Basis of forecast:

Crime forecast is essentially a prediction of crime development trend, structure of crime situation, causes and conditions affecting future crime situation. In recent years, Vietnam has experienced a strong development in all aspects of economy, culture and society, especially the formation of many industrial parks and export processing zones. Besides the achievements at the same time, there are a series of pressing issues that are posed under the impact of the market economy's negative side such as the gap between rich and poor, between rural and urban people, social injustices, the decline in morality, lifestyle, the number of other provinces in labor, study and work are increasing, the types of services in industrial parks and seaport areas are more and more, that situation State management and security in Vietnam also have many issues that need attention.

Increased specialization in careers, expanded relationships, conditions, and job opportunities have raised issues related to family life. Couples and family members have little time to spend time together. And especially in rural areas, where ethnic minorities live, the care and attention of the family towards children a very limited, the educational role of the family for children is not much. In addition, children's awareness of family affection has also changed, divorce accounts for a high proportion for families of the younger generation, the breakdown of the family has made children lack shelter, emotional sentiments change so that children easily become victims of sexual abuse against child crimes.

Technological development is also a problem for society. The inability of authorities to control depraved websites has resulted in a number of teenagers being sexually stimulated by what they have seen and even being addicted to sex. To satisfy their needs, they are willing to commit crimes and children.

2.2.2. Content forecasts

***Situation of sexual abuse against child crimes:**

It is forecast that in the coming time, the situation of sexual abuse against children crimes will show signs of increase; complicated movements, methods and tricks of crime are increasingly sophisticated and cunning; nature and degree of danger are increasing; the consequences of harm are increasing and especially in crimes such as rape against children, sexual intercourse and child pornography. Engaging in prostitution with children is relatively small, but we still have to prevent this crime in the future children are most targeted by their innocence and ignorance.

***Offenders:**

Child sex offenders are concentrated on the ages of 18 and under 30 years old, followed by the age of minors from 14 to under 18 years old. Usually, offenders have acquaintance with the victim, the victim's family or near the victim's house, offenders often focus most on the subjects with primary education and illiteracy, followed by the intermediate level junior high school. The highest number of child sex offenders is self-employed and unstable, while the number of sex offenders with children as farmers is also the proportion pretty high.

***Crime tricks:**

The main mode of crime is to take advantage of children's beliefs and use physical material to commit acts of sexual abuse against children, but at the same time, the offenders also take advantage of children's acquaintance and ignorance to commit a criminal act and hide your criminal behavior. Although this method is not new, in the coming time, there will be cases where offenders use force to kill victims to commit acts of child sexual abuse or right after committing acts of

infringement. Child sexual objects will kill victims to cover clues. In many cases the subject may rob the victim of property. In addition, there will be cases through sex trafficking, virginity trafficking to child sexual abuse.

***About the location of the crime:**

According to research results, Hanoi and Ho Chi Minh City are the places with the highest number of child sexual abuse cases. This is a key area of this type of crime in the near future. The main reason is due to the large number of immigrants and workers, so the management of residence also faces many difficulties. This requires increasing monitoring and supervision, stabilizing regional security and children need special attention, first of all from the family.

***About family circumstances:**

People who commit crimes of child sexual abuse often have economic circumstances, difficult life, groups of people with unhappy family life such as divorce or losing a wife also account for a relatively high proportion of child sexual abuse high.

***About the victims:**

Statistics show that the victims of this crime in Vietnam are mainly concentrated in people aged 13 to under 16 years old, followed by the ages from 6 to under 13 years old and the lowest is the age group under 6 years old. In the coming time, children under 6 years of age who are sexually abused will be on the increase, the victim will still focus on those children whose family situation is not in harmony and difficult, their parents often leave home for work.

3. Conclusion

Protecting children from abuse in general and sexual abuse in particular is a regular and long-term task not only in Vietnam but also globally. The world has millions of sexually abused children. In Vietnam, child sexual abuse always accounts for a high proportion of child abuse crimes. Therefore, improving the effectiveness of the fight against child sexual crimes is an urgent requirement. The fight against crime in the general and child sexual abuse in particular is one of the basic conditions for ensuring children's rights, creating a safe and healthy living environment, ensuring that children develop physically and mentally in harmony, contributing to stabilizing social order and safety, serving the cause of socioeconomic development of the country.

References:

1. Congress. 1992. *Constitution of the Socialist Republic of Vietnam*, National Political Publishing House. Hanoi.
2. Criminal Code 1999. 2015. National Political Publishing House. Hanoi.
3. Criminal Code 2015. 2017. Judicial Publishing House. Hanoi
4. Criminal Police Department - Ministry of Public Security. 2014, 2015, 2016, 2017, 2018. *Final report*.
5. Duong Tuyet Mien. 1998. "On sexual offenses in Vietnam's Criminal Law", Journal of Jurisprudence, page 44.
6. Dinh Van Que. 2002. *Scientific commentary Criminal Code section on crime*, volume I. Ho Chi Minh City Publishing House.
7. Nguyen Duc Mai and Nguyen Ngoc Anh. 2010. *Scientific commentary Criminal Code 1999 amended and supplemented in 2009*. National Political Publishing House. Hanoi.
8. Nguyen Tuan Thien. 2015. "Sexual abuse against children in Vietnam Criminal Code". Hanoi National University. Hanoi
9. Nguyen Thi Minh Huong. 2014. "Sexual abuse against child crimes in Vietnam Criminal Law". Faculty of Law, Hanoi National University. Hanoi.

---oOo---

**ХУУЛЬ БУСААР ЭМ, БИОБЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ ҮЙЛДВЭРЛЭХ,
ИМПОРТЛОХ, ХАДГАЛАХ, ХУДАЛДАХ, ТҮГЭЭХ ГЭМТ ХЭРГИЙН
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АНХААРАХ АСУУДАЛ**

Г.Мөнгөншагай

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн
эрхлэгч, цагдаагийн ахмад*

*Хүн төрөлхтөн түүхийн бүхий л үед гэмт хэрэг,
өвчин гэсэн хоёр зүйлтэй тэмцэж ирсэн.*

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох, түүнийг хэрэгжүүлэх асуудал нь нийгмийн амьдралд үүсэж буй шинэ үзэгдлүүд, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын шинэчлэлийн алс хэтийн үр дүнг төсөөлөхийн тулд тасралтгүй хэрэгжих байнгын үйл явц байдаг.

Монгол Улс нийгэм, эдийн засаг, улс төрийн цоо шинэ тогтолцоонд эргэлт буцалтгүй шилжих болж, эрх зүйт төрийг төлөвшүүлэх үйл явцтай шууд холбоотойгоор урьд өмнө гарч байгаагүй, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц аж ахуйн шинжтэй гэмт хэргүүд үйлдэгдэх болсон нь тэдгээртэй хариуцлага тооцох эрх зүйн үндэс, хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал илт үгүйлэгдэж байгааг илэрхийлж байна.¹

Аливаа үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх ойлголт нь өөрөө Монгол Улсын эрүүгийн бодлогын нэг хэсэг бөгөөд үйлдэл, эс үйлдэхгүйг нийгэмд аюултай гэж тооцон эрүүлжүүлэх /криминализици/ явдлаар тодорхойлогддог. Эрүүлжүүлэх гэдэг нь нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заах үйл явц бөгөөд энэ үйл явц нь Эрүүгийн хуулийн хамгаалалтад авагдах ёстой хүн, төр, нийгмийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлын хүрээг тодорхойлдог онцлогтой.²

Өнөөдөр манай улсад үүссэн нөхцөл байдлаас үзэхэд валютын гэх тодтголтой олддоггүй ховор эмийг дотооддоо үйлдвэрлэх, гадаадаас импортлох болсонтой холбоотойгоор эмийг хууль бусаар үйлдвэрлэх, импортлох, худалдаалах, түгээх, хадгалах зэрэг хүн амын эрүүл мэнд, эдийн засаг, амь насанд аюул учруулахуйц гэмт хэрэг ихээр үйлдэгдэх боллоо.

Иймд энэхүү өгүүллээрээ зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох хадгалах, худалдах, түгээх үйлдэлтэй тэмцэж байгаа эрүүгийн эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийх замаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замын талаар санал-зөвлөмж боловсруулахыг зорьсон.

Эм гэдэг нь хүний болон мал, амьтны өвчнийг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх зориулалттай, үйлчлэл нь эм судлал эмнэл зүйн³ сорилт туршилтаар нотлогдсон, нийтлэг буюу амьтан, ургамал, эрдсийн гаралтай тодорхой тун хэмжээгээр хэрэглэгддэг бодисыг хэлэх⁴ бөгөөд эм нь хүнсний бүтээгдэхүүнээс ялгаатай нь хүний бие махбодь, эрүүл мэндэд хэдэн арав дахин хор хөнөөлтэй гэж⁵ судлаачид тэмдэглэсэн байдаг. Иймээс ч хууль бусаар эм, бэлдмэл худалдаалах нь хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж, улмаар үндэсний аюулгүй байдалд заналхийлдэг, нийгмийн хор аюулаар их учир хүн амын эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах үүднээс дээрх үйлдлийг гэмт хэрэгт тооцож, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид хуульчилсан байдаг.

Хууль бусаар эм худалдаалах явдалтай тэмцэж ирсэн уламжлалыг авч үзвэл, одоогоос 87 жилийн өмнө “Хүрээнд байсан хувийн эмнэлэгийн газруудыг журамлан, улсын болгох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байсан” нь архивын баримт бичигт үлджээ.⁶

Монгол Улсад үйлчилж байсан Шүүх цаазын бичгүүд, Эрүүгийн хуулиудад энэхүү үйлдлийг гэмт хэрэгт тооцож байсан нь аль ч нийгмийн үед эмийн хууль бус эргэлттэй тэмцэх

¹ С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ., 2004, 10 дахь тал

² С.Жанцан. Монголын төрийн эрүүгийн бодлогын тулгамдсан асуудал, Гэмт явдалтай тэмцэх асуудал онол арга зүйн сэтгүүл. УБ, 2004. №4 14 дахь тал

³ **Эмнэлзүйн эм судлал** – Клиническая фармакология – Clinical pharmacology гэдэг бол аливаа эмийн бэлдмэл өвчтэй хүний бие махбодид хэрхэн үйлчилдгийг судладаг, эмнэлзүйн хийгээд биологийн Ш|У-ны шинж чанарыг агуулсан, орчин үеийн А|У-ны нэгэн шинэ салбар шинжлэх ухаан юм.

⁴ Монгол улсын эмийн тухай хууль 3 –р зүйл

⁵ Сономын Ренчинхорлоо судалгааны тайлан ,12 дахь тал, 2006 он

⁶ http://greatkhanaa.blog.banjiga.net/post.php?post_id=152414

асуудал нь төрийн анхаарлын төвд байж ирснийг илэрхийлэх юм. Тухайлбал, 1926, 1929 оны Шүүх цаазын бичигт “Аливаа эмийн зүйлийг найруулах ба эм худалдах газраас бусад дор худалдах тухай дүрэм зааврыг зөрчигсөдийг 100 төгрөг хүртэл торговол зохино” хэмээн хууль бусаар эм худалдаалах үйлдвэрлэхийг хориглосон шинжтэй харилцааг зохицуулж байснаас гадна “Аливаа хорын зүйл буюу мөн зүйл оролцсон хатуу эм ба хар тамхийг албан газрын зөвшөөрөлгүйгээр бусдад худалдахаар хадгалах буюу худалдагсадын уг зүйлүүдийг албадан хурааж 3 сар хүртэл хорих буюу 150 төгрөг хүртэл торговол зохино” хэмээн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар худалдаалахыг хориглосон зүйл заалтыг тусгаж байсан бол 1934 оны Шүүх цаазын бичиг болон 1942 оны Эрүүгийн хуульд энэ үйлдлийг нийгэмд аюулгүй хэмээн үзэж, Эрүүгийн хуулиас хассан бөгөөд гагцхүү бусдыг хууль бусаар эмчлэхийг хориглосон шинжтэй харилцааг зохицуулж байсан.

Харин 1961 оны Эрүүгийн хуулийн 185 дугаар зүйлд “Хүний биед хүчтэй нөлөөлөх хордуулах, ухаан алдуулах бодисыг зөвшөөрөлгүй найруулж бэлтгэх, худалдаж борлуулах мөн худалдаж борлуулах зорилгоор хадгалах буюу олж авах түүнчлэн, хүний биед хүчтэй нөлөөлөх хордуулах ухаан алдуулах бодисыг хадгалах тавьж олгох бүртгэх тээвэрлэх, явуулах талаар тогтоосон дүрмийг зөрчвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан” бол 2002 оны Эрүүгийн хуульд “Эмийн сангийн үйл ажиллагааг эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дууссан эм бэлдмэлийг их хэмжээгээр борлуулсан”, “Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол...” ял хүндрүүлэхээр заасан нь хүн амын эрүүл мэнд, эрх ашгийг Эрүүгийн хуулиар хамгаалахад чухал алхам болсон.

Гэвч орчин үед зарим байгууллага, аж ахуйн нэгж, иргэд зөвшөөрөлгүй, хяналтгүйгээр эмийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, импортоор гаднаас оруулж ирэх, хугацаа нь дууссан, манай улсад бүртгэлгүй эмүүдийг хувиараа худалдах, түгээх явдал хавтгайрснаас ийм эмийг хэрэглэсэн иргэд амь нас, эрүүл мэндээрээ хохирох явдал түгээмэл гарах болсон нь эрх зүйн зохицуулалт нийгмийн харилцаагаа гүйцэхгүй байгааг илэрхийлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатайг илтгэнэ.

Аливаа хууль үйлчлэх явцад хийдэл, хэрэглэхэд хүндрэлтэй асуудал байнга гарч, түүнийг арилгах зарим хэм хэмжээг боловсронгуй болгох зайлшгүй шаардлага тулгардаг нийтлэг зүй тогтлын дагуу дээрх байдлыг харгалзан УИХ-аас 2008 оны 2 сарын 01-ний өдрийн Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “Эмийн сангийн үйл ажиллагааг хууль бусаар явуулах” гэж 198 дугаар зүйлд заасан гэмт хэргийг “Хууль бусаар эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх” гэж өөрчилж, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг нь дараах байдлаар хуульчилсан:

Эрүүгийн хуулийн 198 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэсэн, импортлох, хадгалсан, худалдсан, түгээсэн бол”, 198 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйл ажиллагаа явуулсан бол”, 198 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан бол” хүндрүүлэх бүрэлдэхүүнд хуульчилсан нь өмнөх Эрүүгийн хуулидтай харьцуулахад боловсронгуй болжээ.

Учир нь Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 198 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйл ажиллагаа явуулсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь өмнөх Эрүүгийн хууль тусгагдаагүй шинэ агуулгатай, иргэдийн эрх ашиг, хүн амын эрүүл мэндийг Эрүүгийн хуулиар хамгаалсан, эрх зүйн хийдлийг арилгасан зохицуулалт болсон хэдий ч хууль бусаар эм, худалдаалах явдал нь нийгэмд тарахсан түгээмэл үзэгдэл, энэхүү үзэгдэлд хандах иргэдийн сэтгэлгээ зэрэг нөхцөл байдлаас хамаарч хуулийн хэрэгжилт хангалтгүй байсаар байна.

Үүний шалтгаан нь Эрүүгийн хуулийн 198 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зохих зөвшөөрөлгүй этгээд хууль бусаар эм үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээсэн” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хэлбэрийн бүрэлдэхүүнтэй⁷ -гээр хуульчилсан явдал нь энэ зүйлийг практикт хэрэглэхэд хүндрэл учруулж байна. Өөрөөр хэлбэл, зохих зөвшөөрөлгүй этгээд эмийг худалдаалсан, үйлдвэрлэсэн, түгээсэн үйлдэл хийснээр төгсдөг, ямар нэгэн хор уршиг учирсан байхыг шаардахааргүй хуульчилсан нь учир дутагдалтай болж, манайд бий

⁷ Д. Адыабазар “Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт”. УБ., 1998 он, 195 дахь тал

⁸ “Монгол улсын эрүүгийн хууль”, 2002 он, 198 р зүйл,

⁹ Заавал хор уршиг учирсан байхыг шаарддаггүй, үйлдэл хийснээр төгсдөг гэмт хэрэг

болсон нөхцөл байдалд нийцэхгүй, эцсийн дүнд эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг үгүйсгэж байна. Тухайлбал, Иргэн А нарантуул захад эм зардаг Батаас эм худалдан аваад түүнийг хэрэглээгүй Н-д ямар нэгэн хохирол учраагүй байхад иргэн Батад эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдсэн. Ийм байдлаар их бага хэмжээгээр гар дээрээс эм худалдаалах явдал түгээмэл байдаг нь нийгэмд хэвшил болоод тогтсон зан үйл атал түүнд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан нь хууль тогтоогчийн зүгээс нийгмийн амьдралын бодит байдалд тулгуурлаагүйг илэрхийлж байна.

2015 оны Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлд хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан үндсэн болон хүндрүүлэх шинжтэйгээр хуульчилсан.

Сүүлийн жилүүдэд эм, эмнэлгийн хэрэгслээс гадна биобэлдмэл, малын эм, биобэлдмэлийг иргэн, хуулийн этгээд ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр худалдах, түгээх, импортлох болж, малын эм, бэлдмэлийн чанар хангалтгүй байгаа талаар мэдээлэл гарах болсон. Иймд энэ гэмт хэргийн халдлагын зүйлд биобэлдмэл, малын эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг шинээр нэмж, малын эмчилгээнд хэрэглэхийг хориглосон, зөвшөөрөгдөөгүй, хугацаа дууссан эм, эмийн түүхий эд, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх үйлдлийг гэмт хэрэгт шинээр тооцсон.

Эмийг хууль бусаар үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх гэмт хэрэг нь дэлхийд ашиг орлогоороо тэргүүлдэг гэмт хэрэг бөгөөд дэлхийн улс бүр энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй үр дүнтэй тэмцэхийн тулд хатуу чанга ялын бодлого баримталж байна. Тухайлбал, БНХАУ-ын Эрүүгийн хуулийн 141 дүгээр зүйлд “Хуурамч эм үйлдвэрлэж, борлуулаад хүний биеийн эрүүл мэндэд хүнд ноцтой хор хөнөөл болоход хүрсэн”, “Энэ хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд ноцтой хор уршиг учруулсан” байвал гурваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх бөгөөд мөн торгох ялыг давхар оногдуулахаар заасан. Энэ гэмт хэргийн улмаас хүнийг үхүүлсэн буюу хүний биеийн эрүүл мэндэд онцгой хүнд ноцтой хор хохирол учруулсан байвал” арван жилээс дээш хугацаагүй хорих буюу алах ял шийтгээд борлуулсан мөнгөний тооных нь нэг зууны тавиас дээш хоёр дахинаас доош зоосоор яллах буюу эд хөрөнгийг нь хураан авахаар нийлүүлэн шийтгэнэ хэмээн заасан¹⁰ байна.

Үүнээс үзэхэд, БНХАУ-ын Эрүүгийн хуульд уг гэмт хэргийн материаллаг бүрэлдэхүүнтэйгээр хуульчилсан бөгөөд оноох ялыг илүү хүндрүүлсэн, эд хөрөнгө, хууль бусаар олсон орлогыг нь хураах зэрэг нэмэгдэл ял шийтгэхээр хуульчилсан зэрэг нь энэ төрлийн гэмт хэрэгтэй хийх тэмцэл, эрх зүйн орчныг хангалттай бүрдүүлж чадсныг харуулж байна.

Манай улсын хувьд ч энэ гэмт хэргийг материаллаг бүрэлдэхүүнтэйгээр хуульчлах шаардлагатай байгаа нь гэмт хэргийн нөхцөл байдал болон улсын хэмжээний статистик мэдээнээс үзэж болно.

Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн мэдээлснээр 2008-2009 онд Эрүүгийн хуулийн 198 дугаар зүйлийн 198.3-т заасан 8 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд бүртгэгдсэн гэмт хэргээс үзэхэд, хууль бусаар эм импортлох, борлуулсан буюу БНХАУ-аас чанарын шаардлага хангаагүй үр зулбуулах эм оруулж ирж, хууль бусаар худалдаалж байсныг илрүүлсэн байна.

Яаралтай түргэн тусламжийн төвд ирсэн дуудлагын багагүй хувь нь үр зулбуулах эмийг гар дээрээс худалдан авч, ууснаас хордлогод орж, их хэмжээний цус алдсан дуудлага эзэлдэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэхүү дуудлага өсөх хандлагатай байна.

Үр зулбуулах эм ууж хордлогод орсон охид, эмэгтэйчүүд нөхөн үржихүйн эрхтнээсээ салдаг бөгөөд амиа алдах тохиолдол ч цөөнгүй гардаг. Тухайлбал, 2018 оны байдлаар нийт хордлогын дуудлага 79 ирснээс 16 нь үр зулбуулах эмийн хордлого байсан бөгөөд яаралтай түргэн тусламжийн төвд хүнд хордлогын улмаас амь насаа алдсан 13 хүний 2 нь энэ төрлийн эмийн хордлогын улмаас амиа алдсан гэсэн мэдээ байна.¹¹

Жил ирэх тусам энэ төрлийн гэмт хэргийн гаралт нэмэгдэж, гэмт хэргийн улмаас иргэдийн эрүүл мэндэд хөнгөн, хүнд, хүндэвтэр хохирол, хор уршиг учирсаар байхад энэ гэмт хэрэг бүртгэгдэхгүй ямар ч хариуцлага тооцохгүй. Зөвхөн хүний амь нас хохирсон, бусад хүнд хор уршиг учирсан тохиолдолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн зохицуулалттай холбоотой.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраас 115 эм ханган нийлүүлэх байгууллагад хийсэн шалгалтаар 129 зөрчил илэрч, 14 нэрийн 21 цуврал эм, эмнэлгийн хэрэгслээс сорьц

¹⁰ Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрүүгийн хуулийн 141 дүгээр зүйл

¹¹ Яаралтай түргэн тусламжийн төвийн 2018 оны тайлан

авч, МХЕГ-ын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэн улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж, 5 эм ханган нийлүүлэх байгууллагаас улсын бүртгэлд бүртгэгдээгүй, чанарын баталгаагүй, шаардлага хангаагүй 12 нэрийн 2,178,250 төгрөгийн эмийг хурааж, акт тогтоон устгасан байна.¹²

Эндээс үзэхэд, хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх, улсын бүртгэлд бүртгэгдээгүй, хугацаа нь дууссан эмийг худалдах, түгээх явдал газар авсан, эмийн хууль бус бизнес эрчимтэй хөгжиж байгаа болох нь харагдаж байна.

Эрх бүхий байгууллага 2 жилийн дараа гэхэд эмийн хууль бус эргэлтэд тавих хяналтаа бүрэн алдана хэмээн мэргэжилтэн, судлаачид дүгнэснээс үзэхэд, Эрүүгийн хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, ялын бодлогыг чангатгах, мэргэжлийн байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, хяналтын тогтолцоог өөрчлөх зайлшгүй шаардлагатай болохыг илтгэж байна.

Судалгааны үр дүнд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 20.14 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг материаллаг шинжтэйгээр хуульчлах, ялын бодлогыг чангатгах;
- Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх ажиллагаанд тавих хяналтын системийг боловсронгуй болгох, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;
- Гааль, мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтыг сайжруулах, мэргэжлийн микробиологчдоос бүрдсэн лабораторыг ажиллуулах;
- Эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанар, үйлчилгээг худал сурталчилж, иргэдийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаанд хяналт тавих, түүнийг хориглох
- Чанарын шаардлага хангахгүй, хугацаа дууссан, эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн хор хөнөөл, уршгийн талаар иргэдэд ухуулга сурталчилгаа хийх;
- Гар дээрээс эм худалдах, түгээх явдлыг таслан зогсоох;
- Эмийн улсын бүртгэлийн системийг боловсронгуй болгох-зэрэг болно.

Ном зүй

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он
- Эрүүгийн хууль, 2015
- Зар сурталчилгааны тухай хууль, 2002 он
- Эмийн тухай хууль, 1997 он
- БНХАУ-ын Эрүүгийн хууль 2006 он
- Д.Оюунчимэг. Эмийн чанарын хяналт, 1997 он
- Эрүүл мэндийн газрын судалгааны тайлан, 2018
- Яаралтай түргэн тусламжийн төвийн тайлан, 2018 он

---oOo---

¹² Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар тайлан, 2018 он

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ХАМААРАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

*Э.Дашгаадан
Дотоод хэргийн их сургуулий Цагдаагийн сургуулийн
ЦЭЭТ-ийн багш, цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Энэхүү өгүүллээр хагархай цонхны онол болон байнгын үйл ажиллагааны онолын үзэл баримтлалд тулгуулан нийгмийн дунд сөрөг нөлөө үзүүлдэг гэмт хэрэг, зөрчлийн харилцан хамаарлыг тодорхойлох, урьдчилан сэргийлэх зарим арга замын талаар товч авч үзлээ.

Түлхүүр үг: Криминологи, хагархай цонхны онол, байнгын үйл ажиллагааны онол, гэмт хэрэг, зөрчил, шалтгаан нөхцөл.

Оршил

Криминологийн шинжлэх ухааны үндсэн судлагдахуун нь гэмт явдлын шалтгаан нөхцлийг судлан, тодорхой онош, шинж тэмдгийг тогтоосны үндсэн дээр түүнтэй тэмцэх, үр өгөөж бий болгох нь хамгийн чухал зорилготой байдаг. Сүүлийн хэдэн зуун жил судлагдсан 200 гаруй онолууд энэ л зорилгыг агуулан гэмт явдлын шалтгааныг тайлбарлан, зөв механизмыг тогтоохын тулд тоологдошгүй олон модель, загварыг хэрэгжүүлсэн. Үүнээс дүгнэж үзвэл хуулийн хүрээнд тодорхойлсон “гэмт хэрэг” хэмээх харилцаатай зэрэгцэн нийгмийн хэм хэмжээ, нормыг зөрчсөн “зөрчил” гэх ойлголт ч хамаардаг ба криминологи нь дээрх харилцааны шалтгаан, хэрхэн тэмцэхтэй холбоотой өөр өөр талаас дүгнэн маш олон урьдчилан сэргийлэх, тэмцэх стратегийн үр нөлөөг бий болгодог. Манай оронд сүүлийн жилүүдэд гэмт хэргийн түвшин харьцангуй буурсан үзүүлэлттэй байх болов ч зөрчлийн түвшин нэмэгдсээр байгаа юм. Иймээс дээрх хоёр ойлголтын хамаарлыг тодорхойлж, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зарим арга замыг дэвшүүлэх боломжтой.

Үндсэн хэсэг

Товч утгаараа гэмт явдлын шинжлэх ухаан хэмээн тодорхойлж болох криминологи нь гэмт хэрэгт нөлөөлөх биологийн, сэтгэл зүйн, нийгмийн, экологийн болон бусад хүчин зүйл, шалтгааныг судалж, гэмт явдлыг хэрхэн үйлдэгддэг талаар таамаг дэвшүүлж, урьдчилан сэргийлэх арга зүйг бий болгодог шинжлэх ухааны төрөл салбар юм. Садерланд криминологи нь хууль зөрчих үйлдэл, түүнд авч буй арга хэмжээг судалдаг ухаан гэж үзжээ.¹³ Эдгээр шинж чанартай зэрэгцэн криминологи нь гэмт явдлын шалтгааныг шинжлэх ухааны өнцгөөс судлах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн стратегийн болон төрийн бодлогыг чиглүүлэх салбар юм.

Криминологийн судалгаа нь үндсэндээ гэмт явдлын шалтгаан нөхцөл, гэмт үйлдэлд оногдуулах хариуцлага гэсэн хоёр бүлэгт хуваагдаж байдаг.¹⁴ Энэ хүрээнд криминологи нь шүүгч, прокурор, цагдаа зэрэг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ойлголт, өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч, яллах болон цагаатгах системийн бүхий л байгууллага, хэрэгжүүлэгчид, гэмт хэрэг, холбогдогч, хохирогч, иргэдийн нөлөө зэргийг судалдаг нийгмийн ухааныг хамааруулдаг өргөн судлагдахуун юм.

Гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг шалтгаан нөхцлийг судалдаг онолуудаас бүрддэг моделиудаар гэмт явдлын нөхцөл байдал болон ирээдүйд гэмт хэрэг үйлдэх эрсдэлтэй этгээдийн шинж, гэмт хэргийн түвшинг таамаглах боломжтой болдог. Өөрөөр хэлбэл гэмт явдлын онолуудаар гэмт хэрэг, зөрчил үйлдэх магадлал өндөр хүмүүсийн онцлогийг тогтоох, гэмт хэрэг, зөрчлийн хүрэх түвшинг урьдчилан тооцоолох боломжтой.

Гэмт хэргийг ихэнхдээ хуульд нээлттэйгээр хориглосон, ял шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэл хэмээн тодорхойлдог бол зөрчлийг нийгмийн норм, хэм хэмжээний хүрээнд хүлээн зөврөөгдөхөөс гаднах бүх төрлийн үйлдэл, хандлага гэж ойлгож болох юм.¹⁵


¹³ Sutherland, Edwin H. Cressey, Donald R. 1978. Criminology. 10th edition. Philadelphia, New York, San Jose, Toronto; J. B. Lippincott Company. pp. 128

¹⁴ Adler, Freda, Mueller, Gerhard O. W. Laufer, Williams S. 2004. Criminology. 5th edition. Boston. pp. 169

¹⁵ Ш.Нарантуяа, Н.Ганбадрал, Г.Буянхишиг. “Захиргааны зөрчил.” УБ.,1999. 22 дахь тал

Гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял шийтгэл хүлээлгэх нь гарцаагүй байдаг бол зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэл гаргасан тохиолдолд нийгмийн зүгээс жигших болон сөрөг хандлага үзүүлдэг байна.

Гэмт хэрэг болон зөрчлийн харилцан хамаарал



Товчхондоо хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, хандлага гэж тодорхойлж болох зөрчлийг олон эрдэмтэн судлаачид өөр өөрөөр тайлбарладаг. И.Юүжел зөрчлийг “аль нэг нийгмийн тодорхой цаг хугацаан дахь хэм хэмжээний бус харилцаа” гэж тодорхойлсон бол Ф.Ичли “Нийгэм дэх соёлын үр дүнд бий болсон зан заншил, ёс, уламжлал, эрх зүйн дүрэм журамд нийцэхгүй үйлдэл” хэмээн тодорхойлжээ. Сокуллу Акынжи харин зөрчлийг “олон нийтийн хүлээлтээс өөр эсвэл нийгмийн зохимжтой төрлөөс өөр үйлдэл, хандлага” гэж үзжээ.

Гэмт хэргийг хуулийн үүднээс тодорхойлдог бол зөрчилд нийгмийн норм, хэм хэмжээний эсрэг үйлдэл, эс үйлдэл хамаардаг.¹⁶ Дээрх хоёр ойлголт нь өөр өөр хэм хэмжээ, үнэт зүйлээс үйлчлэлдэг ба эдгээр нь нэг нэгэнтэйгээ огтлолцох зохицуулалттай байдаг. Үүнээс үзвэл гэмт хэргийг төрийн зүгээс хориглосон, зөрчлийг бол ард иргэдийн зүгээс хориглосон нийгмийн сөрөг харилцаа гэж тодорхойлж болох юм. Тухайлбал гэр бүлээс гадуур харилцаа үүсгэх нь гэмт хэрэг биш ч гэлээ эхнэр нөхөр бие биенээ хуурч, гэр бүлийн харилцаанд сөргөөр нөлөөлж байгаа нь олон нийтийн зүгээс зохимжтой үйлдэл биш гэдэг нь тодорхой юм. Энэ үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдохгүй ч гэлээ нилээдгүй олон орны шүүхээс гэр бүл салах шалтгаан байж болно гэж зөвшөөрсөн байдаг байна. Эндээс үзэхэд нийгмийн хэм хэмжээ болон үнэт зүйл нь нийгмийн өөрчлөлттэй шууд хамааралтай байна. Хуулиуд ихэвчлэн нийгмийн өөрчлөлтөөс хоцорч үлддэг ба тодорхой хугацаанд шинэчлэх шаардлагатай болдог.

Гэмт хэрэг зөрчлийн дунд огтлолцох хэсгийн хэмжээ нь тухайн улс оронд төр болон ард иргэдийн үзэл санаа бие биетэйгээ хэрхэн зохицож байгааг харуулж буй хэмжээс болж өгдөг. Гэмт хэрэг зөрчлийг тодорхойлж байгаа ойлголтын давхардал бага байгаа бол төр болон ард иргэдийн дунд үл зохицол, зөрчилдөөн их байгааг илтгэдэг ба хоёр ойлголт бие биенээсээ салангид хол байна гэсэн үг юм. Ард иргэдийн зүгээс тааламжгүй гэж үздэг нийгмийн харилцаа хуулинд тусгагдах чадвар нь төр ард иргэдийн үзэл нийлэх түвшинг, тухайн улс орны хууль эрх зүйн зохицуулалт өндөр түвшинд чанартай байгааг илтгэдэг. Энэ хоёр хэм хэмжээний системүүдийн хооронд гарах хийдэл, давхардал нь нийгэмд үл ойлголцол бий болгож болзошгүй. Үүнээс үзэхэд хууль хэрхэн тогтоох, ямар үйлдэл эс үйлдлүүд гэмт хэрэгт тооцогдохыг шийдвэрлэх механизмыг тодорхойлох хоёр үзэл баримтлалыг тайлбарлах боломжтой: 1.Зөвшилцөл /consensus/ ба 2. Зөрчилдөөн /conflict/

Зөвшилцлийн үзэл баримтлалаар хууль бол нийтийн хэв журам, хүмүүсийн нийтлэг эрх ашигт үйлчлэх тохиролцооны шинжтэй байна. Энэхүү үзэл санаа нь нийгэм нэг бүхэллэг бүтэцтэй байх ба дүрэм журмуудын талаар зөрчилдөхгүй, нэг үзэл санаатай, түүнийгээ бүгд дагаж мөрддөг байх явдал юм. Ёс суртахууны үүднээс зохимжгүй байдал, хуулийн зүгээс зохимжгүй байдал хоёрын хооронд ялгаа үүсэх магадлалтай.¹⁷ Энэ ялгаа нь хэдий чинээ бага байна хуулиуд төдий чинээ зөвшилцлийн шинжтэй байна гэж ойлгож болох юм.

Зөрчилдөөний үзэл баримтлалд бол зөвшилцөл гэх ойлголт үгүй. Учир нь хууль болон төрийн эрх мэдэл нийгмийн бүх гишүүдэд адил, эрх тэгш үйлчилдэггүй. Хуулийг шинээр боловсруулах явцыг үзвэл улс төрийн тооцоо, дарангуйлагч бүлэглэлийн эрх ашиг ихээхэн нөлөө үзүүлдэг. Хуулиуд хүн бүрийн нийтлэг эрх ашгийг хамгаалдаггүй бөгөөд нийгэмд үе үе ондууцал төрүүлдэг.

¹⁶ Ж.Долгорсүрэн. “Захиргааны хариуцлага.” УБ. 1998 он. 17 дахь тал

¹⁷ Jenkins, Philip. 1984. Crime and Justice. Issues and Ideas. Belmont, CA; Brooks/Cole Publishing Company, a division of Wadsworth, Inc. pp. 31-35

Эндээс үзэхэд, зөвшилцлийн үзэл баримтлалд гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг шалтгаан нь нийтээрээ хүлээн зөвшөөрсөн дүрэм журмыг дагаж мөрдөөгүй, хэрэгжүүлээгүй этгээдүүдийн үйлдэл, эс үйлдэл гэж үзэж болох атал зөрчилдөөний үзлээр гэмт хэрэг гэж тооцсон эсвэл тооцоогүй үйлдэл эс үйлдэхүй нь нийгмийн тодорхой бүлэг тухайн нийгмийн амьдралын хэв маягт үзүүлэх сөрөг үйлдэл гэж үздэг байна.¹⁸


Гэмт хэрэг болон зөрчлийн харилцан хамаарлыг энэ хүрээнд дүгнэн тайлбарлах боломжтой юм. Зарим судлаачид “Бүх гэмт хэрэг бол зөрчил, харин бүх зөрчил гэмт хэрэг биш” гэх байдлаар гэмт хэргийг зөрчлийн нэгэн категори гэж үздэг.¹⁹ Харин зөрчилдөөний үзлээр хуулиуд үргэлж заяагдмал эрх зүй, нийгмийн хэм хэмжээ, ард иргэдийн сонголтыг түшиглэдэггүй гэж үздэг. Үүнээс үзвэл бүх гэмт хэрэг нь зөрчил биш ч байж болох юм.

Байнгын үйл ажиллагааны онол /Routine activity theory/ буюу Кохен ба Фелсон нарын дэвшүүлсэн энэ ойлголт нь бусад онолоос ялгаатай нь гэмт этгээдтэй холбоотой онцлог шинжийг судлахын оронд цаг хугацаа, орон зайнаас шалтгаалах нөхцөл байдлын хүчин зүйлд анхаарлаа хандуулах нь зүйтэй гэж үзсэн.

Өмнө хийгдэж байсан орон зайнаас хамааралтай гэмт явдлын анализууд нь түүнийг ойлгоход үнэтэй хувь нэмрээ оруулсан болов ч хүнийг болон хүний экологи гэж хэлж болохуйц хүний орчин тойрны зүйлс, хүний амьдралын динамик бүтцийг тооцоолоогүй. Кохен ба Фелсон нар эдгээр дутуу зүйлсэд анализ хийж, гэмт явдлын механизмыг 1. Эрсдэл бүхий этгээд, 2. Боломжит объект, 3. Сул хамгаалалт гэсэн гурван хэсгээс бүрдэнэ гэсэн санааг дэвшүүлжээ.²⁰

Үүнээс дүгнэхэд байнгын үйл ажиллагааны онолоор гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд тухайн үйлдлийг үйлдэхэд цааргалахгүй этгээд, гэмт этгээдийн анхаарлыг татахуйц объект, түүнийг хамгаалах хэн нэгэн байхгүй байх гэсэн тохиолдлуудын давхцал бий болох шаардлага гарч байна. Энэ гурван шинж бол нэгэн бүхэллэг ойлголт болох бөгөөд гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд бүгд байх шаардлагатай. Хэрэв аль нэг нь үгүй бол гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхгүй гэсэн үг юм.

Байнгын үйл ажиллагааны онол



Метрополис хотуудын гэмт хэрэг, зөрчлүүдийн түвшинг авч үзвэл 10 сая хүн амтай Истанбулд жилд 91.693, 3 сая хүнтэй Берлинд 573.000, 1.6 сая хүн амтай Вианад жилд 154.000, 2,8 сая хүн амтай Мадридад 230.000 гэмт хэрэг үйлдэгддэг байна. Эдгээрийг хүн амын тоонд нь харьцуулан авч үзвэл Мадрид 8%, Виана 10%, Берлин 17% байгаа бол Истанбулд 1% гэсэн түвшин гарч байна. Эдгээр нь Европын хамгийн тайван, аюулгүй хотуудын жишээ юм.²¹

¹⁸ Cloward, Richard A. Lloyd E. Ohlin. 1966. *Delinquency and Opportunity; A theory of delinquent gangs*. New York. Free Press. pp. 588-601

¹⁹ Beccaria, Cesare. 1963. *On Crimes and Punishment*, trans. H. Paolucci. Indianapolis, IN; Bobbs-Merill

²⁰ Cohen, Lawrence E. and Felson, Marcus. 1979. 'Social Change and Crime Rate Trends; A Routine Activity Approach.' *American Sociological Review*. Vol. 44, No.4

²¹ International Centre for the Prevention of Crime, U.S. Department of Justice Office of Justice Programs. 2016

Гэхдээ энэ тоон үзүүлэлт үнэн бодитой эсэх нь эргэлзээтэй юм. Учир нь криминологичид “далд нөхцөл байдал”, “хар тоо” зэрэг ойлголтыг байдаг гэдгийг нотолсоор ирсэн. Гэмт хэрэг, зөрчлийн албан ёсны бүртгэлээс авсан тоо мэдээлэл нь гэмт хэрэг зөрчлийн жинхэнэ тооноос хол зөрөх магадлалтай юм.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх стратегийн түвшинд “Хагархай цонхны онол”, “байнгын үйл ажиллагааны онол” зэргийн үзэл баримтлалыг үндсэн суурь болгон авч үзэж болох юм.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ихэвчлэн нийгмийн анхааралыг татсан, хүнд гэмт хэргүүд рүү төвлөрдөг. Дараа нь гэмт хэрэгтнээс урьдчилан сэргийлэх буюу гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй эрсдэлтэй этгээдүүдийг хянах, сургалтын үйл ажиллагаа явуулах зэрэг байдаг. Тухайлбал манай улсын хэмжээнд 2019 оны эхний 11 сарын байдлаар гэмт хэрэг 30.011 байгаа бол өмнөх оны мөн үед нийт 33.880 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 12 хувиар буурсан сайн үзүүлэлттэй байна. Үүнээс хөнгөн хэрэг 9 хувиар, хүнд гэмт хэрэг 21 хувиар буурсан байна. Харин улсын хэмжээнд 2019 оны эхний 11 сарын байдлаар нийт 1.963.882 зөрчил бүртгэгдэж шалгагдсан бол өмнөх оны мөн үед 1.530.349 зөрчил бүртгэгдэж байсан нь 22 хувиар өссөн үзүүлэлттэй байна.²² Бүртгэгдсэн гэмт хэргийн түвшин хэдийгээр буурсан үзүүлэлттэй байгаа ч зөрчлийн түвшин багагүй хэмжээгээр өссөн байна. Ийм тохиолдолд зөвхөн гэмт хэрэг бус зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг ч зохион байгуулж, үр дүнг гэмт хэргийн түвшинтэй харьцуулах шаардлагатай юм. АНУ-ын Чикаго, Бостон зэрэг муж, тэдний тодорхой дүүргүүдэд дээрх онолуудад тулгарлан 2000 оноос өмнө болон дараа хэд хэдэн үечлэлээр үр дүнг тооцсон туршлага байдаг байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго нь тодорхой гэмт хэрэг зөрчил үйлдэгдэх боломж, нөхцлийг үгүй болгох, хамгийн бага түвшинд аваачих явдал юм. Мөн орчин тойрны урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь гэмт этгээд баригдах магадлалыг ихэсгэснээр тохиолдлоор гэмт хэрэг үйлдэх явдлыг багасгах ач холбогдолтой. Энэ нь “хагархай цонх”-ны үзэл буюу орчин тойрны эмх замбараагүй байдал, нийтийн хэв журмыг сахиулсанаар гэмт хэрэг үйлдэгдэх магадлалыг багасгах боломжтой гэсэн үг юм. Гэмт хэргийн бодит үйлдэгдэж байгаа түвшнийг багасгахын тулд зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг идэвхитэй зохион байгуулах нь үр дүнтэй байх боломжтой юм.

Дүгнэлт

Гэмт хэрэг, зөрчлийн түвшин, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх үйл ажиллагаа чухал харилцан хамааралтай байх ёстой. Үүний тулд тодорхой онолд тулгуурлан урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай юм. Эрүүл орчинд амьдрах, тайван аюулгүй байдал нь гэмт явдал үйлдэгдэх боломжит нөхцөл байдлыг бий болгохгүй байх хандлагыг бий болгодог.

Хагархай цонх моделийг нийгэмд хэрэгжүүлэх ач холбогдлыг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий удирдлага, улс төрийн хүрээнд дэмжих шаардлагатай. Жижиг гэлтгүй зөрчлийг шалган шийдвэрлэх, зөрчил үйлдэгдэх боломж нөхцлийг бүрдэхээс сэргийлэх нь цаашлаад гэмт хэрэг үйлдэгдэх эрсдлийг бууруулах боломжтой юм.

Хот суурин газарт оршин суугчдын дунд гэмт хэрэг зөрчлийн талаархи мэдээ мэдээлэл хомс, хотын соёл үнэт зүйл хараахан суурьшиж амжаагүй нийгэмд энэхүү үзэл санаа анзаарахад бэрх байж болзошгүй. Тийм тохиолдолд хагархай цонхны жишээг гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцлийг нийгэмд таниулсан эрэг имиж бүрдүүлэх, түгээх, нийгмийн дунд ухамсарлуулах арга хэмжээг авах нь илүү үр дүнтэй болно.

Санал

1. Зөрчлийг шалган шийдвэрлэх, үйлдэгддэг шалтгаан нөхцлийг тодорхойлон, хяналтын тогтолцоог сайжруулах, урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион явуулах;
2. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх, нийгмийн болон дэмжлэг үзүүлэх эрх бүхий байгуулагаас зөрчлөөс урьдчилан сэргийлэх (проактив) бодлогыг хэрэгжүүлэн зөрчлийн түвшинг багасгах;

²² ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. “Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ”. 2019 оны 12-р сарын 03

3. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заагдсан зөрчлүүдэд арга хэмжээ авч, шийдвэрлэгдэж чадаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, огт арга хэмжээ авагддаггүй, хэрэгждэггүй зөрчлийг шалган шийдвэрлэх арга хэмжээ хэрэгжүүлэх;

4. Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд засаг захиргааны анхан шатны нэгжийн хүрээнд иргэд, байгууллагууд оролцсон олон нийтийн бүлгүүдийг үүсгэж, хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил, ёс суртахууны эсрэг зөрчлүүдийг цаг алдалгүй шуурхай мэдээлэх, мэдээлэл солилцох, түгээх ажилд хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх;

5. Зөвхөн цагдаагийн байгууллагад гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл гаргаж хандах бус бусад зөрчил шалгах эрх бүлхий төрийн байгууллагуудын үйл ажиллагааг эрчимжүүлж, ирж буй дуудлага мэдээлэл, нэг цэгийн үйлчилгээг төрийн болон төрийн бус байгууллагын ажлын уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах зэрэг санал дэвшүүлж байна.

Ном зүй

1. Beccaria, Cesare. On Crimes and Punishment, trans. H. Paolucci. Indianapolis, IN; Bobbs-Merill. 1963
2. Cloward, Richard A. Lloyd E. Ohlin. Delinquency and Opportunity; A theory of delinquent gangs. New York. Free Press. pp. 588-601. 1966
3. Sutherland, Edwin H. Cressey, Donald R. Criminology. 10th edition. Philadelphia, New York, San Jose, Toronto; J. B. Lippincott Company. pp. 128. 1978
4. Cohen, Lawrence E. and Felson, Marcus. 'Social Change and Crime Rate Trends; A Routine Activity Approach.' American Sociological Review. Vol. 44, No.4. 1979
5. Jenkins, Philip. Crime and Justice. Issues and Ideas. Belmont, CA; Brooks/Cole Publishing Company, a division of Wadsworth, Inc. pp. 31-35. 1984
6. Ж.Долгорсүрэн. Захиргааны хариуцлага. УБ. 1998 он.
7. Ш.Нарантуяа, Н.Ганбадрал, Г.Буянхишиг нар. Захиргааны зөрчил. 1999 он.
8. Adler, Freda, Mueller, Gerhard O. W. Laufer, Williams S. Criminology. 5th edition. Boston. pp. 169. 2004
9. International Centre for the Prevention of Crime, U.S. Department of Justice Office of Justice Programs. 2016
10. ЦЕГ-ын Мэдээлэл, судалгааны төв. "Улсын хэмжээнд 2019 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ". 2019 оны 12-р сарын 03

---oOo---

ТЭЭВРИЙН ЦАГДААГИЙН АЛБАНЫ АЛБАН ХААГЧДЫН СЭТГЭЛ САНААНЫ БАЙДАЛ, АЖЛААС ХАЛШРАХ ХАМ ШИНЖИЙН ТҮВШИНГ ТОДОРХОЙЛСОН НЬ

Э.Бямбажаргал

*Дотоод хэргийн их сургуулийн магистрант,
Тээврийн цагдаагийн албаны сэтгэл зүйч, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд тээврийн цагдаагийн албаны алба хаагчдын сэтгэл санааны байдал, ажлаас халшрах хам шинжийн түвшинг тодорхойлсон судалгааны үр дүнг тусгасан бөгөөд судалгааны танилцуулга, судалгааны арга, зүй, аргачлал, алба хаагчдын сэтгэцийн байдлыг тодорхойлсон судалгааны үр дүн, дүгнэлт, санал зэргээс бүрдэж байгаа болно.

Түлхүүр үгс: Бие хүний сэтгэл түгшилт, түгээмэл сэтгэл түгшилт, сандрах эмгэг, нийгмийн айдас, талбайн айдас, стресс, сэтгэл гутрал /уналт/, ажлаас халшрах хам шинж.

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад тээврийн хэрэгсэлийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаатай холбогдон 1 алба хаагчид ногдох тээврийн хэрэгсэлийн тоо нэмэгдэж улмаар алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэж гэр бүл, эрүүл мэнд, өөрийгөө хөгжүүлэх, сурч боловсрох цаг зав багасч байгаа нь албанаас чөлөөлөгдөх, дутагдлаар халагдах зэрэг сөрөг үр дагаваруудыг бий болгож байгаа тул цаашид энэ чиглэлээр судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/121 дугаар тушаалаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж буй “Эрүүл цагдаа хөтөлбөр”-ийн хүрээнд алба хаагчдын сэтгэл санааны ерөнхий байдал, ажлаас халшрах хам шинжийн түвшинг тодорхойлж, сэтгэл засалд хамруулах алба хаагчийг илрүүлэн оношлох, цаашид сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахаар энэхүү судалгааг Цагдаагийн ерөнхий газрын сэтгэл зүйчдийн багийн хамт зохион байгуулав.

Судалгааны зорилго нь Тээврийн цагдаагийн алба хаагчдын сэтгэл санааны байдал, ажлаас халшрах хам шинжийн түвшинг тодорхойлж, сэтгэл засалд хамруулах алба хаагчийг илрүүлэн оношлох, цаашид тэдний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад оршино.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Бие хүний сэтгэл түгшилтийн судалгаа нь алба хаагчдын сэтгэл зүйн сөрөг нөлөөнд өгч буй бие махбодь, сэтгэл зүйн хариу урвалын түвшинг илрүүлэх судалгаа юм. Сэтгэл түгшилт нь аливаа зүйлд яах бол гэж санаа зовних, айдас хүрмээр зүйлсээс шалтгаалан тайван биш болох, сандрах, хүйтэн хөлс гарах зэргээр илэрч, тэдгээр нь тухайн түгшүүрийг үүсгэж буй асуудлыг зохистой шийдвэрлэснээс дээрх шинжүүд арилж үгүй болдог хүнд илэрдэг шинж юм. Гэвч эдгээр шинжүүд бие хүнд хэт хүчтэй илрэх, хавсарч илрэх, яльгүй зүйлд санаа зовних, шалтгаан тодорхойгүй байхад түгших байдал нэлээдгүй илэрч гарах зэргээр хэвийн бус байдал илрэх нь бий. Ингэснээр стрессийг даван туулах чадвар буурч, стрессээ бие даан өөрөө тайлах боломжгүй болох эрсдэл үүсдэг.

Түгээмэл сэтгэл түгшилт нь хүнд эерэг сөрөг гадаад, дотоод хүчин зүйлийн цочроогчийн нөлөөгөөр илрэн гардаг сэтгэл зүйн хариу үйлдэл.

Айдас хүрмээр буюу амь насанд заналхийлж байгаа цочроогчоос хүн өөрийн эрхгүй айдас төрж, вегетатив мэдрэлийн хөөрөлд орохыг айдас гэнэ. Айснаас зүрх хүчтэй цохилох, бие салганан чичрэх, нуруугаар хүйт даах, амьсгаадах зэрэг илрэл бүхий вегетатив мэдрэлийн хөөрлийн шинжүүд илэрдэг.

Гэр бүлийнхээ гишүүдээс бусад хүмүүстэй нийгмийн тодорхой нөхцөл байдалд уулзах буюу харилцах үед тухайлбал олны өмнө үг хэлэх тохиолдолд, тэдэнтэй хамт хоол идэх, дарга удирдлагатайгаа харилцах үед айх эмээх, ичих мэдрэмжүүд хийгээд “нүүр улайх” хөлрөх” айдсууд өөрийн эрхгүй төрж, зүрх дэлсэх, нүүр улайх, бие салганан чичрэх, амьсгаадах зэрэг илрэл бүхий вегетатив мэдрэлийн хөөрлийн шинжүүд үүсэж, бие сэтгэл шаналахыг нийгмийн айдас гэдэг.

Айдас хүрмээргүй орон зай, талбай, гудамж, болон олон хүн цугладаг газар ганцаараа байхад хар аяндаа өөрийн эрхгүй айдас төрж вегатитив мэдрэлийн хөөрөлд орохыг талбайн айдас гэнэ.

Бие хүний сэтгэц, бие махбодод гадаад, дотоод цочроогчийн нөлөөгөөр цусанд ацетилглицерол ихэсдэг нь сэтгэхүйн өвчин бий болох бас нэг шалтгаан гэж үздэг. Алба хаагчид ажил үүргээ гүйцэтгэх явцад ажиллах нөхцөл, ажлын ачаалал, хамт олны уур амьсгал, харилцаанаас тэдний сэтгэл санаа, бие организмд үүссэн дарамт, түүнийг даван туулах, дасан зохицох гэсэн хүч энерги бүхий хариу үйлдлийг ажлын байрны стресс гэж үзэж байгаа юм.

Ажлын байрны стрессийг үүсгэх хүчин зүйлс нь ажил үүрэг гүйцэтгэж байгаа хүнээсээ болон ажлын байрнаасаа шалтгаалан өөр өөр байдаг.

Сэтгэлээр унах, ганьхирах, сэтгэл тавгүй болох, уйтгарлах, түгшүүрлэх, айдас хүрэх зэрэг илрэл бүхий сэтгэлийн сөрөг хөдлөл буюу сэтгэлийн тааламжгүй хөдлөл үүсэхийг сэтгэл унал буюу гутрал гэнэ. Сэтгэл гутрал нь хүнд сэтгэл гутрах шинж, сэтгэцийн үйл ажиллагааны идэвхи буурах шинж, хөдөлгөөний идэвхи буурах шинжүүдээр илэрдэг.

Судалгаанд Тээврийн цагдаагийн албаны нийт **(497 албан хаагч)** хамрагдсан ба албан хаагчдын насны бүтэц, хүйсийн харьцаа албан тушаалын хувьд хамралтыг тодорхойлсон. Тухайлбал, хүйсийн хувьд 88,1 хувь эрэгтэй, 11,9 хувь нь эмэгтэй, боловсролын хувьд 84,5 хувь дээд боловсролтой болохын тодорхойлсон.

Насны хувьд: /Нийт 497 албан хаагчаас 420 алба хаагч нь насаа тодорхойлсон/
18-24 насныхан – 54 албан хаагч
25-29 насныхан – 87 албан хаагч
30-34 насныхан – 167 албан хаагч
35-39 насныхан – 77 албан хаагч
40-44 насныхан – 33 албан хаагч
45-аас насныхан -2 албан хаагч тус тус хариултын хувилбараас сонголт хийсэн.

Ажилласан жил: /Нийт 497 алба хаагчаас 469 алба хаагч нь ажилласан жилээ тодорхойлсон/

1-3 жил – 99 албан хаагч
4-6 жил – 83 албан хаагч
7-10 жил – 142 албан хаагч
11-15 жил– 91 албан хаагч
16-19 жил – 54 албан хаагч
20-оос дээш жил -18 албан хаагч тус тус тодорхойлсон байна.

Судалгаанд Тээврийн цагдаагийн албаны нийт 497 албан хаагч хамрагдсан ба судалгаанд оролцогчдын 88,1 хувь нь эрэгтэй, 11,9 хувь нь эмэгтэй, 84,5 хувь нь дээд боловсролтой, 18 аас 35 хүртэлх насныхан, 1-3 жил буюу цөөхөн жил ажилласан ажилтнаас 20-иос дээш жил ажилласан албан хаагчид гэхчлэн нас, ажилласан жилийн хувьд тус байгууллагад ажиллагсдын төлөөллийг бүрэн хамруулсан.

Албан хаагчийн ажил үүргээ гүйцэтгэх явцад ажиллах нөхцөл, ажлын ачаалал, хамт олны уур амьсгал, харилцаанаас тэдний сэтгэл санаа, бие организмд үүссэн дарамт, түүнийг даван туулах, дасан зохицох гэсэн хүч энерги бүхий хариу үйлдлийг ажлын байрны стресс нь удаан хугацаагаар үргэжилснээс илрэх ажлаас халшрах хам шинжийн түвшинг шинжилж, судалгааны боловсруулалтыг хийлээ.

ДЭД СОРИЛ-1:

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн төвөөс боловсруулан гаргасан сүүлийн 11 жилийн хугацаанд судалгаанд ашиглагдаж буй судалгааны баталгаат, тохироц чанарыг хангахуйц сэтгэл санааны төлөв байдлын арга зүйгээр стрессийн эх суурь болох “Сэтгэлийн түгшилтийг илрүүлэх сорил”, “Стрессийн түвшинг судлан оношлох сорил”, стрессээс үүсэлтэй “Сэтгэл гутралтай эсэхийг оношлох гурвалсан сорил” юм.

ДЭД СОРИЛ-2:

Ажлын орчин нөхцөл нь нийтлэг нөлөөг бүх хүнд нэг зэрэг үзүүлж байдаг хэдий ч түүнийг хүлээн авах хариу үйлдэл үзүүлэх явдал нь хүмүүсийн тэсвэр хатуужил, сэтгэлийн тэнхээ, эрүүл мэнд, мэдлэг туршлага, сэтгэл зүйн хувийн онцлог шинж зэргээс хамааран

харилцан адилгүй ялгаатай байдаг. Ажлын байрны стрессийг үүсгэх хүчин зүйлс нь ажил үүрэг гүйцэтгэж байгаа хүнээсээ болон ажлын байрнаасаа шалтгаалан өөр өөр байдаг. Ажлын байран дахь стресс нь удаан үргэлжлэн ядаргаа болон ажилдаа дур сонирхол нь буурч “Ажлаас халшрах хам шинж” үүсгэж байна.

Ажлаас халшрах хам шинжийн түвшин нь бие бялдрын, сэтгэлийн хөдөлгөөний, бүтээмжийн бууралт гэсэн үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно. Уг судалгаанаас гарсан оноо нь алба хаагчийн мэргэжлийн хам шинжид орсон эсэхийг мэдэх, чиглүүлэх зорилготой. Үүнийг өөрийнхөө амьдралыг хянах шалгуур гэж ойлгож болно. Хэрэв оноо өндөр байвал гэр бүл, сэтгэл судлаач, сэтгэл зүйчээс зөвлөгөө авах замаар хэд хэдэн алхамуудыг хийж болно. Эхний алхам нь алба хаагч өөрт ямар нэгэн асуудал байгаа эсэхийг л мэдэх, юунд анхаарах гэдэг нь чухал юм.

Судалгааг Маслачийн (Maslach Burnout Inventory) хууль сахиулах салбарын алба хаагчдад зориулсан тестийн хувилбараар авч боловсруулалт хийлээ. Бидний ашигласан MBI тест нь:

- Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт (Emotional exhaustion – EE)
- Ажлыг сэтгэлээрээ мэдрэх чадвар буурах (Depersonalization - DP)
- Хувь хүний ур чадварын өөрчлөлт (Personal Accomplishment) гэсэн бүтэцтэй.

Албан хаагчдын сэтгэцийн байдлыг тодорхойлох судалгааны үр дүн

ДЭД СОРИЛ-1-ийн үр дүн:

Сэтгэл түгшилтийн оношлогоо-Судалгаанд нийт **497 албан хаагч** хамрагдаж, хариултыг судалгааны баталгаат чанарыг хангасан гэж үзлээ. Судалгааны боловсруулалтаар 497 алба хаагчаас ямар нэг хэлбэрээр сэтгэл түгшилт илэрдэг 410 алба хаагч буюу 71,4 хувь, үүнээс түгээмэл түгшилт дангаар илэрсэн 155 алба хаагч, түгээмэл түгшүүр нь даамжран сандрах түгшүүртэй 167 алба хаагч, талбайн түгшүүртэй 3 алба хаагч, нийгмийн айдастай 85 алба хаагч байгаа нь тодорхойлогдсон. Харин хавсарсан хам шинж хэлбэрээр сандрах эмгэг, нийгмийн айдастай 30 алба хаагч, сандрах эмгэг, талбайн түгшүүртэй 9 алба хаагч, нийгмийн айдас, талбайн түгшүүр хавсран илэрсэн 8 алба хаагч, сандрах эмгэг, нийгмийн айдас, талбайн түгшүүр хавсран илэрсэн (40) алба хаагч буюу 9,7 хувь буюу 3 буюу 7.5 хувь мөрдөгч, 37 буюу 92,5 хувь нь гудамж зам үүрэг гүйцэтгэж буй замын цагдаагийн зохицуулагч, цагдаа зохицуулагч нар эзэлж байна.

Судалгаанд хамрагдсан алба хаагчдад сэтгэл түгшихэд илрэх 11 шинжүүдээс нийтлэг байдлаар богино хугацааны давталттай илэрдэг байна. Алба хаагчдын дунд сэтгэл түгшилтээс үүсэлтэй бие организмд дараах шинжүүд хурц илэрдэг нийт **33** алба хаагч байна. Үүнд:

- Зүрх дэлсэх, ходоод орчим өвдөх, шээс ойр ойрхон хүрэх гэж – 13,6 хувь
- Шалтгаангүй хөлрөх, толгой эргэх гэж – 10,5 хувь
- Дотор муухай оргих, амьсгал олшрох, үхэхээс айх гэж – 7,9 хувьтай алба хаагчид бусад шинжүүдээс давамгайл бие организмд илэрч байгааг дурьдсан.

Иймд нэн ялангуяа нийгмийн айдас, сандрах эмгэг, талбай айдас хавсран илэрдэг сэтгэл түгшилттэй судлагдсан (40) алба хаагчийг сонгон авч, удирдлага нь сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мөн зайлшгүй чухал зүйл бол сэтгэл түгшилт өндөр илрэлтэй алба хаагчийн стрессийн болон сэтгэл гутралын судалгаанд хэрхэн оношлогдсон эсэхэд анхаарал хандуулах хэрэгтэй.

Стрессийн түвшинг илрүүлэх оношлогоо - Судалгаанд нийт 497 алба хаагч хамрагдсанаас **487 албан хаагчийн** хариулт судалгааны баталгаат чанарыг хангасан. Судалгааны боловсруулалтаар 303 буюу 62.2 хувь нь хөнгөн зэргийн буюу стрессээ өөрөө тайлах боломжтой, Алба хаагчдын 137 буюу 28.1 хувь нь ажлын үүсэлтэй стресст автсан бөгөөд түүнийгээ тайлах арга хэмжээ авахад оройтоогүй байгаа, 43 буюу 8.8 хувь нь өндөр стрессийн илрэлтэй, харин “туйлдал”-ын буюу хэт өндөр стрессийн илрэлтэй байдалд хүрсэн 4 буюу 0.8 хувь нь илэрсэн. Иймд судалгааны үр дүнгээс (47) алба хаагч буюу 9,9 хувь нь стрессийн хоруу чанарыг бууруулах нөхөн сэргээх сэтгэл засалд хамрагдах шаардлагатай нь харагдаж байна.

2018 онд нийт **616** алба хаагчын ажлын стрессийн түвшинг судлахад дараах үр дүн гарсан. Үүнээс үзэхэд нийт асуулгад оролцсон 2 алба хаагч тутмын 1 нь ямар нэг хэмжээгээр ажлын байрны стресст өртсөн байна.

Хөнгөн зэргийн стресстэй **75** буюу **12,1** хувь, ажлын стрессийн илрэлтэй **231** буюу **37,8** хувь, стрессийн нилээдгүй илрэлтэй **251** буюу **40,7** хувь, архаг илрэлтэй **59** буюу **9,5** хувьтайгаар судлагджээ.

Урьд оны мөн үетэй албан хаагчдын стрессийн түвшинг харьцуулан хүснэгтээр харуулбал:

№	Стрессийн илрэн гарч буй хэлбэр	2018 он	2019 он	Өсөлт бууралт
1	Хөнгөн зэргийн стресс	12.1%	62.2%	50.1 хувиар өссөн
2	Ажлаас үүдэлтэй стресст автсан	37.8%	28.1%	9.7 хувиар буурсан
3	Стрессийн өндөр илрэлтэй	40.7%	8.8%	31.9 хувиар буурсан
4	Стрессийн хэт өндөр илрэлтэй	9.5%	0.8%	8.7 хувиар буурсан

Сэтгэл гутралыг илрүүлэх оношлогоо - Судалгаанд нийт **497** алба хаагч хамрагдаж, хариултыг судалгааны баталгаат чанарыг хангасан гэж үзлээ. Судалгааны боловсруулалтаар 433 алба хаагч буюу 87,1% нь хэвийн түвшинд, 26 алба хаагч буюу 5.2% сэтгэл гутралтай гэж, 38 алба хаагч буюу 7,6% нь сэтгэл гутралд орж болзошгүй хэмээн судлагдсан байна.

Албан хаагчдын нойрны хямралыг илрүүлэх оношлогоо - Судалгаанд нийт **497** албан хаагч хамрагдсан ба хариултыг судалгааны баталгаат чанарыг хангасан гэж үзлээ. Судалгааны боловсруулалтаар 234 алба хаагч буюу 47,1% нь хэвийн түвшинд, 195 алба хаагч буюу 39,2% эмгэг биш буюу ажил амьдралын цагийн зохицуулалтад анхаарах гэж, 41 алба хаагч буюу 8,2% нь хямралын илрэлтэй, 27 алба хаагч буюу 5,4% нь нойрны хямралтай хэмээн судлагдсан байна.

Албан хаагчид нойрны зөв хэв маягтай өөрөөр хэлбэл бүрэн сайн нойрсож байх нь ажлын алдаа дутагдал гаргах, ажлын стресс, ядаргаанаас хамгаалдаг. Харин дутуу амрах, нойр муутай байх нь ой тогтоолтод муугаар нөлөөлдөг ба стресст оруулж, хүмүүстэй маргалдах, уурлаж бухимдахад хүргэдэг байна.

ДЭД СОРИЛ-2-ын үр дүн:

Ажлаас халшрах хам шинжийн оношлогоо: Нийт судалгаанд оролцсон 497 алба хаагчаас **472** алба хаагчийн хариултын баталгаат чанарыг хангасан. Үүнээс 26 алба хаагч буюу 5,5 хувь нь ажлаас халшрах хам шинжийн өндөр өөрчлөлттэй, 128 алба хаагч буюу 27,1 хувь нь ажлаас халшрах мэдэгдэхүйц өөрчлөлттэй, 153 алба хаагч буюу 32,4 хувь нь ажлаас халшрах хам шинжийн үзүүлэлт дунд зэрэг, 165 алба хаагч буюу 34,9 хувь ажлаас халшрах хам шинжийн үзүүлэлт бага, ажлаас халшрах хам шинжийн илрэлгүй гарсан байна. Ингэснээр алба хаагчдын 65,1 хувь нь ямар нэгэн байдлаар ажлаас халшрах шинжийн илрэлтэй байна.

Ажлаас халшрах шинж илэрсэн алба хаагчдын халшрах байдлыг бүтцээр нь авч үзвэл:

Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт - сэтгэл хөдлөлийн илрэлгүй болох, сэтгэл гутрал үүсэх, эргэн тойрны зүйлсийг хар бараанаар харах, өөнтөгч, хардамтгай, аливаа шинэ содон зүйлд гайхах, баярлах мэдрэмж буурах зэрэг шинжүүд илэрсэн 11 алба хаагч,

Ажлыг сэтгэлээрээ мэдрэх чадвар буюу харилцаанд идэвхгүй болох, хэлбэрийн төдий харилцах, хамт ажиллагсад болон харилцагчдаас зай барих, амьдралыг хар бараанаар харах, харилцааны болон ёс зүйн доголдол гаргах шинж илэрсэн 10 алба хаагч,

Хувь хүний ур чадварын өөрчлөлт буюу ажил мэргэжилдээ хайнга хандах, өөрийн мэргэжлийн мэдлэг ур чадварт сэтгэл хангалуун бус болох, хэвшмэл сэтгэлгээтэй болох, бие даан шийдвэр гаргах чадвар буурах, өөрийн ажлын үр дүнд итгэлгүй болох, үүссэн асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх чадвар буурах зэрэг шинж илэрсэн 26 алба хаагч тус тус байна.

Урьд оны мөн үетэй алба хаагчдын ажлаас халшрах хам шинжийг харьцуулан хүснэгтээр харуулбал:

№	Стрессийн илрэн гарч буй хэлбэр	2018 он	2019 он	Өсөлт бууралт
1	Сэтгэл хөдлөлийн өөрчлөлт	8	11	өссөн
2	Ажлыг сэтгэлээрээ мэдрэх чадвар	10	10	хэвээр
3	Хувь хүний ур чадварын өөрчлөлт	34	20	буурсан

ДҮГНЭЛТ

1. Тээврийн цагдаагийн алба хаагчдын 9,7 хувь буюу 40 алба хаагч сэтгэл түгшилт хавсарсан илрэлтэй, 9,9 хувь буюу 47 алба хаагч стрессийн архаг илрэлтэй, 5,2 хувь буюу 26 алба хаагч сэтгэл гутралтай 6-аас дээш шинж илэрсэн, 5,4 хувь буюу 27 алба хаагч нойрны гүн хямралтай, 5,5 хувь буюу 26 алба хаагч ажлаас халшрах шинжийн илрэлтэй байгаа нь алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэгдсэн ажил, арга хэмжээг зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

2. Алба хаагчдын ажлаас үүдэлтэй стресст өртсөн, сэтгэл гутралын илрэлтэй, сэтгэл түгшилтийн илрэлтэйгээр судлагдсан нь ажлаас халшрах байдлыг үүсгэж байна.

3. Замын цагдаагийн газрын Дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсийн алба хаагчид ажлаас халшрах байдалд илүү өртсөн.

4. Алба хаагчдын ажлын ачаалал их, уртасгасан цагаар ажиллах, удирдлагын арга барил, хувь хүний өөрийн сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулдаггүй байдлаас шалтгаалан ажлаас халшрах хам шинж үүсэхэд нөлөөлж байна.

5. Мөн замын цагдаагийн алба хаагчдад ажлаас халшрах хам шинж ажлын орчин, нөхцөл нөлөөлж байна гэж үзэв.

САНАЛ

Алба хаагчдын сэтгэцийн байдал, ажлаас халшрах шинжийн бие хүн болон мэргэжлийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөг бууруулах чиглэлээр дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Тээврийн цагдаагийн албаны замын цагдаагийн алба хаагчдын ажлын орчин нөхцөл, бие хүний сэтгэл зүйн онцлог зэргийг харгалзан үзэж түүнд чиглэсэн “Сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” ажлын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх;

2. Ажлын байранд тогтмол цагт дасгал хөдөлгөөн хийх, завсарлага бий болгох;

3. Алба хаагчдын сонирхлын хүрээг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл хүргэж, соёл урлагийн арга хэмжээ зохион явуулах, хамруулах;

4. Сэтгэл хөдлөлийн өөрчлөлтөд алба хаагчдын гэр бүлийн болон хувь хүний хувьд асуудал үүссэн эсэхийг судлан, тухай бүр дэмжлэг үзүүлж байх;

5. Хувь хүний ур чадварын өөрчлөлтөд өртсөн алба хаагчдыг давтан сургалтад хамруулах, мэргэжлийн үнэт зүйлийн чиг баримжаа тодруулах судалгаа авах, холбогдох сургалт явуулах зэрэг болно.

---oOo---

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХҮН БАРЬЦААЛАХЫН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ

Д.Сундуйсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн профессор,
цагдаагийн хурандаа

Хураангуй: Түүхэн цаг хугацааны туршид дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнууд хүн барьцаалах гэмт явдалтай олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалтаар тэмцэж ирсэн бөгөөд нэгдсэн үндэстний улс түмний хамтын ажиллагаа, хэвийн харилцаа, аюулгүй байдлыг хангах, хүн барьцаалахын эсрэг гэрээ хэлэлцээрийг харьцуулан судлахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Эх сурвалж, терроризм, боолын худалдаа, ёс заншил, барьцаа, хүн барьцаалах гэмт явдал, гэрээ /конвенц/

Удиртгал

Сүүлийн үед дэлхий нийтийн анхаарлыг татаж, ихээхэн айдас түгшүүрийг төрүүлж буй сөрөг үзэгдэл бол олон улсын шинжтэй гэмт хэрэг, тухайлбал алан хядах үйлдлийн илрэл болсон терроризм, хүн барьцаалах, агаарын тээврийн онгоц барьцаалах явдал өсч байгаатай холбогдуулан түүнтэй тэмцэхийн тулд олон улсын гэрээ, хэлэлцээр /конвенц/ байгуулах нь зүй ёсны хэрэгцээ шаардлага юм.

Хүн барьцаалах явдалтай тэмцэж ирсэн олон улсын эрх зүйн акт

Орчин үеийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа нь эрүүгийн гэмт хэрэг болон олон улсын шинжтэй гэмт хэрэгтэй тэмцэх тэмцлээс бүрдэж байна.

Урьд нь хууль зүйн шинжлэх ухаан болон практикт “Олон улсын шинжтэй гэмт хэрэг”-ийн тухай бүрэн гүйцэд тодорхойлолт байгаагүй. Энэ тухай оновчтой тодорхойлолтыг профессор И.И.Карпец өгчээ. Үүнд: “Олон улсын шинжтэй гэмт хэрэг гэдэг нь олон улсын гэрээ хэлэлцээрт заасан, хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт хамаарахгүй гэвч улс хоорондын хэвийн харилцаанд халдаж, дэлхий нийтийн хамтын ажиллагаа, салбар дундын харилцаа (эдийн засаг, нийгэм, соёл, хөрөнгө гэх мэт) ... нд хохирол учруулж буй, тогтоосон хэм хэмжээний дагуу шийтгэлтэй, гэрээ хэлэлцээр ёсоор үндэстний эрүүгийн хууль тогтоомжидоо хуульчлан тогтоосон байх явдал юм.”²³

И.И.Карпедын үзэж байгаагаар, дээрх гэмт хэргийн олон улсын шинж чанар нь олон улсын хэлэлцээрт заасан, олон улсын харилцааны салбарт хохирол учруулж байгаагаар тодорхойлогдох бөгөөд үндэстний эрүүгийн хууль тогтоомжидоо заавал тусгаж, шийтгэлийг ногдуулдаг байна.

Энэ гэмт хэргийн олон улсын шинж чанарыг олон улсын харилцааны салбарт хохирол учруулдаг гэхээсээ илүү “гадаадын элемент”-тэй холбоотой үүсдэг, нарийн төвөгтэй эрүүгийн эрх зүйн харилцаа, өөрөөр хэлбэл, гэмт хэргийн субъект нь “гадаадын”, гэмт хэргийн субъект объект нь гадаад орны нутаг дэвсгэр дээр, үйлдэл нь хэд хэдэн хууль эрх зүйг /хоёр ба түүнээс дээш үндэстний болон олон улсын/ зөрчсөн байдгаар тодорхойлогддог байна.

Дээр дурдсанаас үзэхэд олон улсын шинжтэй гэмт хэрэг нь олон улсын ба улс үндэстний эрх зүйн журамд халдаж байгаа, төр, олон улсын байгууллага, албан тушаалтан, бие хүн хуулийн этгээд тэдгээрийн өмч хөрөнгө, амьдралын сайн сайхан, хүний үнэт зүйл, эрх, эрх чөлөөнд нь хор хохирол учруулж байгаа төрийн /улсын/ хууль тогтоомжид заасан, эрх зүй зөрчсөн, ээдрээ төвөгтэй, нийгэмд аюултай үйл ажиллагаа /үйлдэл/ гэж үзэж болох юм.

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 1979 оны 12 дугаар сарын 17-нд батлагдсан “Хүн барьцаалахын эсрэг” олон улсын Конвенцид хүн барьцаалах нь олон улсын гэмт хэргийн бие даасан төрөл болохыг анх удаа заажээ.

Урьд нь баталсан олон улсын гэрээ, конвенциудад боолчлол, алан хядах ажиллагаа, агаарын хөлөг барьцаалах, бусад олон улсын шинжтэй гэмт хэргийг хамааруулсан байна.

²³ Карпец И.И.Преступления международного характера. М., 1979. С. 40

Тухайлбал; 1926 оны 9 сарын 25-ны өдөр Женев хотод боолчлолтой холбоотой Конвенцид гарын үсэг зурсан бөгөөд хожим нь нэмэлт оруулжээ. Энэхүү конвенцийн эх сурвалж нь дараахь олон улсын актууд:

1. 1889-90 оны Брюсселийн бага хурлын ерөнхий акт, энэхүү актанд гарын үсэг зурсан улс орнууд Африкт хийгддэг боолын наймааг эцэс төгсгөл болгохыг хатуу мэдэгджээ.
2. 1919 оны Сен Жерменийн конвенц, энэхүү конвенцид гарын үсэг зурсан улс орнууд хуурай газар болон далай тэнгист бүх хэлбэрийн боолчлол, боолын наймааг бүрэн устгахаа илэрхийлжээ.
3. 1924 оны 6 дугаар сарын 12-ний өдөр Үндэстнүүдийн Холбооны Зөвлөлөөр томилсон Боолчлолын түр хорооны илтгэл

Сен-Жерменийн конвенцид гарын үсэг зурсан улсуудаас боолчлол, боолын худалдааны талаар гаргасан зорилтуудыг дэлхий даяар хэрэгжүүлэх үүднээс Брюсселийн актын дагуу хэрэгжүүлэх ажлыг дуусгавар болгон хэрэгжүүлэхийг эрмэлзэн, энэхүү конвенцид тусгагдсан заалтуудаас илүү нарийвчилсан заалт бүхий хэлэлцээр байгуулах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч, 1926 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай” Женевийн конвенци батлагдсан байна.

Энэхүү Конвенцид “Боолчлол гэж өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрх мэдлийг хүн дээр хэрэгжүүлсэн байдал буюу нөхцлийг ойлгоно”, “боолын худалдаа гэж хүнийг боол болгох зорилгоор олзлох, олж авах буюу эрхэндээ оруулах бүх үйлдэл, боолыг худалдах буюу солих зорилгоор түүнийг олж авахтай холбогдсон бүх үйлдэл, худалдах буюу солих зорилгоор олж авсан боолыг худалдах буюу солих замаар эрхэндээ оруулах бүх үйлдэл, бүхэлдээ боолыг тээвэрлэх, эсхүл худалдах бүх үйлдэл хамаарна”²⁴ гэж боолчлол, боолын худалдаа гэдгийг анх удаа тодорхойлжээ.

Конвенцийг хүлээн зөвшөөрч хэлэлцэн баталсан талуудын хүлээсэн гол үүрэг бол: Боолын худалдааг хориглох түүнээс урьдчилан сэргийлэх, боолчлолын бүх хэлбэрийг богино хугацаанд бүрмөсөн устгахыг чармайх, боолын худалдаа болон боолчлолыг устгахын тулд харилцан бие биедээ дэмжлэг үзүүлэх явдал гэж үзжээ.

1956 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр “Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс, заншлыг устгах тухай” нэмэлт конвенц батлагдаж, 1957 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болжээ.²⁵

Энэхүү конвенцид оролцогч улс бүр, эрх чөлөө бол хүн бүрийн төрөлхийн заяагдмал эрх мөн гэж үзээд, (Нэгдсэн Үндэстний улс түмэн дүрэмдээ хүн төрөлхтний үнэ цэнэ, нэр төрд итгэх итгэлийг бататгасныг дурдаж) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас зарлан тунхагласан Хүний эрхийн түгээмэл тунхагалд боолчлол буюу эрх мэдэлгүй байдалд хэн ч нэрвэгдэх ёсгүй бөгөөд боолчлол, боолын худалдааг бүх хэлбэрээр нь хориглоно гэж заасныг анхааралдаа авч, Энэхүү Конвенциор 1926 оны “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай” Женевийн конвенцид заасан боолчлол, боолын худалдаа гэсэн тодорхойлолтыг хөндөхгүйгээр зарим ойлголтыг өргөжүүлэн нэмэлт болгож, дараах ёс болон заншлыг бүрэн халах буюу устгах шаардлагатай арга хэмжээ авахыг тусгасан байна.

а/Өрөнд баригдаж боолчлогдсон, өөрөөр хэлбэл өртэй хүн өөрийнхөө, эсхүл өөрөөсөө хараат хүний үйлчилгээгээр өрөө төлөх үүргээ биелүүлэхтэй холбоотойгоор үүссэн барьцааны байдал буюу нөхцөл, хэрэв тэрхүү үйлчилгээг зохих ёсоор үнэлсэн үнэлгээ нь уг өрийн төлөөсөнд тооцогдохгүй, эсхүл тэрхүү хөдөлмөрийн шинж чанар, үргэлжлэх хугацаа нь тодорхой бус бол,

с/ Дараахь үйлдлийг зөвшөөрсөн аливаа ёс, заншил:

а)эмэгтэй хүнийг мөнгө болон биет эд зүйлийн оронд төлөх болзолтойгоор өөрийнх нь зүгээс татгалзах эрхгүйгээр түүний эцэг, эх асран хамгаалагч, гэр бүл, эсхүл бусад хүн, эсхүл бүлэг хүмүүсээс эхнэр болгож өгөхийг амласан эсхүл өгсөн.

б) эмэгтэйн нөхөр, түүний гэр бүл, эсхүл овгийнхон нь тухайн эмэгтэйд өөр хүнд үнэтэй эд зүйлсийн оронд буюу бусад хэлбэрээр шилжүүлэн өгөх эрх эдэлдэг байх.

с) нөхрийг нь нас барахад бэлбэсэн эхнэрийг бусдад өвлүүлэн өгөх.

²⁴ СССР и международное сотрудничество в области прав человека. Документы и материалы МИД СССР. М., 1989. С. 105-106.

²⁵ Международное сотрудничество государств по борьбе с преступностью: Учебно-методическое пособие. М., 1982. С. 124

d)18 нас хүрээгүй болон бага насны хүүхдүүдийг ашиглах буюу тэдний хөдөлмөрийг мөлжмэл зорилгоор эцэг эхийнх нь аль нэг, эсхүл хоёул, эсхүл асран хамгаалагч нь тэднийг шан харамжтай буюу харамжгүйгээр бусдад өгдөг аливаа ёс буюу заншил.²⁶

Анхны эрх зүйн баримт болох 1937 оны “Терроризмаас урьдчилан сэргийлэх болон ял оногдуулах тухай” Женевийн Конвенцид “хүн барьцаалах” гэсэн нэр томъёог анх эхлэн нэрлэн заажээ. Энэ Конвенци оршил болон 29 зүйлтэй, терроризмын үйлдлийн объектыг бүрэн дүүрэн, өргөн хүрээтэй тодорхойлжээ. Конвенцид олон улсын алан хядах явдал /терроризм/-ын ойлголтыг томъёолсон, терроризмтай тэмцэх механизмыг боловсруулсан, үндэсний болон олон улсын түвшинд хэрэглэгдэх журам, үйл ажиллагаа Конвенцид элсэн орох процедурыг тогтоосон юм. Харин улс төр ба хууль зүйн шалтгаанаар хүчин төгөлдөр болоогүй гэвч олон улсын эрх зүйн эсрэг шинжтэй гэмт хэрэг ба олон улсын алан хядах ажиллагааг буруушааж байсан нь одоо ч ач холбогдлоо алдаагүй байна.

Энэ нь сүүлдээ хүн төрөлхтний аюулгүй байдал, дэлхий нийтийн эсрэг гэмт хэргийн тухай хууль, эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулахад ашиглах суурь нь болсон гэж үзэх үндэстэй юм. Түүнчлэн агаарын хөлгийг барьцаалахын зэрэгцээ хүн барьцаалах, олон улсын хамгаалалтанд байдаг хүн, дипломат төлөөлөгчийн халдашгүй байдал, харилцаанд хүч хэрэглэн халдах явдал терроризмын төрлүүдийн нэг юм.²⁷

Иргэний нисэх хүчин, олон улсын харилцааны эсрэг агаарын хөлгийн бүхээгт үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо өсч байгаатай холбогдуулан улс орнууд 1963 онд “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай” Конвенцийг Токио батлан гаргасан байна.

Энэ Конвенциор агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг тодорхойлжээ.

Энэ гэмт хэргийг үйлдэхээр завдсан, үйлдсэн гэх үндэслэл байвал агаарын хөлгийн дарга, агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүсийн аюулгүй байдлыг хамгаалах, нисэх багийн гишүүд болон зоригчдийн дэмжлэгийг авах, гэмт этгээдийн эрх чөлөөг нь хязгаарлах, саатуулах, агаарын хөлгөөс буулгах, эрх бүхий байгууллагад шилжүүлэх, зэрэг бололцоотой бүхий л арга хэмжээг авахыг тусгажээ.

Конвенцийн 11 зүйлийн 1 дэх хэсэгт: “Агаарын хөлгийн бүхээгт байгаа этгээд хүч хэрэглэн, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэн нислэгт буй агаарын хөлгийн удирдлагад хууль бусаар саад учруулах, удирдлагыг булаан авах буюу хууль бус бусад үйлдэл үйлдсэн буюу үйлдэхийг завдсан тохиолдолд хэлэлцэн тохирогч улсууд агаарын хөлгийн удирдлагыг түүний хууль ёсны даргад эгүүлэн өгөх буюу түүний хяналтанд байлгахад шаардлагатай бүхий л арга хэмжээ авна”²⁸ гэжээ. Харилцан тохирогч улс орнууд дээрх арга хэмжээг авахын зэрэгцээ сэжигтэн этгээдийг шилжүүлэн авч, албадан саатуулан, цагдан хорьж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахаар тодорхой зохицуулсан байна.

1970 онд Гаагийн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенци батлагдсан. Хэлэлцэн тохирогч улс бүр “агаарын хөлгийг хууль бусаар булаах” үйлдэл гаргасан тухайн этгээдэд хүнд ял оногдуулах үүрэг хүлээсэн.

Мөн 1971 онд Монреалийн “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” конвенци батлагдсан.

Конвенцийн 7 дугаар зүйлд: Нутаг дэвсгэр дээр нь сэжигтэн этгээд илэрч тогтоогдсон хэлэлцэн тохирогч улс түүнийг шилжүүлэн өгөхгүй байвал гэмт хэрэг түүний нутаг дэвсгэр дээр гарсан эсэхээс үл хамааран яллуулахаар өөрийн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ. Тэрхүү эрх бүхий байгууллага нь тухайн улсын хуульд заасны дагуу ноцтой шинж агуулсан ердийн хэрэгтэй адил журмаар шийдвэрлэнэ” гэж заажээ.

Ийм байдлаар хэлэлцэн батлагдсан олон улсын конвенци нь иргэний нисэх хүчний эсрэг үйлдэж буй гэмт хэргийн ангилалд хамаарч буй нөхцөл байдлыг арилгахын тулд бие биендээ дэмжлэг үзүүлэх, зохих ёсны хариуцлагын зарчим бусад арга хэмжээг хэрэгжүүлэх, олон улсын терроризмын аюултай төрөл буюу хамгийн түгээмэл энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орны хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлжээ.

²⁶ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. Уб., 2015. 306 дахь тал.

²⁷ Советский Ежегодник международного права. М., 1989. С. 124

²⁸ Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. Уб., 2015. 306 дахь тал.

Гэвч олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг, нисэх буудалд үйлдэгдэж буй хүч хэрэглэсэн явдлыг таслан зогсоох асуудал олон улсын эрх зүйн зохицуулалтгүй үлдсэн байна.

Тиймээс “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” Монреаль хотноо 1971 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр үйлдсэн Конвенцийн олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протокол 1988 оны 2 дугаар сарын 24-ний өдөр баталж, 1989 оны 8 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэхүү нэмэлт протоколд “Оролцогч улсууд олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүмүүсийн аюулгүй байдалд аюул занал учруулж буй, учруулж болзошгүй, эсхүл эдгээр нисэх буудлын аюулгүй ажиллагаанд саад учруулж буй хүч хэрэглэсэн хууль бус үйлдлүүд нь эдгээр нисэх буудлын аюулгүй ажиллагаанд итгэх дэлхийн ард түмний итгэлийг бууруулж, бүх улсын хувьд иргэний нисэхийг аюулгүй, журамтай удирдахад саад болж байгаа гэж үзэж, ийм гэмт хэрэг үйлдэх нь олон улсын хамтын нийгэмлэгийг ноцтой түгшээж байгаа гэж үзэн, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэхийн тулд тууштай арга хэмжээ авах шаардлагатай болсныг хэлэлцэн тохирсон тухай” заажээ.

Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай конвенцийг НҮБ-ын Ерөнхий ассамблей 1973 оны 12 дугаар сарын 14-ны өдөр баталж, 1977 оны 2 дугаар сарын 20-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэ конвенцид “тусгай хамгаалалт”, “сэжигтэн этгээд” /тухайн гэмт этгээд/ гэсэн ойлголтыг гарган тавьж, олон улсын хамгаалалтанд буй хүн гэдгийг тодорхойлсон. Конвенцийн 4-11 дүгээр зүйлд тогтоосон хэм хэмжээ, үндсэн зарчмын хүрээнд олон улсын алан хядах ажиллагаа үйлдэж буй этгээдэд ял шийтгэл оногдуулж байх зарчмыг хангах, тэдгээртэй холбоотой зүйлүүд хамаарсан байна.

1973 оны Конвенцийг нэгтгэн дүгнэж үзвэл 1937, 1971 оны конвенцийн олон зүйл заалтыг ашигласан байна.

1975 онд Европын зөвлөлийн оролцогч улсын Хууль зүйн сайд нарын Европын хороо олон улсад хүч хэрэглэсэн янз бүрийн хэлбэрийн гэмт явдалтай холбоотой асуудлуудыг судлан үзэж, энэ асуудлаар конвенцийн төсөл боловсруулах санал дэвшүүлсэн байна.

1976 оны арван нэгдүгээр сарын 10 өдөр Европын Холбооны Сайд нарын зөвлөл терроризмтай тэмцэх тухай Европын конвенцийн баримтыг хүлээн авч, 1977 оны нэгдүгээр сард батласнаар уг баримт 1978 оны наймдугаар сарын 4 өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн. 16 зүйл бүхий энэ баримт бичиг нь олон улсын терроризмтай тэмцэх үйл ажиллагаанд улс хоорондын хамтын ажиллагааны талаар байгуулсан бусад гэрээ хэлэлцээрийн дунд онцгой байр суурь эзэлдэг.

Террорист хүчирхийлэл, үйлдлийн өргөн хүрээг тодорхойлсон нь Конвенцийн онцлог юм. Тэдгээрт иргэний агаарын эсрэг, нисэх хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэргүүд, олон улсын хэмжээнд хамгаалуулах эрхтэй этгээдийн эрүүл мэнд, эрх чөлөөнд халдсан явдал, хүн барьцаалах эсхүл санаандгүй байдлаар хүний эрх, эрх чөлөөнд халдах түүнчлэн бусдад аюул учруулах тэсэрч дэлбэрэх зэвсэг хэрэгсэл ашиглах явдал хамаарахаар зохицуулсан байна.

Уг Конвенци *aut dedere, aut iudicare* гэх зарчимд тулгуурласан, түүнчлэн хэрэгтнийг шилжүүлэн өгөх үйл ажиллагаа нь террорист акт үйлдсэн этгээдүүд ял шийтгэлээс зайлсхийхээс урьдчилан сэргийлж чадсан үр дүнтэй хэрэгсэл болсон байна.

Хүн барьцаалах явдалтай тэмцэх тухай дээр дурьдагдсан конвенциудаас гадна дайны үед эдгээр гэмт хэрэг үйлдэхийг хориглосон конвенциуд байжээ.

1949 онд Женевт олон улсын 4 конвенц батлагдсан. Үүнд: “Дайны талбарт байгаа зэвсэгт хүчний шархтан, өвчтөний нөхцөл байдлыг сайжруулах тухай” Конвенци, “Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнээс сүйрсэн хөлөг онгоцноос хохирсон этгээд, өвчтөн, шархтаны нөхцөл байдлыг сайжруулах тухай” Конвенц, “Олзлогдсон цэргийг харж хандах тухай” Конвенц, “Дайны үед иргэний хүн амыг хамгаалах тухай” Конвенциуд²⁹ юм. 1977 онд эдгээр конвенциудад нэмэлт протокол батлагдсан.

Тухайн цаг үед хүнийг газар сайгүй барьж, хорьж, алахаар эрүү шүүлт тулгах, ташуурдаж яллах, гэмтэл бэртэл учруулах, хүний эрхэм чанарыг доромжлох, хүнийг барьцаанд авах, зохих ёсны шийдвэргүйгээр хоморголон яллаж байсан, эдгээр гэмт үйлдлийн бүх төрлүүд нь харгис хэрцгий, бусдыг басамжлан доромжилсон хандлагатай байв.

²⁹ Женевские конвенций о защите жертв войны. М., 1954. С. 12

1949 оны Женевын конвенциуд болон 1977 онд баталсан Нэмэлт протокол баримтууд байлдаж буй талууд олзлогдсон, далайд онгоцны сүйрэлд нэрвэгдсэн, шархадсан, өвчтөн зэргийн хүмүүст хандах хүмүүнлэг ёсны хэм хэмжээг тусгасан байна. Дээрх олон улсын акт баримтад тусгаж зааснаар хүн барьцаалах хүнд ноцтой гэмт хэрэг үйлдэхийг хориглосон байгаа нь чухал ач холбогдолтой юм. Хүн барьцаанд олзлон авах үйлдэл олон улсын зарим эрх зүйн баримт бичигт³⁰ олон улсын гэмт хэрэгт тооцогдож байгаа боловч практик дээр энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээнүүд хангалтгүй байгаа нь илт харагддаг.

Олон улсын төвшинд хүн барьцаалах үйлдлийг бие даасан гэмт хэрэгт тооцох, түүнтэй тэмцэхэд чиглэсэн нэн яаралтай арга хэмжээг боловсруулан батлахад хүргэсэн эмгэнэлтэй явдал бол 1972 оны есдүгээр сарын 5-ны өдөр Мюнхены XX Олимпын наадмын үед гарсан “Хар есдүгээр сар” гэх, экстремист бүлгийн гишүүд тамирчдыг барьцаалсан хэрэг юм.

“Террористууд барьцааны хүмүүстэй хамт арабын аль нэг улс руу хамт нисэх онгоц гаргаж өгөхийг шаардсан. Террористууд, ХБНГУ-ын цагдаагийн байгууллага нар зөвшилцөлд хүрсэний дараа террористууд болон барьцааны хүмүүсийг Мюнхен хотоос 25 км байрших Фюрстенфельдруке дэх нисэх буудал руу хоёр вертолёт онгоцоор хүргэсэн, тэдгээрийг тэнд “Боинг” онгоц хүлээж байв. Вертолёт онгоц газардахад отолтод байсан цагдаагийн мэргэн буучид террористуудын зүг гал нээв. Буудалцааны үед террористууд барьцааны хүмүүс, вертолётын нэг нисгэгч мөн цагдааг бөмбөг дэлбэлэн амийг нь хөнөөжээ. Энэ ажиллагааны дүнд 16 хүн амиа алдсан ба тэднээс 11 нь олимпын тэмцээнд оролцож байсан тамирчид байв. Бавари мужийн Дотоод хэргийн сайд отолт зохион байгуулсан шалтгаанаа тайлбарлахдаа нисэх буудалд ирэнгүүт нь барьцааны хүмүүсийг алж болзошгүй гэж Германы албаны хүмүүс болгоомжилж байсан учир тэдгээрийг онгоцонд суухаас нь өмнө цагдаа нар аврахыг оролдсон гэжээ”.³¹

Энэ гэмт хэрэг гарсантай холбогдуулан НҮБ-ийн гишүүн орны хувьд ХБНГУ Хүн барьцаалах үйлдэлтэй тэмцэх Конвенци санаачлан боловсруулсан. НҮБ-аас ХБНГУ-ын энэхүү санаачилгыг дэмжсэн бөгөөд Ерөнхий Ассамблейн 31\103 баримт бичгийн дагуу 1976 оны арванхоёрдугаар сарын 15 өдөр Хүн барьцаалах үйлдэлтэй тэмцэх олон улсын конвенци боловсруулах Тусгай хороог байгуулсан юм.

Уг хороог байгуулсан нь НҮБ-ийн гишүүн орнууд хүн барьцаалах асуудалд хэр сэтгэл зовниж буйг харуулжээ. Олон тооны эмгэнэлт үйл явдал гарч байсан ч тэдгээр харгис үйлдлийг зохион байгуулагчдын эсрэг олон улсын хэмжээнд нэн яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулсан юм.

Улс төрийн зорилгоор хүн барьцаалах гэмт үйлдэл ямар ч гэм буруугүй хүмүүсийн амь насанд заналхийлж, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулан, төр засгийн хүчийг сулруулж буй үйлдлийн эсрэг тухайн улс орны зүгээс хүмүүнлэг ёсыг дагаж хууль зөрчин арга хэмжээ авахад хүргэж байна.

Аль ч орны дотоодын хууль тогтоомжоор хүний амь хөнөөх, агаарын хөлгийг эзлэн авч барьцаалах, хүүхэд хулгайлах, хүний эрх чөлөөг хууль бусаар хасах, дээрэмдэх зэрэг хэргүүд нь хүнд ноцтойд тооцогддог, хатуу шийтгэлтэй гэмт хэрэг юм. Хүн барьцаалах нь мөн адил олон улсын эрх зүйгээр байж болшгүй гэмт хэрэг, ихэнх тохиолдолд үндэсний эрүүгийн эрх зүйгээр хангалтгүй зохицуулагдсан байдаг, ялангуяа нэг улс оронд хүн барьцаалж, амийг нь хороосон этгээд өөр улс орноос орогнол олдог явдлыг таслан зогсоох шаардлагатай байгааг Канадын төлөөлөгч Вонг онцлон тэмдэглэжээ.³²

Хүн бүр Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан амьд явах, эрх чөлөөтэй байх, хувийн аюулгүй байдлаа хамгаалах эрхтэй гэсэн зарчмыг баримтлах шаардлагатай. Хүн барьцаалах явдал нь гэм буруугүй хүмүүсийн амь насанд заналхийлсэн гэмт үйлдэл тул түүнтэй тэмцэхгүй нэг ч улс орон байх боломжгүй юм.

ХБНГУ, Францын төлөөлөгчдийн конвенцийн төслийн үндэс нь “ял оноо эсвэл хүлээлгэн өг” гэсэн зарчим юм. Олон улсын хэмжээнд үр дагавар үүсгэдэг хүн барьцаалах явдал нь хүмүүнлэгийн эрх зүйг зөрчөөд зогсохгүй хүний эрхийг зөрчиж, улс хоорондын найрсаг харилцааг бусниулдаг. Конвенцийг боловсруулах үед гэм буруугүй золиос болж болзошгүй хүмүүсийн аюулгүй байдлын тухай асуудал голлох байр суурийг эзлэх ёстой гэдгийг бүгд

³⁰ Женевские конвенции 1949 года и Дополнительные протоколы к ним 1977 года; Европейская конвенция 1976 года.

³¹ Советский спорт. 1972. 7 сент.

³² ООН.Генеральная Ассамблея. 5-е заседание. Специальный комитет. 5 августа 1977 г. А/АС. 188/5. С. 6.

хүлээн зөвшөөрсөн. Мөн түүнчлэн, барьцааны хүн гэдэг ойлголтыг урьдчилсан тодорхойлох шаардлагатай эсэх талаар хэлэлцсэн. Олон хүмүүсийн дэмжлэгийг авсан боловч Италийн төлөөлөгчдийн үзэж байгаагаар, барьцааны хүн гэсэн ойлголтыг урьдчилсан тодорхойлох шаардлага байхгүй, учир нь золиос боллогчийн тодорхойлолт нь гэмт хэргийн тодорхойлолтоосоо автоматаар урган гарч байгаа тухай илэрхийлсэн байдаг.

Тусгай хороо гурван удаа чуулган хийж /1977, 1978, 1979 он/ ажлын явцад 35 орны төлөөлөгчид конвенцийн үндсэн зүйл заалтуудыг хэлэлцсэн байна.

1979 оны 12 сарын 17-ны өдөр Нью-Йорк хотод НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 34-р чуулганаар 34/146 тоот тогтоолыг баталж, Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын конвенцид гарын үсэг зурснаар, хэрэгжүүлэх нөхцөл боломжийг нээж өгсөн.

Конвенц нь удиртгал ба 20 зүйлээс бүрдсэн. Удиртгалд конвенцид оролцогч улс орнууд Нэгдсэн үндэстний ард түмнүүд хоорондын хамтын ажиллагаа, найрсаг харилцаа, аюулгүй байдал, олон улсын энх тайвныг хангахад чиглэгдсэн НҮБ-ын дүрмийн зорилго, зарчмыг дэмжихийг онцлон дурьдсан. НҮБ-ын дүрэм болон олон улсын эрх зүйн зарчмын тухай тунхаглалд ард түмнүүдийн тэгш эрх, тусгаар тогтнох зарчмыг бататгасан.

Удиртгалд мөн энэхүү конвенцид оролцогч орнууд хүний эрхийн түгээмэл тунхаглал, иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактад заасан хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, аюулгүй байх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрсөн, мөн хүн барьцаанд авах нь олон улсын хамтын нийгэмлэгийн санааг ихээхэн түгшээсэн гэмт хэрэг гэж үзэж байгаа тул нэг бол эрүүгийн журмаар яллах эсхүл шилжүүлэн өгвөл зохихыг заасан. Хүн барьцаанд авах бүх үйлдлийг олон улсын терроризмын илрэл гэж үзэн тэдгээрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг яллах болон шийтгэх талаар үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хэлэлцэн тохирсон байна.

Хүн барьцаанд авахын эсрэг Олон улсын Конвенцийн 1 дүгээр зүйлд: “гурав дахь этгээдээр, тухайлбал улс, засгийн газар хоорондын олон улсын байгууллага, хувь хүн, хуулийн этгээд, эсхүл бүлэг этгээдээр аливаа үйлдэл гүйцэтгүүлэх буюу гүйцэтгэхээс татгалзуулах зорилгоор өөр нэг хүн (цаашид “барьцааны хүн” гэх)-ийг суллах шууд буюу шууд бус болзол болгон тавьж түүнийг олзлох буюу саатуулах, амийг нь хөнөөх, бие махбодид нь гэмтэл учруулах, эсхүл үргэлжлүүлэн саатуулахаар заналхийлж буй аливаа этгээдийг энэхүү конвенцийн хүрээнд хүн барьцаалах гэмт хэрэг үйлдсэн гэж” үзэхээр тодорхойлжээ. Түүнчлэн “аливаа этгээд: а) хүн барьцаалах үйлдэл хийхийг завдсан б) хүн барьцаалах үйлдэл хийсэн буюу чингэхийг завдсан этгээдийн гэмт хэрэгт хамтран оролцсон бол” ... гэмт хэрэг үйлдсэн гэж үзэхээр, оролцогч улс бүр дээрх гэмт хэргүүдийн ноцтой шинжийг харгалзан зохих шийтгэл ногдуулахаар заасан байна. Мөн гэмт хэрэгтэн нутаг дэвсгэрт нь хүн барьцаалсан бол оролцогч тухайн улс барьцааны хүний байдлыг хөнгөвчлөх, тухайлбал, түүнийг суллах, сулласны дараа шаардлагатай тохиолдолд уг улсаас гарахад нь тусламж дэмжлэг үзүүлэх, гэмт этгээдийн хүн барьцаалж байж олж авсан аливаа зүйл оролцогч улсын мэдэлд орсон бол тухайн оролцогч улс түүнийг түргэн хугацаанд барьцааны хүн буюу тэдгээрийн эрх бүхий холбогдох байгууллагад буцааж өгөх, оролцогч улс нь нутаг дэвсгэрт нь олж тогтоосон сэжигтэнг шилжүүлээгүй бол гэмт хэрэг нутаг дэвсгэрт нь үйлдэгдсэн эсэхээс үл хамаарч уг хэрэгт тухайн улсын хууль тогтоомжийн дагуу байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа шударга хандаж өөрийн эрх бүхий байгууллагад яллуулахаар шилжүүлэх, шийдвэрээ ноцтой шинж бүхий ердийн гэмт хэргийг шийдвэрлэдгийн адилаар гаргаж байхаар зохицуулжээ.

Дайнд хэлмэгдэгсдийг хамгаалах тухай 1949 оны Женевийн конвенциуд буюу тэдгээрийн нэмэлт протоколуудыг хүн барьцаалах тодорхой үйлдлийн хувьд хэрэглэдэг бөгөөд энэхүү конвенцид оролцогч улсууд дээрх конвенцуудын дагуу хүн барьцаалсан этгээдийг яллах буюу шилжүүлэн өгөх үүрэг хүлээсний хэрээр 1977 оны 1 протоколын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрэм болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу улсууд найрсагаар харилцах, хамтран ажиллах талаархи олон улсын эрх зүйн зарчмын тухай тунхаглалд дурдсан өөртөө засан тохинох эрхээ хэрэгжүүлэх үүднээс колонийн дарлал, харийн эзлэн түрэмгийлэл, арьсны үзэлт дэглэмийн эсрэг хийж буй ард түмнүүдийн тэмцлээс үүдсэн зэвсэгт мөргөлдөөн зэрэг 1949 оны Женевийн конвенциуд болон тэдгээрийн протоколуудад заасан зэвсэгт мөргөлдөөний үед хүн барьцаалах үйлдлийн хувьд энэхүү конвенцийг хэрэглэхгүй, гэмт хэргийг нэг улсын нутаг дэвсгэрт үйлдсэн бөгөөд барьцаанд байгаа хүн болон сэжигтэй этгээд хоёул тухайн улсын харьяат, түүнчлэн сэжигтэн этгээдийг тухайн улсын нутаг дэвсгэрт олж тогтоосон тохиолдолд энэхүү конвенцийг хэрэглэхгүй байхаар тус тус тогтоосон байна.

Гишүүн орнууд Хүн барьцаанд авахын эсрэг Олон улсын конвенцид гарын үсэг зурсан явдал түүх, улс төр болон хууль эрх зүйн чухал ач холбогдолтойг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол улс Хүн барьцаалахын эсрэг олон улсын Конвенцид 1992 оны 06 дугаар сарын 09-нд нэгдэн орсон байна.

Дүгнэлт

Хүн барьцаалах гэмт хэрэг нь олон улсын терроризмын нэг хэлбэр, мөн дэлхийн хамтын нийгэмлэг, улс орнуудын хоорондох харилцаанд (олон улсын харилцааг тогтворгүй болгодог) хохирол учруулдаг олон улсын бие даасан гэмт хэрэг гэж үзэхээр байна. Түүхэн олон улсын гэрээ, конвенциудад боолчлол, алан хядах ажиллагаа, агаарын хөлөг барьцаалах, бусад олон улсын шинжтэй гэмт хэргийг хамааруулан зохицуулсан байна. Хүн барьцаалах гэмт хэргийн нэн эртний хэлбэрийг боолчлол гэж үзэх үндэстэй юм.

1926, 1956 оны конвенциор боолын худалдааг хориглох түүнээс урьдчилан сэргийлэх, боолчлолын бүх хэлбэрийг богино хугацаанд бүрмөсөн устгахыг чармайх, боолын худалдаа болон боолчлолыг устгахын тулд харилцан бие биедээ дэмжлэг үзүүлэх явдал гэж үзжээ.

1963 онд “Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай” Конвенциор агаарын хөлөг, түүний дотор байгаа хүмүүс, эд хөрөнгө, түүнчлэн агаарын хөлгийн дотоод сахилга, дэг журамд аюул учруулсан, учруулж болзошгүй үйлдэл, агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг тодорхойлсон байна.

1970 онд Гаагийн “Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” конвенциор “агаарын хөлгийг хууль бусаар булаах” үйлдэл гаргасан тухайн этгээдэд хүнд ял оногдуулахаар зохицуулсан байна.

1971 онд Монреалийн “Иргэний нисэхийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” конвенциор иргэний нисэх хүчний эсрэг үйлдэж буй гэмт хэргийн ангилалд хамаарч буй нөхцөл байдлыг арилгахын тулд бие биендээ дэмжлэг үзүүлэх, зохих ёсны хариуцлагын зарчим бусад арга хэмжээг хэрэгжүүлэх, олон улсын терроризмын аюултай төрөл буюу хамгийн түгээмэл энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд улс орны хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бүрдүүлжээ. Гэвч олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг, нисэх буудалд үйлдэгдэж буй хүч хэрэглэсэн явдлыг таслан зогсоох асуудал олон улсын эрх зүйн зохицуулалтгүй үлдсэн учир 1971 оны Конвенцийн олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай нэмэлт протоколыг баталж, 1989 оны 8 дугаар сарын 6-ны өдөр хүчин төгөлдөр болсон байна.

Нэмэлт протоколоор оролцогч улсууд олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүмүүсийн аюулгүй байдалд аюул занал учруулж буй, учруулж болзошгүй, нисэх буудлын аюулгүй ажиллагаанд саад учруулж буй хүч хэрэглэсэн хууль бус үйлдлүүд, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэхийн тулд тууштай арга хэмжээ авахаар тогтжээ.

1977 оны “Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс түүний дотор дипломат төлөөлөгчдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шийтгэх тухай” конвенцид тогтоосон хэм хэмжээ, үндсэн зарчмын хүрээнд олон улсын алан хядах ажиллагаа үйлдэж буй этгээдэд ял шийтгэл оногдуулж байх зарчмыг хангах, тэдгээртэй холбоотой зүйлүүд хамаарсан байна.

1949 оны Женевын конвенциуд болон 1977 онд баталсан Нэмэлт протокол баримтууд байлдаж буй талууд олзлогдсон, далайд онгоцны сүйрэлд нэрвэгдсэн, шархадсан, өвчтөн зэргийн хүмүүст хандах хүмүүнлэг ёсны хэм хэмжээг тусгасан байна. Дээрх олон улсын акт баримтад тусгаж зааснаар хүн барьцаалах хүнд ноцтой гэмт хэрэг үйлдэхийг хориглосон байгаа нь чухал ач холбогдолтой.

1979 оны 12 сарын 17-ны өдрийн Хүн барьцаанд авахын эсрэг олон улсын Конвенцид хүн барьцаалах гэмт хэргийн шинжийг анх удаа бие даасан гэмт хэрэгт тооцохоор тодорхойлж, ангилсан бөгөөд ноцтой шинжийг нь харгалзан зохих шийтгэл ногдуулах зэргээр оролцогч улс орнууд үүрэг хүлээж, харилцан туслалцаа үзүүлэхээр тогтсон үндсэн баримт бичиг юм.

Уг конвенцийн дутагдалтай тал нь гэмт хэргийн субъектыг тодорхойлох асуудалд зөвхөн хувь хүн (этгээдүүд) гэж тодорхойлсон, зарим тохиолдолд хүн барьцаанд авах актыг зохион байгуулан гүйцэтгэгчээр оролцож буй улс, засгийн үүрэг ролийг тодорхойлоогүй явдал юм.

Ашигласан материал

1. Карпец И.И. Преступления международного характера. М., 1979.
2. СССР и международное сотрудничество в области прав человека. Документы и материалы МИД СССР. М., 1989.
3. Международное сотрудничество государств по борьбе с преступностью: Учебно-методическое пособие. М., 1982.
4. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхтгэл. Уб., 2015.
5. Советский Ежегодник международного право. М., 1989.
6. Женевские конвенций о защите жертв войны. М., 1954.
7. Женевские конвенций 1949 года и Дополнительные протоколы к ним 1977 года; Европейская конвенция 1976 года.
8. Советский спорт. 1972.
9. ООН. Генеральная Ассамблея. 5-е заседание. Специальный комитет. 5 августа 1977.

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА, ОЛОН УЛСЫН ЖИШИГ³³

Б.Досжан

*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш*

Товч агуулга: Энэхүү өгүүлэл гурван үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хуульд өсвөр насны хүнийг тодорхойлсон байдал хүлээлгэх эрүүгийн хариуцлага зэргийг судлан, олон улсын гэрээ хэлэлцээрүүд болон зарим улс орны эрүүгийн хууль тогтоомжид дээрх ойлголтыг тодорхойлсон байдлыг харьцуулан тодорхойлох юм. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын ойлголт нь эрүү болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн шинжлэх ухааны ухагдахуун боловч гол төлөв эрүүгийн эрх зүйн талаас асуудлыг шинжлэн судлах юм.

Түлхүүр үг: Өсвөр насны хүн, эрүүгийн хууль, олон улсын гэрээ.

Удиртгал

Улс орны ирээдүй болсон өсвөр насны хүний нийгмийн харилцаанд оролцох явц хууль зүйн хүрээнд явагдах нь тухайн улс орны хөгжил ирээдүйд шууд нөлөөлнө. Хууль тогтоогч, судлаачдын зүгээс өсвөр насны гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага оноох байдлыг тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарыг харгалзахаас гадна нийгмийн ирээдүйн нөхцөл байдлыг төсөөлөх нь зүйтэй мэт. Өсвөр насны хүнд оноох эрүүгийн хариуцлага болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсэн эрхийг сэргээх, хохирол нөхөн төлүүлэх зэргээс илүүтэйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тухайн хүнийг нийгэмшүүлэхэд чиглэх зорилготой байх шаардлагатай юм. Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг шалган тухайн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал нь тухайн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн бодит мөн чанар болон нийгэмд учруулах аюулыг ухамсарлах, эсхүл жолоодох боломжтой байсан эсэхийг тогтоох өвөрмөц нөхцөл байдал бий болгодог учир энэхүү ойлголтыг олон улсын жишигтэй харьцуулан авч үзэх болов. Монгол хэлний их тайлбар тольд “өсвөр нас” гэдгийг ид өсөн торниж буй хүүхэд үеийг³⁴ хэлнэ хэмээн тайлбарласан байдаг бол Монгол улсын Эрүүгийн хуульд өсвөр насны хүнийг тодорхой тоон үзүүлэлт бүхий насыг нарийвчлан зааж өгсөн байдаг.

Үндсэн хэсэг

Хүн төрөлхтний түүхэн дэх эрх зүйн хөгжил түүгээр дамжиж ирсэн хуулийн тогтолцоо бүр *“тодорхой гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд зарим шалгуур шаардлага буюу нас болоод биеийн хөгжил тэгширсэн”* байх гэсэн үзэл суртал давамгайлж ирсэн.

Ромын эрх зүйд “12 хүснэгтийн хууль” хэрэгжиж эхэлснээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл байдал нь тухайн этгээд бие болоод сэтгэцийн хувьд тодорхой хэмжээнд өсөж бойжсон байхыг шаарддаг. Шашны эрх зүйд 7 насанд хүрээгүй этгээд санаатай үйлдэл хийх боломжгүй сэтгэцийн хувьд эрүүл бус хүний адил хүлээн зөвшөөрөгддөг байсан бөгөөд шүүгчид хэрэг маргааныг хянан хэлэлцэхдээ 7 насанд хүрсэн хэдий ч тухайн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн хор аюулын шинж чанарыг ухамсарлаж байгаа эсэхийг нарийвчлан тогтоох үүрэгтэй байсан³⁵.

Германы эрх зүйн хөгжлийн эхэн үед гэмт этгээдийн насны байдалд төдийлөн анхаарал хандуулдаггүй байсан боловч хожим нь гэмт этгээд 12 насанд хүрсэн байхаар хуульчилсан. Улмаар 12 насанд хүрээгүй этгээдүүд санаатайгаар хүн алах тохиолдолд ч эрүүгийн хариуцлага ял зэмлэл хүртээхгүй байх бөгөөд зөвхөн тухайн этгээдийн ар гэрийнхнийг хохирогчийн ар гэрийнхэнд нөхөн төлбөр төлөх байдлаар уг асуудлыг шийдэж байв³⁶.

³³ Гадаад улсуудад өндөр насны тэтгэвэрт гарсан болон хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн эрдэмтэн багш нартаа зориулж шавь, хамтран зүтгэгч, мэргэжил нэгтнүүд нь эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх явдал түгээмэл байдаг. Энэ нь хүлээн зөвшөөрөгдсөн хүндэтгэлийн нэгэн хэлбэр бөгөөд миний бие өөрийн эрүүгийн эрх зүйн багш Хайруллагийн Гүлбостаны дурсгалд зориулан энэхүү эрлэм шинжилгээний өгүүллийг бичив.

³⁴ Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/dictionary/detail/73318>

³⁵ Şahin Akinci. Roma Hukuku Dersleri, Sayram yayınları. 2019. 150 дахь тал

³⁶ Naci Şensoy. Çocuk suçluluğu – küçüklük – çocuk mahkemeleri ve infaz müesseseleri. 1990 он. 579-р тал.

Исламын эрх зүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг хүйсээр ялгамжтай ангилж байсан бөгөөд эмэгтэй 9 нас, эрэгтэй 12 нас гэж тодорхойлсон. Энэхүү эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны талаарх ойлголтод Исламын хуульчид санал зөрөх явдал их байсан учир уг нас, хүйс үл харгалзан 15 нас болсон³⁷.

Орчин цагийн хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг тодорхойлон зааж уг насанд хүрээгүй этгээдийг хэрэг хариуцах чадваргүй гэж үзсэн³⁸ бөгөөд цаашид эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг тогтоохдоо өсвөр насны хүн өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн шинж чанарыг ухамсарлах хэмжээний сэтгэл зүй, сэтгэхүйн болон бие махбодын хөгжилд хангалттай хүрсэн эсэхийг нарийвчлан тогтоох шаардлагатай³⁹ хэмээн томъёолсон.

Өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны талаарх ойлголтод Монгол улсын эрүүгийн хуульд тоёолсоноор үндсэн 3 ухагдахуун байх боломжтой.

1. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой төрлийн гэмт хэргүүд буюу 10.1/Хүнийг алах/, 11.1/Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1/Хүчиндэх/, 17.1/Хулгайлах/, 17.2/Дээрэмдэх/, 17.8/Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 20.7/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.16/Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 26.1/Цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2/Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3/Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8/Террор үйлдэх/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол 14 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохоор зүйлчилсэн.

14 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй дээр дурдсан гэмт хэргүүдийг үйлдсэн өсвөр насны хүнд эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл журмыг баримтлан хариуцлага хүлээлгэх бөгөөд хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан тусгай үндэслэл журмыг баримтална. 14 насанд хүрээгүй хүн өөрийн үйлдлийн хор уршиг, үр дагаврыг хангалттай гадарлаж өөрийгөө удирдан жолоодох боломжтой болсон байдаг ч хуульд 14 насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй гэж үзсэн.

2. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг хийсэн хүн 16 насанд хүрсэн байх ёстой бөгөөд уг хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бүрэн боломжтой гэж Монгол улсын эрүүгийн хуульд тусгасан. Учир нь эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн байх нь эрүүгийн хариуцлага хүлээх этгээдэд заавал байх хууль зүйн шинж юм⁴⁰.

Хууль тогтоогчийн зүгээс эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх насны хязгаар тогтоохдоо тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээг бус харин тэрхүү этгээд үйлдсэн гэмт хэргийнхээ нийгмийн аюулын шинж чанар, учир холбогдол, мөн чанарыг хэрхэн ухамсарлан ойлгох чадвартай эсэх сэтгэхүйн шинжийг нь шалгуур болгон авч үздэг.

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16-р бүлэг 16.7 Хүүхэдтэй хэрцгий харьцах, 1-дэх хэсэгт зааснаар тус гэмт хэргийг үйлдэх боломжтой этгээд нь заавал 18 насанд хүрсэн байхыг шаардаж байгаа юм. Хууль тогтоогчийн зүгээс 16 нас зарим тохиолдолд 14 насанд хүрсэн тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Гэвч дээрх гэмт хэргийг үйлдэх этгээд заавал 18 насанд хүрсэн эсхүл түүнээс дээш байх ёстой гэж тухайн зүйлийн диспозицид тусгасан явдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны талаарх нийт 3 төрлийн ойлголт байх боломжтой гэх үндэслэлийг нотолж байна.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тухайн этгээд үйлдэл, эс үйлдэхүйн хор аюулын шинж чанарыг ухамсарлах чадвартай байхыг шаарддаг боловч өсвөр насны хүн дээрх шинж чанарыг бүрэн ухамсарлах, удирдан жолоодох чадвар нь насанд хүрсэн хүнтэй харьцуулахад сул гэж үзэн хариуцлага хүлээлгэхдээ тухайн хүнийг нийгмээс бүхэлд нь тусгаарлах байдлаас зайлсхийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор оногдуулах ялыг тодорхой хэмжээгээр

³⁷ MÜcahit Çolak. İslam hukukunda ceza ehliyeti açısından yaş küçüklüğü, Atatürk üniversitesi ilahiyet fakültesi dergisi, sayı: 35, Erzurum 2011 он. 118-р тал.

³⁸ НҮБ- Хүүхдийн эрхийн тухай конвенц 40.3-р зүйл. www.legalinfo.mn/law/details/1276.

³⁹ The Beijing Rules 4-р зүйл. Бээжингийн дүрэмд тодорхой насыг нарийвчлан заахаас зайлсхийсэн нь улс орон бүр ёс заншил хөгжлийн түвшин түүх соёлын хувьд ялгаатайг илтгэж байгаагийн илрэл юм.

⁴⁰ Б.Ганболд, Монгол улсын эрүүгийн эрх зүйн тойм, Улаанбаатар, 2003 он, 39-р тал.

түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун болон сэтгэцийн хөгжилд харшлахгүй байдлаар багасгаж оногдуулдаг.

НҮБ-н хүүхдийн эрхийн конвенцод 18 насанд хүрээгүй өсвөр насны хүн буюу хүүхдийн эрхийг улс төрийн бодлого, үйл ажиллагаа зэргээс ямагт нэгт тавих тэдний эрх чөлөөг хязгаарлах явдал нь хэрэглэж болох хамгийн сүүлийн арга хэмжээ хэмээн үзэж, гэмт хэрэг үйлдсэн гэх өсвөр насны хүнийг нийгэмшүүлэх арга хэмжээг зохион байгуулах нь шүүх хууль тогтоох тогтолцооны бүхий л шатанд баримталбал зохих ач холбогдолтой зарчим гэж үздэг⁴¹.

Иймд Монгол улсын эрүүгийн хууль дээрх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд: гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд /гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй байсан хүн/ нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих зэрэг ял мөн бусад албадлагын арга хэмжээг хэрэглэнэ. Өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн хөгжилд нь харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ба энэхүү ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт зуун хориос гурван зуун жаран цаг байхаар, эрүүгийн хуульд хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн тохиодолд өсвөр насны хүнд эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд заасан журмаар хорих ялыг хоёр дахин багасгаж сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ.

Эрүүгийн хууль тогтоомжид тусгасан өсвөр насны хүнтэй холбогдох зохицуулалт нь 2015 оны хуулиар шинэчлэгдэж 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн, энэхүү зохицуулалтыг олон улсын эрх зүйн хэм хэмжээтэй харьцуулах үүднээс дараах дэд сэдвийг хөндөж байна.

Олон улсын гэрээ хэлэлцээрт зааснаар өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь

Хүүхдийг хамгаалах тухай олон улсын эрх зүйн зохицуулалт дэлхийн I-р дайны дараа бий болсон гэж үздэг. League of Nations буюу одоогийн НҮБ-н үндэс суурь нь 1924 онд анх “Хүүхдийн эрхийн тухай” тунхаглалыг Женев хотод батлан энэ цаг үеэс хүүхдийн эрх, түүнийг хамгаалах тухай ойлголт бий болж, тусгайлан авч үзэх болсон. Үүний дараагаар буюу 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр НҮБ-н Ерөнхий ассамблей “Хүүхдийн эрхийн тунхаглал”-ыг баталсан. Энэхүү тунхаглалууд хууль эрх зүйн тодорхой хариуцлагын хэм хэмжээ бус гол төлөв ерөнхий үзэл баримтлал зарчим зэргийг өөрт агуулсан байдаг⁴².

Олон улсын эрх зүйд хүүхдийн эрхийг хамгаалах ерөнхий зохицуулалт нь НҮБ-н Хүүхдийн эрхийн тухай конвенцыг 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж⁴³, 1990 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр уг гэрээг үзэглэж эхэлсэн бөгөөд нийт 20 улс хүлээн зөвшөөрснөөр 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Монгол улсын хувьд Хүүхдийн эрхийн конвенцод 1990 онд 5 дахь орон болон нэгдэн орж тус конвенцыг үндэслэн “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хууль боловсруулан 1996 оны 5 дугаар сарын 8-ны өдөр батлан гаргаж 6 дугаар сарын 1-ний өдөр мөрдөж эхэлсэн бөгөөд энэ хууль нь 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр “Хүүхдийн эрхийн тухай” хууль батлагдсанаар хүчин төгөлдөр бус болсон.

НҮБ-н Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрэм”⁴⁴, 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдөр “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар НҮБ-н үндсэн зарчим буюу Эр-Риядын зарчим”⁴⁵ мөн онд “Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүйчүүдийг хамгаалах талаарх НҮБ-н дүрмүүдийг /Хаванагийн дүрэм/”⁴⁶ баталсан.

Дээрх олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдийн агуулгыг дэлгэрүүлэн авч үзвэл:

⁴¹ Sevük Handan Yokuş, Uluslararası Sözleşmelerdeki İlkeleri Açısından Çocuk Sorumluluğu ile Mücadelede Kurumsal Yaklaşım, İstanbul 1998, ХЭК-н 31-р зүйлийг тайлбарлах нь, 185-р тал.

⁴² Yusuf Solmaz, Çocuk Ceza Hukuku, Ankara 2003, 45-46-р тал.

⁴³ 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон Хүүхдийн эрхийн тунхаглалтай адил хугацаанд батлагдсан учир жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүүхдийн эрхийг хамгаалах өдөр гэж үздэг болсон. www.un.org/en/events/childrenday

⁴⁴ www.un.org/en/events/pastevents/pdfs/Beijing_Declaration_and_Platform_for_Action.pdf

⁴⁵ www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/PreventionOfJuvenileDelinquency.aspx

⁴⁶ www.unodc.org/pdf/criminal_justice/United_Nations_Rules_for_the_Protection_of_Juveniles_Deprived_of_their_Liberty.pdf

1. Хүүхдийн эрхийн тухай тунхаглал

Уг тунхаглалд насанд хүрээгүй хүнтэй холбоотойгоор тодорхой хууль, журам баталж эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг нарийвчлан тогтоож тогтоосон насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх. Гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг тогтоон дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх. Насанд хүрээгүй хүний хүмүүжил болон хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ буюу албадлагын арга хэмжээг хэрэглэх. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдолд эрүүдэн шүүлтийн золиос болгохоос сэргийлэх, 18 насанд хүрээгүй хүнд бүх насаар нь хорих ял оноохгүй байхыг санал болгосон⁴⁷.

2. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрэм/

Бээжингийн дүрэмд улс орнууд үндсэн ашиг сонирхолдоо нийцүүлэн насанд хүрээгүйчүүдэд эерэг нөлөө үзүүлэхүйц амьдралын хэв маяг бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор насанд хүрээгүйчүүдийн амьдралын нөхцөлийг сайжруулах. Гэмт хэрэг зөрчил үйлдсэн насанд хүрээгүй хүнд оногдуулах хариуцлага нь хууль зүйн хувьд хөнгөн хэлбэртэй байх бөгөөд тэдэнтэй хүнлэг байдлаар харилцах нөхцөлийг бүрдүүлэх. Насанд хүрээгүй хүний хөгжилд анхаарч тэдгээрийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой тогтолцооны дагуу сайжруулах. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст тэдний эрх чөлөөг бүрэн хязгаарласан буюу хорих ял оногдуулахаас зайлсхийхийг санал болгосон агуулгатай⁴⁸.

3. Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар НҮБ-н үндсэн зарчим буюу Эр-Риядын зарчим

Насанд хүрээгүй хүний хөгжилд анхаарч тэдгээрээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг тогтоон дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх тэдгээрийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг идэвхжүүлэх тал дээр зарим улсуудад улс төрийн тодорхой бодлогын өөрчлөлт оруулахыг зөвлөмжилсэн.

4. “Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүйчүүдийг хамгаалах талаарх НҮБ-н дүрмүүд /Хаванагийн дүрэм/

Насанд хүрээгүй хүнийг тодорхой хугацаагаар тодорхой нэг байгууллагад байршуулах нь гол төлөв хэрэглэж болох хамгийн сүүлийн арга хэмжээ байх шаардлагатай хэмээн үзэж, эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүйчүүдэд бусдын хамгаалалт, дэмжлэг шаардагдаж байдгийг дурдан насанд хүрээгүйчүүдийн эрхийг бүрэн хамгаалсан тохиолдолд л хүмүүжүүлэх арга хэмжээ авах ёстой гэж үзсэн. Хэрэв насанд хүрээгүй хүнд хорих ял оноосон бол тухайн этгээдүүдийг хорих байр зарим тусгай шаардлагыг хангаж тэднийг гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлах бус сурч боловсрох, бие бялдрын хэвийн хөгжил зэрэгт анхаарах тус ял эдэлж дууссан тохиолдолд амьдралаа хэвийн авч явахад нь анхаарах зэрэг агуулгатай.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр өсвөр насны хүн гэж хэн болохыг тодорхойлох, тэдэнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэлбэр зэргийн талаарх ерөнхий ойлголт зөвлөмжийг өгч байна. Монгол улсын хувьд нэгдэн орсон олон улсын хэм хэмжээг ердийн хууль тогтоомжид тусгасан болов ч тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явдал хангалтгүй байгаагаас насанд хүрээгүйчүүдийг хүмүүжүүлэх тэдгээрт оноосон ялыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд зарим тохиолдолд тэдний эрх нь зөрчигдөх байдал ажиглагддаг.

Дээрх гэрээ хэлцэлд нэгдэн орсон бусад улс орнууд дотоодын хууль тогтоомж, хуульчилсан акт зэрэгтээ хэрхэн өөрчлөлт, шинэчлэл оруулсан байгааг судлах шаардлага урган гарч байна. Улс орнууд олон улсын гэрээ хэлцэлд үндэслэн дараах байдлаар өсвөр насны хүнтэй холбогдох зохицуулалтыг томъёолсон.

Гадаад улсуудын туршлага, эрх зүйн зохицуулалт

1. ХБНГУ

Герман улс 0-14, 14-18 болон 18-21 зэрэг насны ангиллыг Насанд хүрээгүй иргэдийн асуудал шийдвэрлэх шүүхийн тухай хуульд зааж өгсөн.

⁴⁷ Öztürk Bahri, Erdem M.Ruhan, Uygulamalı Ceza Muhakemesi Hukuku, Ankara 2006, 378-379-p тал.

⁴⁸ Bağcı Olca, Çocuk Yargılaması, İstanbul Barosu Yayınları, Cep kitapları 6, 8-p тал.

Герман улсын эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээд 14 насанд хүрээгүй бол тухайн этгээдийг өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хор уршиг, нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах чадваргүй гэж үзэн гэм буруугүйд тооцож эдгээр этгээдэд эрүүгийн хариуцлага болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэхээс татгалздаг⁴⁹. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй байгаа этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ үйлдэл, эс үйлдэхүйнхээ хор уршиг, нийгмийн аюулын шинж чанарыг хэрхэн ухамсарлаж байгааг харгалзан оногдуулах хариуцлагын төрөл, хэлбэр⁵⁰ хэлбэлздэг. 18-21 насныхныг мөн тодорхой ангилал болгон тусгасан шалтгаан нь дээр дурдсан ангилал бүрийн хоорондох шилжилтийн үед ямар нэгэн гэнэтийн өөрчлөлт гарахгүй бөгөөд нас нь хэдийгээр нэмэгдэх ч тухайн этгээдийн сэтгэхүйн хөгжил байдал л насанд хүрээгүй хүнийхтэй адил төстэй байх магадлалтай учир ялгамжтай хариуцлага хүлээлгэх ёстой гэж тусгасан⁵¹.

2. Итали

Итали улсын эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар 14, 14-18 нас юм. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй байгаа этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ үйлдэл, эс үйлдэхүйнхээ хор уршиг, нийгмийн аюулын шинж чанарыг хэрхэн ухамсарлаж байгааг харгалзан үзэж үйлдэл, эс үйлдэхүйн үр дүнд бий болох нөхцөл байдлыг бүрэн дүүрэн мэдэж байгаа тохиолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Зарим тохиолдолд үйлдсэн гэмт хэргээ хүлээн зөвшөөрсөн өсвөр насны хүнийг хариуцлагаас чөлөөлөх, хариуцлага хүлээлгэхийг хойшлуулах боломжтой мөн насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг шалган шийдвэрлэхдээ тусгай журам баримтална⁵².

3. Франц

Франц улсын эрүүгийн хууль эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг 0-13, 13-16, 16-18 мөн 18 түүнээс дээш гэх байдлаар нийт дөрвөн төрлийн ангилал бий болгосон. 13 насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. 13-16 болон 16-18 насны гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг адил төстэй журмаар шалгах боловч 13-16 насны этгээдүүдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл тэдний наснаас нь шалтгаалан хөнгөрдөг бол 16-18 насны этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдолд шүүх тухайн хариуцлагын хөнгөрүүлэхээс татгалзаж болдог⁵³.

13 насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ буюу албадлагын арга хэмжээг хэрэглэх бөгөөд тухайн этгээд 13 насанд хүрсэн тохиолдолд түүнд авч буй арга хэмжээ тодорхой үр дүнд хүрээгүй гэж үзвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохоор хуульчилсан⁵⁴.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар нь улс орон бүрт тэдний нийгэм, эдийн засаг, ёс заншил, соёл иргэншил, улс төрийн болон эрх зүйн тогтолцооноос нь хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал: Малайз 10⁵⁵, Румын 12⁵⁶, Турк 12⁵⁷, Швед 12⁵⁸, Болгар 14⁵⁹, Их Британи 14⁶⁰, Аргентин 14⁶¹, Финланд 15⁶², Куба 16⁶³ гэх ба эдгээр насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар хуульчилсан. Гэвч гэмт хэрэг

⁴⁹ Aksay Bekir, Ceza Hukukunda Yaş Küçüklüğü, İstanbul 1990, 44-р тал.

⁵⁰ Тухайн этгээдийн гэмт хэрэгт хандаж буй сэтгэхүйн хандлагыг нарийн тогтоож эрүүгийн хариуцлага, албадлагын арга хэмжээ зэргийг ялгамжтай хэрэглэнэ.

⁵¹ germanlawarchive.iuscomp.org/?p=756

⁵² Patrizia Meringolo, Juvenile Justice System in Italy: Researches and interventions, 2011, www.researchgate.net/publication/262515461_Juvenile_Justice_System_in_Italy_Research_and_interventions

⁵³ Anne Wyvenkens, The French Juvenile Justice System, 2017, halshs.archives-ouvertes.fr/halshs-00458770/document

⁵⁴ 1 жилээс бага хугацаа үлдсэн тохиолдолд цагдан хорих байранд хорино, 1 жилээс их бол насанд хүрээгүй хүнийг тодорхой мэргэжил эзэмшүүлэх зорилгоор сургалтын хорих байгууллагад хорино, halshs.archives-ouvertes.fr/halshs-00458770/document

⁵⁵ www.agc.gov.my/agcportal/uploads/files/Publications/LOM/EN/Penal%20Code%20%5BAct%20574%5D2.pdf

⁵⁶ www.vertic.org/media/National%20Legislation/Romania/RO_Criminal_Code.pdf

⁵⁷ www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf

⁵⁸ www.government.se/contentassets/5315d27076c942019828d6c36521696e/swedish-penal-code.pdf

⁵⁹ prostitution.procon.org/sourcefiles/BulgariaCriminalCode.pdf

⁶⁰ agc.gov.ms/wp-content/uploads/2010/02/penal_code.pdf

⁶¹ www.loc.gov/law/help/child-rights/argentina.php

⁶² www.finlex.fi/en/laki/kaannokset/1889/en18890039_19951010.pdf

⁶³ www.warnathgroup.com/wp-content/uploads/2015/03/Cuba-Penal-Code-Lawyers-Without-Borders-2009.pdf

үйлдэхдээ дээрх насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй бол тэдэнтэй холбоотой мөрдөн шалгах, шүүх ажиллагааг тусгай журмаар явуулна гэж нийтлэг байдлаар хуульчилсан.

Дүгнэлт

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тэр дундаа хорих ял оноох нь тухайн хүнийг хүмүүжүүлэх бус дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл байдал руу түлхэх боломжтой гэж олон улсын гэрээ хэлэлцээрт дурдсан байна.

Монгол улсын эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг 14 нас гэж хуульчилсан нь нийгэм эрх зүйн хөгжлийн зүй тогтолтой харьцуулан үзэхэд тохиромжгүй мэт. Учир нь сүүлийн жилүүдэд хийгдэж буй судалгаагаар гэмт хэрэг үйлдэх нас харьцангуй залуужсан гэж үздэг ба энэ нь техник, технологийн хөгжлөөс шалтгаалан насанд хүрээгүй хүний сэтгэн бодох, танин мэдэхүй, эргэцүүлэл нь маш хурдацтай төлөвшсөнтэй холбогдож байдаг.

Өсвөр насны хүнтэй холбогдох ихэнх гэмт хэргүүдийн шалтгаан нөхцөл нь тэдний асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг бүхий этгээдүүдээс өсвөр насны хүний хүмүүжилд тавих анхаарал хяналт суларсан тохиолдолд гэмт хэрэг, зөрчил үйлдэх явдал идэвхжиж байдаг. Иймд бусад улсын жишгээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч этгээдүүдэд мөн үүрэг хүлээлгэж хариуцлага тооцох арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Хэдийгээр энэ нь эрүүгийн хуулийн ерөнхий ангид тусгалаа олсон шударга ёсны зарчимтай зөрчилдөх мэт боловч дээр дурдсан ойлголт нь эрүүгийн хариуцлагыг халдаан хэрэглэх бус асран хамгаалах харгалзан, дэмжих үүргээ үл биелүүлсэнд нь л хариуцлага хүлээлгэж буй явдал юм.

Олон улсын гэрээ хэлэлцээрт өсвөр насны хүнтэй холбогдох гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх этгээд нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх, зөвхөн уг асуудлыг шийдвэрлэх бүтцийн байгууллага шинээр байгуулахыг шаардаж зөвлөдөг бол манай улсын хувьд энэ ойлголт хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад л хэрэгждэг. Цаашид өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг шалган шийдвэрлэхэд дагнасан прокурор, шүүх байгуулах шаардлагатай байна.

Ном зүй

- Б.Ганболд, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тойм, Улаанбаатар, 2003 он.
- Монгол хэлний их тайлбар толь.
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц
- Aksay Bekir, Ceza Hukukunda Yaş Küçüklüğü, İstanbul 1990 он.
- Anne Wyvenkens, The French Juvenile Justice System, 2017 он.
- Bağcı Olcay, Çocuk Yargılaması, İstanbul Barosu Yayınları, Cep kitapları.
- Mücadelede Kurumsal Yaklaşım, İstanbul 1998 он.
- Mücahit Çolak. İslam hukukunda ceza ehliyeti açısından yaş küçüklüğü, Atatürk üniversitesi ilahiyet fakültesi dergisi, sayı: 35, Erzurum 2011 он.
- Naci Şensoy. Çocuk suçluluğu – küçüklük – çocuk mahkemeleri ve infaz müesseseleri. 1990 он.
- Sevük Handan Yokuş, Uluslararası Sözleşmelerdeki İlkeleri Açısından Çocuk Sorumluluğu ile
- Şahin Akıncı. Roma Hukuku Dersleri, Sayram yayınları. 2019 он.
- Öztürk Bahri, Erdem M.Ruhan, Uygulamalı Ceza Muhakemesi Hukuku, Ankara 2006 он.
- Patrizia Meringolo, Juvenile Justice System in Italy: Researches and interventions, 2011 он.
- Yusuf Solmaz, Çocuk Ceza Hukuku, Ankara 2003 он.
- www.legalinfo.mn/law/details/1276
- mongoltoli.mn/dictionary/detail/73318.
- www.un.org/en/events/pastevents/pdfs/Beijing_Declaration_and_Platform_for_Action.pdf
- www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/PreventionOfJuvenileDelinquency.aspx
- www.unodc.org/pdf/criminal_justice/United_Nations_Rules_for_the_Protection_of_Juveniles_Deprived_of_their_Liberty.pdf
- www.researchgate.net/publication/262515461_Juvenile_Justice_System_in_Italy_Research_and_interventions
- www.agc.gov.my/agcportal/uploads/files/Publications/LOM/EN/Penal%20Code%20%5BAct%20574%5D2.pdf

- www.vertic.org/media/National%20Legislation/Romania/RO_Criminal_Code.pdf
- www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf
- www.government.se/contentassets/5315d27076c942019828d6c36521696e/swedish-penal-code.pdf
- www.loc.gov/law/help/child-rights/argentina.php
- www.finlex.fi/en/laki/kaannokset/1889/en18890039_19951010.pdf
- www.warnathgroup.com/wp-content/uploads/2015/03/Cuba-Penal-Code-Lawyers-Without-Borders-2009.pdf
- prostitution.procon.org/sourcefiles/BulgariaCriminalCode.pdf
- agc.gov.ms/wp-content/uploads/2010/02/penal_code.pdf
- germanlawarchive.iuscomp.org/?p=756
- halshs.archives-ouvertes.fr/halshs-00458770/document

---oOo---

ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ БИЕЛҮҮЛЭХИЙГ ХОЙШЛУУЛАХ ОЙЛГОЛТ, ҮНДЭСЛЭЛ, ОНЦЛОГ

Т.Еркебулан
Баян-Өлгий аймаг дахь ШШГГ-ын
Цагдан хорих байрны дарга, хошууч

Товч утга:

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөгдсөнөөс хойш хоёр жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зарим зохицуулалтыг хэрэгжүүлэхэд эргэлзээ бүхий, ойлгомжгүй, маргаантай байдал бий болсоор байна. Тухайлбал, гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах зэрэг эрх зүйн зохицуулалтууд өнөөдрийг хүртэл практикт маргаан дагуулсаар байна.

Иймд энэхүү өгүүллийн хүрээнд дээрх маргаантай зохицуулалтуудын нэг болох хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалтыг судлан, тулгамдаж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно.

Түлхүүр үг:

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах, хорих ял, түүхэн уламжлал.

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж⁶⁴ улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оноос эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Ийнхүү шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх явцад зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт нэлээдгүй байгаа учир тухайн заалтуудыг практикт нэг мөр хэрэгжүүлэхийн тулд тодорхой асуудлаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай⁶⁵ хэмээн практикт ажиллаж буй хуульчид болон салбарын эрдэмтэн, судлаачдын үзэж байгаа нь хуулийн хэрэгжилтийн талаар зохион байгуулагдаж буй хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг⁶⁶, хурлын үр дүнгээс харагдаж байна. Тухайлбал, 2002 оны Эрүүгийн хуулиар насанд хүрээгүй хүүхдийн хувьд хорих ял оногдуулахдаа гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр хорих ял оногдуулсан шийтгэлийг тэнсэх, хойшлуулах зохицуулалттай байсныг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар зөвхөн “хөнгөн гэмт хэрэг” гэж хязгаарласан нь өсвөр насны хүний эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалт болсон гэж хуульч, шүүгч, судлаачид үзэж байна.⁶⁷

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн маргаан бүхий зохицуулалтуудаас энэхүү өгүүллийнхээ хүрээнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалтын талаар судлан үзсэн болно.

Эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх институц нь манай улсын Эрүүгийн хууль тогтоомжид уламжлагдан ирсэн энэрэнгүй ёсны зарчмын тод илрэл юм.⁶⁸ Шүүхээс тодорхой этгээдэд оногдуулсан хорих ялыг Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу биечлэн эдлүүлэхийг тодорхой нөхцөл хугацаагаар түдгэлзүүлэхийг “ял хойшлуулах”⁶⁹ гэнэ.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах тухай ойлголтыг эрдэмтэн судлаачид өөр өөрийнхөөрөө тодорхойлсон байдаг. Тухайлбал, доктор, профессор Г.Совд “...Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг

⁶⁴ Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, УБ., 2013 он.

⁶⁵ Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл, 6.7 дугаар зүйл.

⁶⁶ Тухайлбал, УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-тай хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг”, “Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлэг, “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн үйл явц” сэдэвт хэлэлцүүлэг, “Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа – онол практикийн асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурал.

⁶⁷ Мөн тэнд.

⁶⁸ С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эх зүйн онол, (УБ, 2014), 338 дахь тал.

⁶⁹ Б.Ганболд, Эрүүгийн эрх зүйн мэдлэг, (УБ, 2009), 202 дахь тал.

хойшлуулахад ялтныг ял эдлэхээс чөлөөлж байгаа боловч тодорхой болзлыг тогтоосон бөгөөд тэр болзлыг зөрчвөл анх удаа шийтгэсэн хорих ялыг биечлэн эдлүүлэх болдог тул ял эдлэхээс чөлөөлж, байгаа бус эрүүгийн хариуцлага хүлээж байгаа албадах арга хэмжээ” гэж, С.Жанцан “...Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах гэдэг нь эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмаар шүүгдэгчид оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл тодорхой хугацаа зааж, үүрэг болгосон агуулгатай болзол тавьж ялыг биечлэн эдлүүлэх явдлыг түдгэлзүүлж байгаа хэрэг юм”⁷⁰ хэмээн тус тус тодорхойлсон байна.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахад анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн:

- Өсвөр насны хүн.;
- Жирэмсэн эмэгтэй
- Гурав хүртэлх насны ганц бие эцэг, эхийн үйлдсэн гэмт хэрэгт нь хорих ял оногдуулсан тохиолдолд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болохоор шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тусгасан байна.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Ийнхүү шүүхээс тогтоол гарсан үед нэмэгдэл ял биелүүлэхийг нэгэн адил хойшлуулахаар тусгажээ. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахад гэмт хэрэг үйлдсэн хүнийг хорих ялаас чөлөөлж байгаа боловч тодорхой болзол тогтоож, тухайн болзлыг зөрчвөл шүүхээс оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэх бөгөөд харин шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлөхөөр хуульчилсан байна.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, хяналт тавих үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад даалгаж, дээрх хугацаанд дахин гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд хойшлуулсан ялыг сэргээн эдлүүлэх талаар прокурорын байгууллагад санал гаргаж шийдвэрлүүлэхээр эрх олгосон.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах талаарх эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал

Эрүүгийн эрх зүйн харилцаа нь Монголчуудын хувьд нэн эртнээс эхлэлтэй бөгөөд түүхэн эх сурвалж, баримтуудад тэмдэглэгдэн үйлдсэн байдаг.

Монгол Улсын шинжлэх ухааны доктор И.Дашням өөрийн бүтээлдээ “...Хүннү Улсын үед Модун Шаньюй ял онох дээд эрхийг эдлэхийн хамт хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх эрхтэй байсан” талаар дурджээ.⁷¹

Мөн Их засаг хуульд Монголын нэгдсэн улсын ялын бодлого, ялын төрөл, хэлбэр, ял оногдуулах чөлөөлөх асуудлыг тусгайлан хуульчлан мөрдөж байсан талаар эрдэмтэн, судлаачдын бүтээлд тэмдэглэгдэн үлжээ.

Түүнчлэн VIII Богд Жавзундамба Монгол Улсын Хаан ширээнд өргөмжлөгдөөд 1911 оны 12 дугаар сарын 29-ний өдөр гаргасан “Хишиг тараах” зарлигт “Аливаа элдэв ялтныг цөм хэлтрүүл” гэж ялаас чөлөөлөх шийдвэр гаргаж байсан тухай түүхэн эх сурвалжид тэмдэглэгдэн үлджээ.

Ийнхүү Монгол Улс 1926 онд анхны Эрүүгийн төрөлжсөн хуулиа “Шүүх цаазын бичиг” нэртэйгээр баталж, дагаж мөрдөх болсон билээ. Энэхүү Шүүх цаазын бичгийн “Ял үл хэлэлцэх нь” хэмээх Гуравдугаар бүлгийн 18-22 дугаар зүйлд ялаас чөлөөлөх үндэслэл журмыг хуульчилсан байна. Мөн энэ хуулийн долдугаар бүлэг буюу “Ял тогтоохын урьд хоригдсоныг ялд тооцох ба хугацаа дуусахын урьд ялтныг гаргах ба ялыг нэг мөсөн өршөөн хэлтрүүлэх” тухай 35-40 дүгээр зүйлд заасан байна. Тухайн үед аливаа ялыг нэг мөсөн өршөөн хэлтрүүлэх буюу хөнгөтгөх эрхийг Улсын бага хурлын тэргүүлэгчид эдэлж байжээ.

1926 оны Шүүх цаазын бичгийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлд:

а/ Анх гэмт явдал өдлүүлсэн үедээ 18 нас хүрээгүй хүмүүс

б/ Хөхүүл хүүхэдтэй буюу жирэмсэн эмэгтэйчүүд нарт ял оногдуулахгүй эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх тухай заажээ.

⁷⁰ С.Жанцан. дурдсан бүтээл. УБ., 2014. 317 дахь тал

⁷¹ И.Дашням, Монголын төр эрх зүйн түүх /Тэргүүн боть/, (УБ, 2005), 59 дэх тал.

Шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулах институцийг 1926 оны Шүүх цаазын бичгийн 8 дугаар зүйлд “Оноосон ялыг түдгэлзүүлэх нь шүүн таслах газраас тогтоосон хугацаа 3-5 жил хүртлээс дээшгүй хугацааны дотор уг ялтан дахин тэр мэтийн гэмт явдал үйлдвээс оноосон ялыг эдлүүлнэ”⁷² гэж хуульчилсан байна.

Харин 1929 оны Шүүх цаазын бичгийн 12 дугаар зүйлд “Оноосон ялыг түдгэлзүүлэх нь шүүн таслах газраас тогтоосон нэгээс таван жил хүртэлх хугацааны дотор ялт хүмүүн дахин нэг төрлийн буюу өөр хүнд гэмт явдал эс үйлдвээс оноосон ялыг эдлүүлмөй”⁷³ гэжээ.

Түүнчлэн хэрэг үйлдэх үедээ 18 нас хүрээгүй байсан хүмүүс, мөн хөхүүл хүүхэдтэй, жирэмсэн эмэгтэйд цаазаар авах ял оноож болохгүй. “Гэмт хэрэг үйлдсэн 14 насны багачуудад эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохгүй” гэж зарчмын өөрчлөлт оруулжээ.

Улмаар 1934 оны Шүүх цаазын бичгийн 38 дугаар зүйлд шийтгэсэн ялыг гүйцэтгэхэд түдгэлзсэн ялтай хүнийг тэнсэх тухай зохицуулалт тусгагдсан нь агуулгаараа тэнсэх бус хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг хойшлуулах явдал байсан хэмээн үзэж болох юм.

1942 оны Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлд “Шүүх хорих ял эдлүүлэх нь заавал бус гэж үзвэл оноосон ялыг эдлүүлэх явдлыг түдгэлзүүлэх эрхтэй болно. Түдгэлзүүлэх хугацаа нэг жилээс доошгүй бус, таван жилээс дээшгүй бус байна гэжээ.

Харин 1961 оны Эрүүгийн хуулийн 34 дүгээр зүйлд байлдааны цагт цэргийн албан хаагчид ба цэргийн алба хаах үүрэгтэй хүмүүсийг ял эдлүүлэхийг хойшлуулах тухай зохицуулалт шинээр хуульчлагдсан юм.

Мөн энэ хуульд 1980 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 302 дугаар зарлигаар батлагдсан “БНМАУ-ын Эрүүгийн хууль, БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар “Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах” гэсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар “Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах” гэсэн заалтыг 34 дүгээр зүйлд анх удаа оруулж өгсөн байна.⁷⁴

Тус хуульд шүүх ял оногдуулахдаа тухайн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн хор аюулын хэр хэмжээ, хэрэгтний хувийн байдал, олон нийтээс тусгаарлахгүйгээр засаж хүмүүжүүлэх боломжийг харгалзан үзэж хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлэхийг зургаас хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно хэмээн заасан байжээ.

1986 оны шинэчилсэн найруулсан Эрүүгийн хуульд шийтгэх тогтоолыг хойшлуулах эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгон тус хуулийн 41 дүгээр зүйлд цэргийн алба хаагч болон цэргийн үүрэгтэнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг 42 дугаар зүйлд заасан насан хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг тус тус хойшлуулахаар хуульчилсан байна.

Мөн тус хуульд 1961 оны Эрүүгийн хууль дахь насанд хүрээгүй хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаарх хэм хэмжээ хэвээр хадгалагдан үлдсэн ба ерөнхий ангийн 42 дугаар зүйлд насанд хүрээгүй этгээдэд ял хойшлуулах 9 зүйлийн 4 хэсэгт 18 насанд хүрэхийн өмнө нийгмийн хор аюулаар их биш гэмт хэргийг анх удаа үйлдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх⁷⁵ зэрэг хэм хэмжээ шинээр хуульчилсан байна.

Ийнхүү 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” хуулийн 23 дугаар зүйлд “Хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэр биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй ялтныг хянан харгалзах”, 24 дүгээр зүйлд “Ийм шийдвэрийг хүчингүй болгох, ялаас чөлөөлөх” үндэслэл журмыг тус тус нарийвчлан тодорхойлжээ.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах талаарх эрх зүйн зүйн зохицуулалт түүхэн хөгжлийн явцад улам боловсронгуй болсоор 2002 оны Эрүүгийн хуулийн 62, 63 дугаар зүйлд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах талаарх зохицуулалт хуульчлагджээ.

Тус хуулийн 62 дугаар зүйлд анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм

⁷² Д.Адъяабазар, Монгол Улсын 1921 оноос хойшхи Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт / I дэвтэр/, (УБ, 1998), 9 дэх тал.

⁷³ Мөн тэнд, 39 дэх тал.

⁷⁴ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол //I боть/, (УБ, 2014), 314 дэх тал.

⁷⁵ Г.Гантөмөр, Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол, (УБ, 2010), 150 дахь тал.

буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Ийм тогтоол гаргасан үед нэмэгдэл ял биелүүлэхийг нэгэн адил хойшлуулна.

Мөн 63 дугаар зүйлд жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулна гэж тус тус заажээ.⁷⁶

Ийнхүү 2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль батлагдаж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсон билээ. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.11 дүгээр зүйлд хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих шинэлэг зохицуулалтыг хуульчилсан тул өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах журмыг хуульчлаагүй байсан.

Гэсэн хэдий ч зорчих эрхийг хязгаарлах ялыг 2019 оны 1 дүгээр сарын 1-ний /дахин 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл хойшлуулсан/ өдрийг хүртэл хэрэгжих хугацааг хойшлуулсантай холбоотойгоор 2017 онд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих журмыг хасаж, түүний оронд уламжлалт өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах журмыг хуульчилсан юм.

2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуулийн хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулан үзвэл:

Хүснэгт 1. 2002 болон 2015 оны Эрүүгийн хууль дахь хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын харьцуулалт:

№	2002 оны Эрүүгийн хуулийн	2015 оны Эрүүгийн хууль
1	<p>62 дугаар зүйл. Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах</p> <p>62.1. Анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Ийм тогтоол гаргасан үед нэмэгдэл ял биелүүлэхийг нэгэн адил хойшлуулна.</p> <p>62.2. Шүүх шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа тодорхой хугацаанд ажил, сургуульд орох, учруулсан хохирлоо нөхөн төлөх, гэм хорыг арилгах, ажлын газар, сургуулиа өөрчилсөн тухайгаа оршин суугаа газрынхаа цагдаагийн байгууллагад мэдэгдэж байх зэрэг түүний засрал хүмүүжилд дөхөм үзүүлэх үүргийг даалгаж, түүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон</p>	<p>7.6 дугаар зүйл. Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах</p> <p>1. Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.</p> <p>2. Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана.</p> <p>3. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.</p> <p>4. Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон</p>

⁷⁶ Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5.

<p>буюу төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэнд тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр хариуцуулж болно.</p> <p>62.3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хугацаанд даалгасан үүрэг биелүүлээгүй буюу захиргааны шийтгэл хүлээсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж гаргана.</p> <p>62.4.Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд засарч хүмүүжсэнээ харуулсан бол цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн шүүх түүнийг ялаас чөлөөлж болно.</p> <p>62.5.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.</p> <p>63 дугаар зүйл. Жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах</p> <p>63.1.Шүүх анх удаа хүндэвтэр, хүнд гэмт хэрэг үйлдсэн жирэмсэн эмэгтэй, түүнчлэн гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд цагдаагийн байгууллага хяналт тавина.</p> <p>63.2.Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол шүүх цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шүүгч захирамж гаргана.</p> <p>63.3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 58 дугаар зүйлд заасан журмыг баримтлан ял оногдуулна.</p>	<p>хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.</p> <p>8.6 дугаар зүйл.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах</p> <p>1.Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.</p> <p><i>/Энэ хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</i></p> <p>2.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.</p> <p>3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд энэ хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.</p> <p>4.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.</p>
---	--

2002 оны Эрүүгийн хуульд насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх буюу ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах журмыг хуульчилсан байсан. Энэ нь гэмт хэрэг анх удаа үйлдсэн, нийгмээс

тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүхээс үзсэн “онцгой субъект”-уудад хэрэглэх арга хэмжээ юм.⁷⁷

Ийнхүү хуульчлахдаа 2002 оны Эрүүгийн хуулийн 62, 63 дугаар зүйлд заасан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах журмыг 2017 онд батлагдсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 7.6 дугаар зүйлд нэгтгэн “Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно” гэж хуульчилжээ.

Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа үүрэг хүлээлгэх, хязгаарлалт албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Өөрөөр хэлбэл, шүүхээс гэмт хэрг үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулж, Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлд заасан 4 төрлийн үүрэг хүлээлгэж, 4 төрлийн хязгаарлалт тогтоодог.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг шинээр үйлдвэл шүүх түүнд хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах журмыг баримтлан ял оногдуулна.

Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалтын асуудал

2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 6.11 дүгээр зүйлд хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих шинэлэг зохицуулалтыг хуульчилсан тул өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах журмыг хуульчлаагүй байгаа нь гэмт хэрэг холбогдсон хүн бүр хорих ял эдэлж байна. Энэ нь мэргэжлийн байгууллагын гаргасан судалгаанаас харагдаж байна.⁷⁸ Үүнд:

1. 2017 онд өсвөр насны хүн 205, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 105 хүнийг,
2. 2018 онд өсвөр насны хүн 79, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 32 хүнийг,
3. 2019 оны 3 дугаар улирлын байдлаар өсвөр насны хүн 65, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг 28 хүнийг тус тус хойшлуулсан нь өмнөх онуудтай харьцуулахад жилээс жилд багасаж байгаа үзүүлэлтээс харж болно.

Дүгнэлт

Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахыг практикт хэрэгжүүлснээр 1. Эрүүгийн хуулийн энэрэнгүй байх зарчим хэрэгжинэ.

2. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг заавал хорих ангид ял эдлүүлэхгүйгээр тухайн орчинд нийгэмшүүлэх боломж бүрдэнэ.

3. Хорих ял эдлэх хүний тоо буурч, хоригдлуудад зарцуулах улсын төсөв хэмнэгдэнэ.

Санал

1. Өндөр настай эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганц бие хүнд оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг мөн адил хойшлуулахаар эрүүгийн хуулинд нэмэлтээр тусгах;

2. Эрүүгийн хуулинд гэмт хэргийн “Хүндэвтэр” ангилалыг нэмж тусгах;

2. Өсвөр насны хүнд хариуцлага хүлээлгэх, хэргийг шийдвэрлэх дагнасан мөрдөгч, прокурор, шүүгчтэй болгох тогтоолцоог бий болгох;

⁷⁷ Г.Совд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, (УБ: 2002), 98 дахь тал.

⁷⁸ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрэлэнгийн шүүн таслах ажиллагааны тайлан

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГАА: ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

Н.Манлайбаатар

*Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн тэнхимийн
дэд профессор, цагдаагийн хошууч*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа⁷⁹ нь хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар төрөөс баримталж буй бодлого, үйл ажиллагааг зохицуулж байгаа хэм, хэмжээний цогц билээ.

Гэмт хэрэгтэй тэмцэхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь шуурхай, хүний хууль ёсны эрх ашиг сонирхолд хуульд заасан үндэслэл, журмын дагуу халдах, эрх чөлөөг нь хязгаарлах, мөрдөн мөшгих /нууцаар/ нь гагцхүү Эрүүгийн процессын эрх зүй⁸⁰-н хувьд авч үздэг онцгой зохицуулалт /императив/ бүхий эрх зүйн харилцаа юм.

Нийгмийн харилцаанд зөрчлийн олон хэлбэр оршин байдаг бөгөөд энэ нь тухайн нийгмийн харилцаа хэвийн байгаа эсэх, төр, төрийн байгууллага, бусад байгууллага, хувьд хүнээс ч анхаарч засаж, сайжруулах, боловсронгуй болгох нөхцөл байдал байгаа эсэхийг анхааруулж байдаг.

Ардчилсан /олон ургалч үзэл санааг дэмжигч/ болон чөлөөт эдийн засгийн харилцаа бүхий нийгмийн гол үзэл баримтлал нь эрх чөлөөг аль болох хувьд хүнд чөлөөтэй эдэлүүлэх явдал /номлол, үзэл баримтлал/ бөгөөд бид социалист /нэг ишт үзэл санааг дэмжигч/ чиг баримжаа бүхий төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог өөрчилснөөс хойш 28 жил өнгөрчээ. Энэ хугацаанд хийгдсэн эрх зүйн шинэчлэл нь төрөөс баримтлах гадаад, дотоод бодлого, үндсэн хуулийн байгуулал, нийгэм соёл, эдийн засаг, эрх зүй, улс төр, байгаль орчин, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны гээд бүхий л чиглэлд хийгдсээр ирсэн ба одоо ч үргэлжилж байгаа билээ.

Бид 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр хуульчилсан мөрдөн шалгах бусад ажиллагааны үзэл баримтлалыг авч үзэх юм.

Үндсэн хуулийн 1-р зүйлийн 1.2 дахь хэсэгт "...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"⁸¹ гэж хуульчлан тогтоосон бөгөөд энэ нь Rule of Law гэддэг "эрх зүйт төр"-ийн үзэл санааг бэхжүүлсэн гэж үзэж болох юм. Уг гарлаараа Rule of Law нь 19-р зуунд германы эрх зүйн тогтолцоонд англи-саксоны эрх зүйгээс анх авч хэрэглэсэн⁸² нь өдгөө дэлхийн улс орнуудын эрх зүйн үзэл санааны үндэс болон хөгжиж байна.

Манай улсын хувьд Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийхдээ уг үзэл санаанд нийцүүлэн хийх оролдлого ч мөн сүүлийн 25 жилийн турш хийгдэж байна. Тухайлбал: 1994 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа анх удаа "мэтгэлцэх зарчим"-ыг зохицуулж өгсөн нь эрх зүйт төрийн үзэл санаа эрүүгийн процесст нэвтэрч, нутагшсан бодлогын шинжтэй алхам болсон⁸³ гэж үздэг. Өөрөөр хэлбэл аливаа гэмт хэргийг нотлох ажиллагаа нь яллах болон өмгөөлөх талын үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь мэтгэлцээний зарчимд суурилсан байх тухай номлол хуульчлагдсан байна. Энэхүү

⁷⁹ Цаашид ЭХХШ гэх.

⁸⁰ Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй гэх мэтээр ярьж, бичиж хэвшсэн байдлыг "Эрүүгийн процессын эрх зүй" гэж нэрлэх талаар эрдэмтэн, судлаачид нэгдсэн байр суурьтай байдаг.

⁸¹ Монгол Улсын Үндсэн хууль. Хууль зүйн үндэсний хүрээлэн. 2014 он. 5 дахь тал.

⁸² Хууль зүйн яам, УИХ-ын Тамгын газар. Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо. УБ., 2000 он. 30 дахь талд дэлгэрэнгүй үзнэ үү.

⁸³ Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Зүмбэрэллхам энэ талаар судалгаа хийсэн байдаг.

шилжилтийн чанартай бодлого нь төрөөс баримтлан байгаа гэмт хэрэг мөрдөн мөшгих үйл ажиллагаанд чанарын хувьд томоохон дэвшил болсон гэж үзэх үзэл байгаа нь сайшаалтай.

Дээрх байдлаас үзвэл ЭБШ ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэж өөрчлөх замаар байцаалтаас татгалзсан процесст шилжих шаардлагатай⁸⁴ гэж үзэн Эрүүгийн болон Эрүүгийн процессын шинэчлэлийг өрнүүлсэн байна.

ЭХХШТХ-ын үзэл баримтлалын тухай:

Хууль зүйн ухааны доктор, профессор Д.Баярсайхан⁸⁵ орчин үеийн Эрүүгийн процессын загвар⁸⁶-ыг дараах хэлбэртэй харьцуулан авч үзсэн байдаг.

Д/д	Инквизицийн загвар мөрдөн шалгах тогтолцоо Crime control	Аккусацийн загвар мэтгэлцүүлэн шүүх тогтолцоо Due process
1.	Хэргийн бодит үнэнийг тогтоох зорилготой	Шүүх хэргийг шударгаар шүүх зорилготой
2.	Хэргийг нотлоход шүүгч идэвхтэй бөгөөд голлох үүрэг гүйцэтгэнэ.	Хэргийг нотлоход шүүгч идэвхгүй, төвийг сахисан байр суурьтай ба харин талууд шийдвэрлэх үүрэгтэй
3.	Шүүгч хавтаст хэргийн материалыг шүүх хурлын өмнө уншиж танилцсан байна.	Шүүх хурлаас өмнө шүүгч хавтаст хэргийн материалтай урьдчилан танилцдаггүй.
4.	Гэмт хэрэг бүрийг мөрдөн байцаалт явуулж, шүүхээр шийдвэрлүүлнэ.	Хүнд биш хэрэг болон гэм буруу, хохирлоо хүлээн зөвшөөрч тохиролцсон тохиолдолд шүүхэд шүүхэд шилжүүлэхгүйгээр хялбаршуулж шийдвэрлэнэ. (85-92%)
5.	Өмгөөлөгчийн эрх хязгаарлагдмал, мөрдөн байцаагч, прокурор давуу эрхтэй.	Сэжигтэн, яллагдагчид нотлох баримт гаргах эрхийг өргөнөөр олгож, өмгөөлөгчийг нотлох ажиллагаанд идэвхтэй оролцуулна
6.	Шүүх хуралдаанд хэргийг шинжлэх, хэлэлцэх ажиллагаа мөрдөн байцаагчийн олж цуглуулсан хавтаст хэргийн хэмжээнд мэтгэлцээний бус замаар явагдана. Нотлох ажиллагааг шүүгч гардан удирдаж хэрэгжүүлнэ.	Шүүх хуралдаанд хэргийг шинжлэх, хэлэлцэх ажиллагаа нь талуудын мэтгэлцээнд тулгуурлан явагдана. Нотлох ажиллагааг талууд тодорхойно.

Дээрх харьцуулсан хүснэгтээс ажиглахад бидний үзэж байгаагаар эрүүгийн процессын үзэл баримтлал нь **Инквизицийн загвар** - мөрдөн шалгах тогтолцоо **/Crime control/**, **Аккусацийн загвар** - мэтгэлцүүлэн шүүх тогтолцоо **/Due process/** загварын аль алиныг хольж авч үзэн нь анхаарал татаж байна.

Ийм ч учраас гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх эрүүгийн процессын зорилт нь мөрдөн шалгах ердийн болон тусгай ажиллагаагаар хэрэгжинэ. Уг ажиллагааны үр дүнд эрүүгийн хэргийг шударгаар шийдвэрлэх нөхцөл бүрдэх бөгөөд мэтгэлцүүлэх шүүх явцад гагцхүү хууль хэрэглэх, хуульд заасан үндэслэл, журмын дагуу авсан нотлох баримтаас эцэслэн шийдвэрлэнэ. 2017 он хүртэл үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар Гүйцэтгэх ажлын хуульд заасан ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох асуудал бүрэн зохицуулагдаагүй ирсэн. Гэтэл мэтгэлцүүлэн шүүх процесс 1994 оноос ЭБШ хуульд тусгалаа олсон. Мэтгэлцүүлэн шүүх процесст нотлох баримтын учир холбогдол онцгой. Тодорхой тохиолдолд гүйцэтгэх ажлын үр дүнг шүүхэд танилцуулж шийдвэрлэж байсан тохиолдол энэхүү цаг үед гарч байсан.

Дээр өгүүлсэнчлэн хуульд заасан үндэслэл, журмын дагуу авсан гэдэг нь гагцхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын цуглуулж,

⁸⁴ Энэ талаар хууль зүйн ухааны доктор, профессор Д.Баярсайхан Эрүүгийн процессын эрх зүй бүтээлдээ, энэ талаар бичсэн өгүүлэлдээ тэмдэглэсэн байдаг.

⁸⁵ МУИС-ийн ХЗС-иас “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан”-гаас үзвэл доктор Д.Баярсайхан ЭХХШТХ-ийн талаарх үзэл баримтлал, анхаарах асуудлаар тэмдэглэсэн байна.

⁸⁶ <file:///C:/Users/user-010/Downloads/9. - Д.Баярсайхан - монгол-улсын-эрүүгийн-процессын - тулгамдсан - асуудлууд.pdf> үзнэ үү.

бэхжүүлсэн байх явдлаар хууль зүйн шаардлага, шалгуурыг хангана. Бид эрх зүйт төрийг бэхжүүлэх, төрийн үйл ажиллагаанд гагцхүү хууль дээдлэх зарчмыг үндэс болгож мөрдөн шалгах нууц ажиллагааг хуульчлан бэхжүүлсэн ба үзэл баримтлалын талаас нь анхааран авч үзэх зүйлс байгааг дараах байдлаар дурьдаж байна. Тухайлбал:

1. “Хууль дээдлэх ёсон бол ард түмэн амар амьдрах баталгаа” гэж нэрт эрдэмтэн Б.Чимид агсан хэлсэн нь аливаа заавар, журмаар нийгмийн харилцааг зохицуулах нь эмгэг үүсгэх, тайван бус байдлын илрэл болох талаас нь харжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т “Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно” гэж заасан нь хууль дээдлэх зарчмыг бататгасан хэрэг мөн. Ийм учраас мөрдөн шалгах нууц /тусгай/ ажиллагаа явуулах үндэслэл, журмыг ЭХХШ тухай хуульд бэхжүүлэв.
2. Мөрдөн шалгах нууц ажиллагаа гэж томъёолох нь зохимжтой эсэхээр өнөөдөр судлаачид харилцан адилгүй байр суурьтай байна. Тухайлбал: судлаач А.Лхамсүрэн мөрдөн шалгах тусгай ажиллагаа гэж томъёолох нь зүйтэй тухай тэмдэглэж байна. Энэ нь гадаадын зарим улсуудын Эрүүгийн процессын хуульд тусгаж байгааг дэмжиж байгааг илтгэнэ. Нөгөөтэйгүүр нэршил, агуулга талаасаа өнөөдөр хэрэгжих боломжгүй ажиллагаа ч байгааг харгалзах нь зүйн хэрэг болоод байна. 2012 оноос эрүүгийн болон эрүүгийн процессыг шинэчлэх ажил эрчимтэй өрнөж, хуулиар зохицуулагдаагүй, заавар, журмаар зохицуулагдаж ирсэн ажиллагааг хуульчлах нь зүйтэй гэж үзэв. Хүний эрхийг дээдлэх, хүний эрхийг баталгаатай эдлүүлэх, хууль дээдлэх зарчим агуулгыг гол үзэл баримтлалаа болгож мөрдөн шалгах ажиллагааг хуульчлан бэхжүүлэв.
3. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах арга хэлбэрийг нэмэгдүүлж тусгасан ба мөрдөгч бие дааж явуулах мөрдөн шалгах ажиллагаа, прокурорын зөвшөөрлөөр явуулах мөрдөн шалгах ажиллагааг тодорхойлж, прокурорын зөвшөөрөл авах үндэслэлийг нарийвчлан тусгалаа. Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн болох баримт, мэдээллийн талаар мөрдөгч нууц ажиллагааны магадлагаа үйлдэж, прокуророор баталгаажуулж, хавтаст хэрэгт тусгахаар нэмсэн. Мөрдөн шалгах нууц ажиллагааг мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага, түүнээс эрх олгосон мөрдөгч гүйцэтгэхээр, мөрдөн шалгах нууц ажиллагаанд Улсын Ерөнхий прокурор, түүнээс эрх олгосон прокурор хяналт тавихаар тусгасан нь хууль дээдлэх ёсон Эрүүгийн процесст сайтар шингэсэн гэж үзэх үндэслэлийг бий болгож байна. Өөрөөр хэлбэл Rule of Law гэддэг “эрх зүйт төр”-ийн үзэл санааг бэхжүүлсэн гэж бид үзэж байна.
4. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан байцаалт авах ажиллагааг мэдүүлэг авахаар өөрчилж, мөрдөгч мэдүүлгийг мэдүүлэг авах шаардлага хангасан өрөөнд, шаардлагатай бол мэдүүлгийг тухайн хүний байгаа газарт нь очиж авч болохоор заасан. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааны явцад эрүү шүүлт гарахаас сэгийлэх учир холбогдол бий болгоно. Шүүх хуралдаанд гэрч, хохирогч, дүгнэлт гаргасан шинжээч биечлэн оролцож мэдүүлэг өгөх боломжгүй тухай мөрдөгчийн санал, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл прокурор нь түүнээс дуу-дүрсний бичлэг ашиглан мэдүүлэг авахыг мөрдөгчид даалгаж болохоор тусгасан хэдий ч практикт энэхүү нөхцөл байдал бүрэн биелэлээ олоогүй, техник эдийн засгийн боломж хомс байгааг бид анхаарах хэрэгтэй.
5. Улс төрийн зорилгоор Мөрдөн шалгах нууц ажиллагаатай холбоотой зарим асуудлыг хэт дэвэргэх хандлага гарч, тодорхой хэмжээнд бүрэн дүүрэн үзэл баримтлал нь тогтоогүй, өнөөдөр хэрэгжүүлэхэд бодит хүндрэл гарч байгааг бид эргэн авч үзэх шаардлагатай байна. Нэгэнт мэтгэлцүүлэн шүүх үзэл санаа Эрүүгийн процесст тусгагдсан нь нууц ажиллагааны үр дүнг хэргийн материалд хавсаргах зүйн шаардлагыг нөхцөлдүүлж байна. Энэ нь эрүүгийн процесс дахь дэвшилтэт үзэл баримтлал юм.
6. Цаашид мөрдөн шалгах нууц ажиллагааны үзэл баримтлалыг хууль дээдлэх үзэл санааны үндэс дээр нухацтай авч үзэх зүй ёсны шаардлага байгаа билээ. Өөрөөр хэлбэл практик төлөөлөл, эрдэмтэн судлаачдын төлөөлөл, орон орны туршлага, алдаа оноог дэнслэн хуульчлах явдал чухал юм.

Дээрх нөхцөл байдлаас үзвэл мөрдөн шалгах тусгай ажиллагаанд “Эрх зүйт төр”-ийн үзэл санаа “хууль дээдлэх зарчим” бага ч болов шингэсэн болохыг авч үзэв.

---ooOoo---

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БА ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХОД АНХААРАХ АСУУДАЛ

*Б.Баянмөнх
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЦЭЗТ-ийн дэд профессор,
цагдаагийн дэд хурандаа*

Товч утга: Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг өөрийн хүч хэрэгсэл дээрээ тулгуурлан зохион байгуулж хэрэгжүүлж байгаа ч өнөөдөр зарим төрлийн гэмт хэрэг, зөрчил нэмэгдэх хандлагатай байгаа нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны онолын үндсэн чиглэл тодорхой бус, олон урсгал чиглэлээр салбарлаж үйл ажиллагаагаа явуулж байгаа, урьдчилан сэргийлэх ажил хангалттай хэмжээнд явагдаж чадахгүй байгаа, түүнчлэн удирдлага, зохион байгуулалтын оновчгүй хэлбэрт баригдсан, нөгөө талаараа эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус байгаа зэрэг олон хүчин зүйлээс хамаарч гэмт хэрэг, зөрчил буурахгүй байна гэж судлаачийн хувьд үздэг билээ.

Монгол Улсын засаг захиргааны анхан шатны баг, хороог хариуцан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулж, иргэдийн дунд ажилладаг алба хаагч бол цагдаагийн хэсгийн байцаагч юм.

Энэхүү өгүүлэлээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох онолын үндэс, түүнчлэн цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааг зохицуулж буй “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг боловсронгуй болгоход гадаадын зарим орны туршлагыг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа талаар авч товч үзсэн болно.

Түлхүүр үг: Онол, чиглэл, заавар, эрх зүйн зохицуулалт.

Үндсэн хэсэг

Орчин үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны чиг хандлагыг Их Британийн цагдаа судлаач Роберт Пийл тодорхойлохдоо чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц гэсэн үндсэн асуудлыг хөндөж тависан байдаг.

Орчин цагийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл нь “reactive” буюу гомдол мэдээлэлд тулгуурласан үйл ажиллагаа, “Proactive” буюу өөрсдийн идэвхи санаачилгаар чиг үүргээ биелүүлэх үйл ажиллагаа гэсэн 2 хэсэгт хуваагдаж байна.

Манай улсын цагдаагийн байгууллага орчин үеийн цагдаа болж хөгжих зорилго тавьсан бол өөрсдийн идэвхи санаачилгаар нийгмийн сөрөг үзэгдэл дунд нэвтэрч тэдгээрийн мөн чанарыг цаг алдалгүй танин мэдэх “Proactive” үйл ажиллагаа бидэнд хэрэгтэй юм.

Өнөөдөр цагдаагийн байгууллагад үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэлийг нарийвчлан шинэчлэн тодорхойлох, хууль сахиулах ажлын арга барил, хэлбэр, удирдлага, зохион байгуулалтаа нийгмийн бодлого, өөрчлөлттэй уялдуулан шинэлэг, үр дүнтэй арга механизмаар солих, баримтлах онолын үндсээ зөв тогтоох шаардлага зүй ёсоор гарч байна.

Манай улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа ямар онолын урсгал чиглэл тохирох эсэхийг нарийвчлан тодорхойлох, түүнд тохирсон хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зэрэг нь өнөөдрийн тулгамдсан асуудал болоод байна.

Өнөөдөр манай улсын цагдаагийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагааг бүхэлд нь ажиглаваас асуудалд тулгуурласан цагдан сэргийлэлт (Problem-oriented policing)-н аргыг ихэвчлэн ашиглаж үйл ажиллагаагаа явуулж байна гэж үзэж болохоор байна.

Асуудалд тулгуурласан цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг гарч буй үндсэн учир шалтгаануудыг тодруулж, улмаар түүнд тохирох хариу арга хэмжээнүүдийг янз бүрийн шинэлэг арга барилаар хэрэгжүүлэх зорилготой явуулдаг арга юм.

Problem-Oriented Policing буюу асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн цагдаагийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх цагдаагийн үйл ажиллагааны (Тухайлбал, хөтөлбөр, төлөвлөгөө) үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч шийдлээ тодорхойлох явдал байна.⁸⁷

Харин судлаач миний хувьд манай улсын цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны онолын үндсэн чиглэл нь шинээр гаргаж ирсэн “Аюулгүйн баянбүрд” онол байх болно гэж үзэж байна.

Манай цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бүхий л онолын урсгал чиглэл, үзэл баримтлалууд нь цагдаагийн үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр нэвтрээд тодорхой хугацаа өнгөрсөн хэдий ч хангалттай үр дүнд хүрэхгүй, гэмт хэрэг, зөрчил буурахгүй, нэмэгдсээр байгаа нь асуудлыг өөр өнцгөөс авч үзэх цаг болжээ гэж үзэж байна.

Судлаачийн хувьд “Аюулгүй баянбүрд” гэсэн онолын үзэл баримтлалыг шинээр гаргаж, өнөөгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд баримтлах бодлого чиглэлд өөрчлөлт шинэчлэлт оруулах шаардлага байна гэж үзлээ.

“Аюулгүйн баян бүрд” онолын агуулга нь цагдаагийн байгууллагын явуулж буй бүхий л үйл ажиллагааны эх үндэс нь улс, бүс, хот, дүүрэгт бус харин засаг захиргааны анхан шатны баг, хороон дээр тулгуурласан үйл ажиллагаанд анхаалаа хандуулах, түүнд тохирсон бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчныг бий болгох замаар хэсгийн байцаагчид тодорхой эрх мэдлийг өгч, баг, хорооны нутаг дэвсгэрт урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэн тогтворжуулсанаар гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, нөгөө талаараа иргэдэд аюулгүйн баталгаа өгөх нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Гэхдээ энэхүү онолын үзэл баримтлал нь дан ганц цагдаагийн байгууллагын явуулж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, захиргааны хяналтын үйл ажиллагаанаас хамаарахгүй, харин төрийн тусгай чиг үүрэг хүлээсэн төрийн бүхий л байгууллагууд харилцан, хамтарч засаг захиргааны анхан шатны баг, хорооноос ажлаа эхлэн бүрэн аюулгүйн баталгаа өгөх нөхцлийг бүрдүүлэх явдал юм.

Тухайн нутаг дэвсгэрийн цагдаа, онцгой байдлын алба, мэргэжлийн хяналт, эмнэлгийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллага, тэр дундаа баг, хорооны ажилтан, алба хаагчид бүгд баг, хороо руу чиглэсэн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулж, үйл ажиллагааныхаа удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн орчныг бүрдүүлж чадвал онол хэрэгжих бүрэн боломжтой юм. Тухайлбал:

№	Байгууллага	Харъяалах үүрэг	Хүрэх үр дүн
1.	Цагдаагийн байгууллага	Баг, хорооны нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил гарах бүхий л нөхцлийг арилгах, объектын судалгааг бүрэн хийх замаар камерын хяналтанд авах, урьдчилан сэргийлэх ажлыг иргэд, олон нийтийн тусламж дэмжлэгтэйгээр явуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих захиргааны хяналтыг цагдаагийн хэсэгт хамаарах алба хаагчдын /мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, хорооны цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан/ тусламжтайгаар явуулах	Аюулгүй ажиллаж амьдрах орчин нөхцөл бүрдэнэ.
2.	Онцгой байдлын байгууллага	Баг, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн орон сууц, хашаа байшин, аж ахуйн нэгж, байгууллагуудын байшин барилгад гал түймрийн аюул гарах бүхий л шалтгаан нөхцлүүдийг арилгах замаар хяналтыг бүрэн тавьж галын аюулгүй орчин бүрдүүлэх	Галын аюулгүй байдал хангагдана.
3.	Мэргэжлийн хяналтын хэлтэс	Баг, хорооны нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бүх аж ахуйн нэгж, байгууллагууд эрүүл, чанарын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдаалах	Хүнсний аюулгүй байдал хангагдана.
4.	Аймаг, дүүргийн ЗДТГ	Баг, хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг бүхий л аж ахуйн нэгж, байгууллагын үйл	Эрх зүйн дэг журам

⁸⁷ Community-Oriented Policing: Effect and Impact (Greene, 2007. P196 in The encyclopedia of Police Science

		ажиллагаанд харьяалах чиглэлээрээ хяналтыг тавьж, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх замаар үйл ажиллагааг нь зогсоох эрх бүхий албан тушаалтын саналыг хангаж ажиллах	хангагдана.
5.	Эрүүл мэндийн байгууллага	Баг, хороо хариуцсан эрүүл мэндийн төв нь иргэн бүрт эрүүл ахуйн тусламж үйлчилгээг түргэн шуурхай хүргэж, иргэдийнхээ эрүүл мэндийн байдалд нь бүрэн хяналт тавих	Эрүүл мэндийн аюулгүй байдал хангагдана.
6.	Баг, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтнууд	Хариуцсан хорооныхоо иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагуудын талаархи судалгааг бүрэн хийж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнуудыг шаардлагатай мэдээллээр бүрэн хангах	Баг, хорооны иргэн, байгууллагын талаар бүрэн мэдээлэлтэй болно.

Дээр дурдагдсан төрийн бүхий л байгууллагууд засаг захиргааны анхан шатны баг, хорооны нутаг дэвсгэрт анхаарлаа хандуулан үндсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж, аюулгүй орчин нөхцлийг бүрдүүлсэнээр “Аюулгүй баян бүрд” онол хэрэгжиж, аюулгүйн баталгаа өгөх боломжтой болно.

Харин энэхүү онолыг хэрэгжүүлэгч гол албан тушаалтан бол иргэдтэй хамгийн ойр байж, тэдний итгэл дээр тулгуурлан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа явуулдаг алба хаагч бол цагдаагийн хэсгийн байцаагч юм.

Нөгөө талаараа иргэд, олон нийт цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын ур чадвар, үйл ажиллагааны үр дүнгээр нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь үнэлж дүгнэх нь цөөнгүй байна.

Өнөөдөр цагдаагийн хэсгийн байцаагч нь Цагдаагийн албаны тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх 4, нийтийн хэв журам хамгаалах 7, олон нийтийн аюулгүй байдлыг хангах 5, захиргааны хяналтын 3 үүрэг, мөн бусад хууль тогтоомжоор цагдаагийн байгууллагад үүрэг болгосон зарим хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, түүнчлэн нутгийн захиргааны байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актийн хэрэгжилтийг хангах, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлагаас, гаргасан тушаал шийдвэр, өгсөн үүрэг даалгаварыг өөрийн хариуцсан нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагчид хүлээлгэсэн дээрхи бүхий үүрэг нь үндсэн ажил болох гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг явуулахад сөргөөр нөлөөлж, гэмт хэрэг, зөрчил буурахгүй байгаатай холбон үзэж болохоор байна.

Өнөөдөр хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам сахиулах ажлын арга барил шинэчлэгдэхгүй, удирдлага, зохион байгуулалтын оновчгүй хэлбэрт баригдан ажлын үр нөлөө төдийлөн дээшлэхгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус, өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж чадахгүй байгаа нь хэсгийн байцаагчийн зааврыг шинэчлэх зайлшгүй шаардлага бий болсноор харж болно.

Зөвхөн БЗД-ийн 5-р хороон дээр жишээ авч үзвэл 2017-2019 оныг оролцуулан сүүлийн 3 жилийг авч үзвэл нийт 3108 зөрчил гарч, түүнийг шийдвэрлэсэн албан тушаалтнууд дээр судалгаа хийж үзвэл нийт зөрчлийн 48%-ийг хэсгийн байцаагч шалган шийдвэрлэсэн нь түүний урьдчилан сэргийлэх үндсэн ажлаа явуулах боломж нөхцөл байхгүй байна гэж үзэх бүрэн боломжтой байна. Энэ нь тухайн хороонд гарсан бүх зөрчлийг шалгадагаас шууд хамааралтай юм.

Манай цагдаагийн “Хэсгийн байцаагчийн ажлын заавар” нь 2003 онд батлагдан хэрэгжсэнээс хойш өнөөдрийг хүртэл 16 жил шинэчлэгдээгүй өнөөдрийг хүрсэн байна.

Гэтэл Орос холбооны улс энэ хугацаанд цагдаагийн хэсгийн байцаагчийнхаа заавар, журмыг 2 удаа шинэчлэн боловсруулж, хамгийн сүүлд Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны сайд, цагдаагийн генерал В.Колокольцевын 2019 оны 3 дугаар сарын 29 –ны өдрийн № 205 тоот тушаалаар “Хэсгийн байцаагч хариуцсан засаг захиргааны нэгжид албаны үүрэг гүйцэтгэх журам”, “Хэсгийн байцаагчийн албыг зохион байгуулах заавар” нэртэйгээр 2 бүлэг заавар, журмыг батлан гаргаж, хэрэгжүүлж эхлээд байна.

Энэ журмын онцлог нь хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд дараах дэвшлийг тусгаж чадсан байна. Үүнд:

- Цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, түүний хамрах хүрээг нарийвчлан тодорхой зааж өгсөн;
- Хэсгийн байцаагчийн шалгах зөрчлийн хамрах хүрээг нарийвчлан тодорхойлж, зөвхөн өөрт харъяалах зөрчлийг шалгах нөхцлийг бүрдүүлж өгч чадсан;
- Хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг нутаг дэвсгэрийн засаг захиргааны онцлог, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал зэргийг харгалзан нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын дарга тогтоож болохоор тусгаж өгсөн;
- Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын цагийн хуваарийг нарийвчлан тусгаж өгсөн;
- Хэсгийн байцаагчийн ажлын байранд ашиглагдах техник хэрэгсэл, эд зүйлийн жагсаалтыг гаргаж, хариуцах албан тушаалтанг тодорхой зааж өгсөн;
- Цагдаагийн хэсгийн байцаагчийн байрлан ажиллаж буй байрны гадна талд “Хэсгийн байцаагчийн мэдээллийн самбар”-ыг байрлуулж, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ, гомдол мэдээлэл хүлээн авах, хийсэн ажлын тайлан тавих талаар мэдээлэлийг байршуулахаар тусгасан;
- Нутаг дэвсгэрийн иргэдийн өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах өдөр, цагийг нарийвчлан тодорхой зааж өгсөн;
- Урьдчилан сэргийлэх эргүүл хийх цагийн хуваарийг нарийн зааж өгсөн;
- Цагдаагийн хэсгийн байцаагчийн “нэрийн хуудас”-ийг бий болгож, иргэдэд мэдээлэл хүргэх нэг хэрэгсэл болгож өгсөн;
- Ажлын байрны хаалганы материал, цонхны төмөр сараалжин хаалт, ханын зузаан гэх мэт орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангах чиглэлээр тодорхой шалгууруудыг нарийн зааж өгсөн;

Харин манай хэсгийн байцаагчийн ажлын зааварт гүйцэтгэх үүргийг нарийвчлан заасан боловч хэрэгжүүлэх арга замыг тодорхой тусгаагүй, үйл ажиллагааны хамрах хүрээг хэт өргөн байдлаар тусгасан, хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээ том, хүн амын тоо их /зарим тохиолдолд сумын төвийн хүн амаас 5-8 дахин их/ байгаагаас хэсгийн байцаагчийн үндсэн үүргийн хэрэгжилтийн үр дүн буурах нэг хүчин хүчин зүйл болсон байна.

Тиймээс цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, түүний хамрах хүрээ, ажлын хуваарийг нарийвчлан нарийвчлан тодорхой болгох, хариуцах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг цагдаагийн байгууллагын дарга өөрөө тогтоож болох, хэсгийн байцаагчийн харъяалан шалгах зөрчлийг тодорхой болгох, хэсгийн байцаагчийн ажлын байр, үйл ажиллагаанд ашиглагдах техник хэрэгсэл, эд зүйлийн жагсаалтыг гаргаж бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хэсгийн байцаагч бүр “Цагдаагийн хэсгийн мэдээллийн самбар”-ыг гаргаж ажиллуулах, мөн “нэрийн хуудас”-тай болгох зэрэг олон асуудлыг шинээр тусгах нь зүйтэй болоод байна.

Дээрхи зүйлүүдийг хэсгийн байцаагчийн ажлын зааварт тусгаж эрх зүйн орчныг бүрдүүлж чадваас зааварт заасан үндсэн үүргээ биелүүлэх боломж нэмэгдэхийн зэрэгцээ хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах, ард иргэдтэй ойр дотно байж хамтран ажиллах нөхцөл боломж бүрдэх, нөгөө талаараа ажлын ачаалал буурч, урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулж явуулж, гэмт хэрэг, зөрчил буурна гэж үзэж байна.

Дүгнэлт

Өнөөдөр манай цагдаагийн хэсгийн байцаагчийн явуулах үйл ажиллагааны хамрах хүрээг нарийвчлан тодорхой болгоогүйгээс хэт өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндсэн үүргээ хэрэгжүүлэх боломж нөхцөл хязгаардлмал болгосон байна. Нөгөө талаараа хэсгийн байцаагч нар зөрчлийн шинжтэй өргөдөл, гомдол шалгах ажиллагаанд ихэнхи цагаа зарцуулж байгаа нь үндсэн үүргээ хэрэгжүүлэх боломжийг бууруулсан байна.

Энэ нь цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагааг зохицуулж буй “Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын заавар” өнөөг хүртэл шинэчлэгдээгүй, 16 жил үйлчилж байгаатай салшгүй холбоотой бөгөөд өнөөгийн нийгмийн шаардлагыг хангаж чадахгүй байгаатай холбон үзэж байна. 2003 оноос хойш энэ хугацаанд Цагдаагийн албаны тухай хууль болон үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа олон хууль тогтоомж шинэчэгдсэн боломж, хэсгийн байцаагчийн заавар шинэчлэгдээгүй хуучин хэвээрээ байгаа нь тулгамдсан асуудал болсон байна.

Тиймээс тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нэг алхам бол “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-ыг түргэн хугацаанд шинэчлэн боловсруулж мөрдүүлэх явдал гэж судлаачийн хувьд үзэж байна..

Санал

Цагдаагийн хэсгийн байцаагчийн ажлын зааварыг шинэчлэн боловсруулахад дараах зүйлийг тусгаж чадваас хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа сайжирч, гэмт хэрэг, зөрчил буурах нэг нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Үүнд:

1. Цагдаагийн хэсгийн байцаагчийн гүйцэтгэх үүрэг, түүний хамрах хүрээ, ажлын хуваарийг нарийвчлан нарийвчлан тодорхой болгох;
2. Хэсгийн байцаагчийн хариуцах нутаг дэвсгэрийн хил хязгаарыг нутаг дэвсгэрийн онцлог, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал зэргийг харгалзан цагдаагийн байгууллагын дарга өөрөө тогтоож болох зохицуулалтыг оруулж өгөх;
3. Хэсгийн байцаагчийн шалгах зөрчлийг тодорхой болгож, зөвхөн өөрт харъяалах зөрчлийг шалгадаг байхаар тусгах;
4. Хэсгийн байцаагчийн ажлын байр, үйл ажиллагаанд ашиглагдах техник хэрэгсэл, эд зүйлийн жагсаалтыг гаргаж, тусгах;
5. Цагдаагийн хэсгийн байрны гадна талд “Цагдаагийн хэсгийн мэдээллийн самбар”-ыг байрлуулж, иргэдтэй уулзах, гомдол мэдээлэл хүлээн авч уулзах өдөр, цаг, харъяалан шалгах зөрчлийн талаархи мэдээлэлийг байршуулахаар тусгах;
6. Цагдаагийн хэсгийн байцаагчийн “нэрийн хуудас”-ны загвар, доторхи мэдээллийн агуулгыг гаргаж, иргэдэд мэдээлэл хүргэх нэг хэрэгсэл болгох талаар тусгаж өгөх;

---oOo---

АЛБАНЫ НОХОЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, АШИГЛАХ АРГАЧЛАЛ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ш.Чулуун

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Дотоодын цэргийн
тэнхимийн ахлах багш, цагдаагийн дэд хурандаа*

Тухайн үеийн ЗХУ-аас авч байсан тусламжийн хүрээнд Монгол улс нь 1934 онд улсын хил хамгаалах албаны үйл ажиллагаанд албаны нохойг авч ашиглаж эхэлсэн нь төрийн тусгай албанд албаны нохойг ашиглах үндэс суурь нь болсон гэж үздэг.

Харин Цагдан сэргийлэх байгууллага нь 1940-өөд оны эхнээс гэмт хэрэгтэй тэмцэх ажилд сургуультай нохойг ашиглаж эхлэх бодлого явуулж 1944 оны 07- сарын 01-нээс эхлэн Улсын цагдан сэргийлэх газрын Гүйцэтгэх албаны хэлтсийн 3-р тасагт нохойг ашиглах, боловсруулах, хөтлөгчийн орон тоо 2-ыг бий болгож лейтенант Цэвээнжав, Адилбиш нарыг томилж байснаар цагдаагийн албаны нохойн хэлтсийн эх үүсвэрийг тавьж байжээ.⁸⁸

Монгол улсын Цагдаагийн байгууллагад албаны нохойг ашигласан түүхийг дараах 3 үе шатанд хувааж үздэг байна. Үүнд:

1. Албаны нохойн алба үүсч бүрэлдсэн үе /1944-1960 он/

Анх байгуулагдахдаа Цагдан сэргийлэх байгууллага нь өөрийн гэсэн нохойгүй байсан ба байсан ба 1952 онд Зөвлөлт Холбоот Улсаас эм хүйсний, нас нэлээн ахисан “Жульбарс” дуудлагатай нохойг 1500 төгрөгөөр худалдан авч байжээ.

2. Нохойн алба хөгжин цэцэглэсэн үе /1960-1990 он/

1957 онд ЗХУ-аас 2, 1960 онд БНЧАУ-аас 3, 1977 онд БНАГУ-аас 20 нохой худалдан авч мөн дотооддоо 1961 онд 2, 1965 онд 1, 1968 онд 16, 1974 онд 10, 1981 онд 10, 1985 онд 12, 1987 онд 10, 1988 онд 15, 1989 онд 9 нохойг сурган бэлтгэж байсан байна.

1964-1968 онд нийт 27 нохой ашиглаж 634 хэргийн газар очиж, 428-д нь нохой ашиглаж, 242 хэргийг илрүүлсний дотор 50 хэргийг шууд илрүүлэн тогтоож, 192 хэрэгт чиглэл гаргаж өгснөөр бүх хэргийн 57,9 хувийг илрүүлж байжээ.

Мөн 1969-1973 оны хооронд 68 нохой ашиглаж 819 хэргийн газар очиж 437 хэрэгт нохой ашиглан 303 хэргийг илрүүлсний дотор 215 хэргийг шууд олж, 88 хэрэгт чиглэл тогтоож өгсөн нь бүх хэргийн 69,4 хувийг илрүүлж өмнөх 5 жилээсээ өссөн байгаа нь Цагдан сэргийлэх байгууллагын эрэлч нохойн албаны бүх үйл ажиллагаа өсөн бэхжиж байсныг харуулсан явдал юм.

1968 оны 08-р сарын 24-ний Улсын Цагдан сэргийлэх газрын даргын 406 тоот тушаал гарч төв, орон нутагт эрэлч нохдын байр бариулах сургалтанд 15 хүнийг 9 сарын хугацаатай ЗХУ-д явуулахаар шийдвэрлэж байжээ.

1961 онд Сэлэнгэ, Дорнод, Дорноговь, 1962 онд Дархан, 1963 онд Увс, 1969 онд Өвөрхангай, Архангай, 1970 онд Төв, 1973 онд Завхан, Хөвсгөл аймгууд эрэлч нохойн албатай болсон байна.

1969 оны 06-р сарын 01-ний өдрийн НАХЯ-ны сайдын 266 тоот тушаалаар эрэлч нохойн албаны группын дарга-1, зоотехникч-1, нохой хөтлөгч офицер-6, хөтлөгч ахлагч-8, гөлгөн нохой маллагч-1, тогооч-1 бүгд 18 хүний орон тоотой нохойн албыг байгуулж байжээ.

3. Нохойн албаны хөгжлийн өнөө үе /1990 оноос хойш/

1992 онд Хилийн ба Дотоодын цэргийн 0267-р тусгай салбарыг ЦЕГ-ын Эрэлч нохойн групптэй нэгтгэж, Цагдаагийн Ерөнхий газрын Албаны нохойн тасгийг байгуулан үйл ажиллагааг нь тэлж шинэ бүтэц, орон тоо, зохион байгуулалтаар ажилласан бөгөөд улмаар Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 229 тоот тушаалаар Сургалт, дадлагын төвийн “Албаны нохой, морь сургалтын хэсэг” болгон шинэчлэн өөрчлөгджээ.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр Улаанбаатар хотын Цагдаагийн газрын харъяа Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүрэг дэхь хэлтсүүдийн жижүүрийн шуурхай албанд албаны нохойн туслах төлөөлөгчийг албаны нохойн хамт 3 ээлжээр 24 цагаар гэмт хэрэг, учралын газарт шууд ба шууд бус хэлбэрээр ашиглаж гэмт хэрэг илрүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

⁸⁸ “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 83-р тал

Цагдаагийн Ерөнхий газрын харъяа Сургалтын төв нь 2014 онд хууль эрх зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Их хурлаар батлагдсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн дагуу Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 226 дугаар тушаалаар Сургалтын хэлтэс, Албаны нохой, морь сургалтын тасаг, Хээрийн сургалтын хэсэг гэсэн 3 нэгжтэй байгуулагджээ.

Улмаар тус Сургалтын төв нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2016 оны Б/180 дугаар тушаалаар 3 хэлтэс, 2 хэсэг, нийт 81 орон тоотойгоор шинэчлэн батлагдсан. Үүний нэг хэлтэс болох “Албаны нохойн хэлтэс” нь хэлтсийн дарга 1, үржлийн хэсгийн дарга бөгөөд их эмч 1, ахлах дасгалжуулагч 1, үнэрийн лабораторийн эрхлэгч 1, дасгалжуулагч 1, мэргэжилтэн 4, нохойн төлөөлөгч 16, жижүүрийн цагдаа 4, үржлийн зоотехникч 1, бага эмч 1, лаборант 1, цагдаа-жолооч 2, үйлчлэгч 1, нохой маллагч 2, нохойн тогооч 2 нийт 39 орон тоотойгоор ажиллагааг бүтэц, орон тоог нь шинэчлэн баталж үйл ажиллагааг нь өргөжүүлжээ.

Энэ нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах цагдаагийн албаны үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх үйлсэд албаны нохойн гүйцэтгэх үүрэг чухал ач холбогдолтойг илтгэн харуулсан явдал болсон юм.

Шинэчлэн баталсан Цагдаагийн албаны тухай хуулинд цагдаагийн алба хаагч гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, авран хамгаалах зорилгоор албаны нохой ашиглаж болно⁸⁹ гэж тусгасан нь алба, үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд албаны нохойг ашиглах эрх зүйн зохицуулалт, эрхийг хангаж өгсөн явдал болсон юм.

Мөн цагдаагийн алба хаагч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй, зэвсэглэсэн этгээд зугтаасан, довтолсноос бусад тохиолдолд хүний эсрэг албаны нохой ашиглахыг хориглоно гэж Цагдаагийн албаны тухай хуулинд тусгайлан зааж өгсөн байна.⁹⁰

Цагдаагийн албаны тухай хуулийн 56.3-д заасны дагуу Цагдаагийн Ерөнхий газрын даргын тушаалаар “Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах” журам⁹¹ шинээр батлагдан гарчээ. Тус журамд албаны нохойг хэрхэн бэлтгэх, үйл ажиллагаанд ямар байдлаар ашиглах, анхаарах болон хориглох зүйл, албаны нэгдсэн нэр томъёо гэх зэрэг асуудлыг нарийвчлан тусгаж өгчээ.

Тус журамд дурдсан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгохоор тусгаж өгсөн байна.⁹² Тухайлбал:

“Албаны нохойг бэлтгэх” – Цагдаагийн байгууллагад албаны зохих шалгуур хангасан нохойг үржүүлэх, сонгон шалгаруулан авч эрэл, мөрдлөг, эргүүл, харуул хамгаалалт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис болон тэсэрч дэлбэрэх бодис олж илрүүлэх аврах эрэн хайх, үнэрийн харьцуулалтын чиглэлээр сургах үйл ажиллагааг

“Албаны нохойг ашиглах” – Цагдаагийн байгууллага нь албаны нохдыг гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, авран хамгаалах үйл ажиллагаанд ашиглахыг

“Албаны нохойг хамгаалах” – Албаны нохойг албан үүргээ гүйцэтгэхээс бусад үед нь амраах, арчлах, маллах, тэжээх, эмчлэх, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эмчилгээ сувилгаа хийх, тээвэрлэх, үедээ аюулгүй байдлыг нь ханган ажиллах үйл ажиллагааг

“Албаны нохой” – Төрөл мэргэжлийн сургалтад хамрагдаж шалгалтад тэнцэж, батламж олгогдон албанд ашиглаж буй нохойг

“Дасгалжуулагч” – Албаны нохой болон нохойн төлөөлөгч, хөтлөгч нарыг сургаж, бэлтгэх онолын болон дадлагын хичээл, давтан сургалтыг биечлэн удирдан ажиллаж буй цагдаагийн алба хаагчийг

“Нохойн төлөөлөгч” – Гэмт хэргийн газарт хэрэг илрүүлэх зорилгоор гэмт этгээдийн үлдээсэн ул мөрний үнэрээр албаны нохойг ашиглан хэргийн сэжиглэлийг зөв тогтооход тусалцаа үзүүлж буй цагдаагийн алба хаагчийг

⁸⁹ Цагдаагийн албаны тухай хуулийн 56-р зүйлийн 56.1 дэх заалт

⁹⁰ Цагдаагийн албаны тухай хуулийн 56-р зүйлийн 56.2 дахь заалт

⁹¹ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаал

⁹² ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 1-р зүйлийн 1.2 дахь хэсэг

“Хөтлөгч” – Эргүүл, харуул хамгаалалтын мэргэжлийн сургалтад хамрагдан нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах ажилд албаны нохойг хөтлөн оролцуулж буй цагдаагийн алба хаагчийг

“Үржлийн мал зүйч” – Үржлийн нохойд үржил, селекцийн ажлыг төлөвлөлтийн дагуу явуулж байгаа тусгай мэргэжилтэй цагдаагийн алба хаагчийг

“Гөлгөн нохойн дасгалжуулагч” – Гөлгөн нохдыг 2 сартайгаас эхлэн 6 сар хүртэлх хугацаанд сургалтын бэлтгэл хангах, нийгэмшүүлэх сургалтыг биечлэн удирдан ажиллаж буй цагдаагийн алба хаагчийг

“Нохой маллагч” – Албаны нохойн арчилгаа, маллагаа, хооллолт, байрны цэвэрлэгээ болон гөлгөн нохой бойжуулах ажлыг биечлэн хариуцсан ажилтныг

“Үржүүлэг” – Албаны нохойн нөхөн хангалт тоо, толгойг олшруулах үүлдэрлэг болон албаны чанарыг сайжруулах зорилгоор үржилд сонгож авсан эр, эм нохойг нийлүүлэгт оруулахыг

“Имитатори” /үнэр орлуулагч/ - Албаны нохойн тусгай сургалтад ашиглах ОУ-ын ТУ-2643-007-6157304609 техникийн нөхцлүүдэд нийцсэн мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, цогцосны үнэр орлуулагчаар бүрдсэн иж бүрдлийг

“Тоног хэрэглэл” – Нохойн хүзүүвч, хушуувч, өргөст хүзүүвч /парафорс/, цээживч, урт богино оосор, гинжин оосор, тоног хэрэглэлийн цүнхийг

“Сургалтын хэрэглэгдэхүүн” – Дэлхийн нохойн спортын холбоо /IFCS/-ны дүрмээр зөвшөөрөгдсөн, олон улсын нохой хөтлөгчдийн холбоо /FCI/-ны дүрмээр баталгаажсан албаны нохойн бие бялдрын хөгжилтөнд нөлөөлж түүнийг хурдан шаламгай, зоригтой хөдөлгөөний эвсэлтэй болгодог төрөл бүрийн саад, хаалт, шуудуу, шат, дамнуур, хөөж барилтын хувцас, ханцуйвч, савааг

“Нохойн байр”–Албаны нохойг байрлуулж буй нохой амрах, унтах зориулалтын байрыг

“Үржлийн нохойн байр” – Үржлийн хээлтэй нохдыг өвөл, зуны улиралд гөлөглүүлэх нэмэлт дулаалгатай, нохой маллагч хяналт тавих цонхтой, нохой, гөлөг амрах, унтах зориулалтын байрыг

“Гөлгөн нохойн байр” - Гөлгийг эхээс салгасны дараа 5-6 сарын настай болтол хэсэг, бүлгээр байрлуулдаг зориулалтын байрыг

“Зугаалгын талбай”–Албаны нохойн биеийн эрүүл мэнд, өнгө үзэмж, ажлын хүчин чадлыг хэвийн байлгах зорилгоор агаар, нар салхинд тодорхой хугацаагаар зугаалуулах сүүдрэвчтэй элс олон хайрган дэвсгэртэй, тороор хамгаалагдсан хашааг гэж тус тус нарийвчлан тодорхойлж өгчээ.

Албаны нохдыг эзэмшиж, ашиглаж байгаа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас нохойн захиалгаа тухайн оны 11 дүгээр сарын 15-ны дотор багтаан Сургалтын нэгдсэн төвд ирүүлнэ.

Тухайн жилд бэлтгэх албаны нохойн төлөөлөгч, хөтлөгч, нохойны тоо, сургалтын хөтөлбөрийг Цагдаагийн байгууллагын сургалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгаж Цагдаагийн төв байгууллагын дарга батална.⁹³

Сургалтын нэгдсэн төв нь захиалгат байгууллагаас ирүүлсэн эрэлт, хэрэгцээ, шаардлагад үндэслэн албаны зохих шалгуур хангасан нохдыг бэлтгэж, хангах үүргийг хүлээнэ. Албаны нохой, нохойн төлөөлөгч /хөтлөгч/-ийн сургалтын шалгалтыг батлагдсан норм, нормативын дагуу авч тэнцсэн нохойн төлөөлөгч /хөтлөгч/-д гэрчилгээ, нохойд батламжийг Сургалтын нэгдсэн төв олгоно.

Албанд нохойг сонгон авах үндэслэл нь:

а/ албанд тэнцэх нохойг үржлийн хэсгийн байранд төрсөн гөлөгнөөс болон тухайн байгууллагын захиалгад нийцүүлэн хувь хүн, нохойн үржлийн газруудаас худалдан авч болно.

б/ албанд нохойг сонгохдоо мэргэжлийн комисс томилж тусгай шалгуурын дагуу авна. Мэргэжлийн комисс нь мэргэжлийн дасгалжуулагч, үнэрийн лаборторийн эрхлэгч, малын эмч, мал зүйчээс бүрдэнэ.⁹⁴

⁹³ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 2-р зүйлийн 2.2 дахь хэсэг

⁹⁴ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 2-р зүйлийн 2.5 дахь хэсэг

Албанд тэнцэх гөлгийг үүлдэр, үйл ажиллагааны чиглэлээр нь төрөлжүүлэн, ерөнхий сургалтыг 2 сартайгаас эхлүүлэн 6 сар хүртэл түүнээс цааш тухайн чиглэлийн мэргэжлийн сургалтад хамруулна.

Цагдаагийн байгууллагад албаны нохойг дараах чиглэлээр сургана гэжээ.⁹⁵

а/ эрэл, мөрдлөг

б/ эргүүл

в/ харуул, хамгаалалт

г/ аврах эрэн хайх

д/ үнэрийн харьцуулалт

е/ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэх

ж/ тэсэрч дэлбэрэх бодис олж илрүүлэх

Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ашиглагдах эргүүл, харуул хамгаалалтын нохой, хөтлөгч бэлтгэх сургалтын хугацаа 3 сар байна.

Эрэл мөрдлөг, авран хамгаалах, эрэн хайх чиглэлээр нохой, нохойн төлөөлөгч бэлтгэх сургалтын хугацаа 6 сар байна.

Үнэрийн харьцуулалт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэсэрч дэлбэрэх бодис олж илрүүлэх чиглэлээр нохой нохойн төлөөлөгч бэлтгэх сургалтын хугацаа 3 сар байна.

Цагдаагийн ерөнхий газрын Сургалтын нэгдсэн төв нь Хууль зүй, дооод хэргийн яамны харьяа хууль сахиулах байгууллагууд болон бусад байгууллагын захиалгаар нохойн төлөөлөгч, хөтлөгч, нохойг бэлтгэн өгч болно.

Суралцахаар ирсэн алба хаагчийн сургалтад тэнцэх эсэх талаарх дүгнэлтийг сургалтын эхний 14 хоногт гаргаж шаардлага хангаагүй тохиолдолд захиалагч байгууллагад мэдэгдэж солих арга хэмжээг авахуулна.

Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаанд эрэл, мөрдлөгийн албаны нохойг дараах чиглэлээр ашиглана.⁹⁶ Үүнд:

а/ Гэмт хэргийн газраас илрүүлсэн үнэрийн бичил мөрөөр мөрдлөг хийх

б/ Сэжигтний үнэрийн бичил мөрөөр чиглэл тогтоон илрүүлэх

в/ Гэмт хэргийн газраас сэжигтэн гэх хүн, эд мөрийн баримтаар эд зүйл олох зорилгоор самнан нэгжилт хийх

г/ Сэжигтэй гэх хүний болон эд зүйлийн үнэрээр сонгон ололт хийх

д/ Гэмт хэргийн газраас үнэр болон үнэртэй эд зүйлийг бусад аргаар бэхжүүлэн авсны дараа түүнийг хадгалах, харьцуулалт явуулахын тулд тусгайлан сургасан 3-4 нохойг ашиглан хийх

е/ Зэвсэглэсэн болон онц аюултай гэмт хэрэгтэн оргон зайлсан, олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, харуул хамгаалалтад байгаа объект, хүмүүс рүү халдсан, мөрийн үнэрээр ашиглах үед хуульд заасан үндэслэлийн дагуу нохойг оосор хушуувчгүйгээр ашиглаж болох ба түүнийг хариуцан ажиллаж байгаа алба хаагч нь үүссэн нөхцөл байдалд дүгнэлт хийн, “зогс, нохой тавилаа” гэж урьдчилан анхааруулж, нохойг өөрийн хяналтаас гаргахгүйгээр ашиглах

ё/ Эрх бүхийн албан тушаалтны шийдвэрээр мөрдөн шалгах нууц болон гүйцэтгэх ажлын арга хэмжээний үед

з/ Гэмт хэрэгт холбогдогч оргон зайлсан үед олж илрүүлэхэд

ж/ Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис илрүүлэхэд

л/ Тэсэрч дэлбэрэх бодис, төхөөрөмж ба тэсэрч дэлбэрэх бодис агуулсан эд зүйл илрүүлэхэд

м/ Барилга байгууламж, орон сууц, олон нийтийн газар, агаарын хөлөг, галт тэрэг, тээврийн хэрэгсэл, олон улсын илгээмж, ачаа тээшний аюулгүй байдлыг шалгахад

Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр эргүүл, харуул хамгаалалтын албаны нохойг дараах чиглэлээр ашиглана.⁹⁷ Үүнд:

⁹⁵ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 2-р зүйлийн 2.7 дахь хэсэг

⁹⁶ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 3-р зүйлийн 3.1 дэх хэсэг

⁹⁷ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 3-р зүйлийн 3.2 дахь хэсэг

а/ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд явган эргүүлийн үүрэг гүйцэтгэхэд

б/ Нийтийг хамарсан баяр ёслолын арга хэмжээнэй үеэр олон нийтийн аюулгүй байдлыг хангахад

в/ Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн үед иргэдийн амь нас, эрүүл мэндэд хор хөнөөл учруулж болзошгүй бүлэг этгээдүүдийн хүчийг сарниулахад

г/ Гэмт хэрэгт холбогдсон этгээдийг хуяглан хүргэх үед

д/ Эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагч сэжиг бүхий хүн, объектод үзлэг, нэгжлэг хийхдээ өөрийн болон бусдын амь нас, бие махбодийн аюулгүй байдлыг хангахад

е/ Улсын онц чухал объектуудын аюулгүй байдлыг хангахад

Харуул хамгаалалтын чиглэлээр албаны нохойг ашиглахдаа нохойг гүйлгээ уяанд болон нэг цэгээс уях, харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчийн хяналтанд сул чөлөөтэй байлгана. Нэг нохойг газар, байршлын онцлогоос шалтгаалж 150-200 метр талбайд байнга болон түр ашиглах хэлбэртэйгээр ашиглана.

Аврах, эрэн хайх үйл ажиллагаанд албаны нохойг дараах чиглэлээр ашиглана⁹⁸. Үүнд:

а/ Төөрсөн хүн эрэн хайх /байгалийн саад бартаа, уул хад, ой мод, бут сөөгтэй шугуйд самнан нэгжилт хийхэд/

б/ Байгалийн гамшигт үзэгдэл буюу газар хөдлөлтийн улмаас нурсан барилга байгууламжийн нурангин доороос хүн болон цогцос эрэн хайхад

в/ Голын усанд хүн живж осолдсон тохиолдолд цогцосыг эрэн хайхад

Албаны нохойг ашиглахад дараах зүйлийг хориглоно.⁹⁹ Үүнд:

а/ албаны нохойг мэргэжлийн бус ажилтанд хариуцуулж үүрэг гүйцэтгүүлэх

б/ албанд тэнцэхгүй, дутуу сургалттай, ажлын чадвараа алдсан нохойг ашиглах

в/ мөрдөн шалгах нууц болон гүйцэтгэх ажлын арга хэмжээнд эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр

г/ нохойн төлөөлөгчийг үндсэн ажлаас нь шалтгаангүйгээр хөндийрүүлэх

д/ сургалтад хамруулаагүй нохойг

е/ химийн бодис ашигласан эсвэл бохирдуулсан газарт

ж/ төрөл мэргэжлийн тусгай албаны нохойг бусад төрлөөр ашиглах

з/ өндөр настан, насан хүрээгүй хүүхэд, жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүсийн эсрэг

и/ цагдаагийн албан хаагч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй зэвсэглэсэн этгээд зугтаасан, довтолсноос бусад тохиолдолд хүний эсрэг

Албаны нохойн төлөөлөгч, хөтлөгч, нохой бэлтгэх, сургалт зохион байгуулахад шаардагдах зардал болон үржил селекти, хоол, тоног хэрэглэл зэрэгт шаардагдах зардлыг тооцож, Сургалтын нэгдсэн төвийн жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн алба хариуцна.

Албаны нохойд олон улсын стандарт, чанарт нийцсэн витаминт зориулалтын хоолыг зохих жорын дагуу өдөрт 2 удаа олгоно. Үржлийн болон гөлгөн нохой, өвчтэй нохойд нэмэлт хоолыг малын эмчийн шийдвэрийг үндэслэн олгоно.

Албаны нохойг хоногт нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, өвчин эмгэг илэрсэн тохиолдолд нэн даруй урьдчилан сэргийлэх, эмчлэх арга хэмжээ авна. Нохойг жилд нэг удаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд, улиралд нэг удаа паразит цагаан хорхойн туулганд хамруулна.

Албаны нохойтой ажиллагсад өөрсдийн хувийн ариун цэврийг чанд сахиж, нохойн байрыг цэвэрлэх, сургах дасгалжуулах явцдаа хөдөлмөр хамгаалалын хувцас /өвөл зуны комбинзон/ өмссөн байвал зохино. Хөдөлмөр хамгаалалын хувцсыг жилд 1 удаа тавьж олгоно.

Алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс болон улсын онц чухал объектод үүрэг гүйцэтгэж байгаа албаны нохойг байрлуулах, арчлах, маллах, тэжээх, эрүүл мэндийг хамгаалах ажлыг тухайн байгууллага, алба хаагч хариуцна.

⁹⁸ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 3-р зүйлийн 3.3 дахь хэсэг

⁹⁹ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 4-р зүйлийн 4.1 дэх хэсэг

Албаны нохой эдгэх боломжгүй өвчин эмгэг, гэмтэл бэртэлтэй, нас хөгширсөн /8 нас хүрсэн/, сургалтын явцад саатал үүссэн тохиолдолд мэргэжлийн комиссын дүгнэлтийг үндэслэн акталж данснаас хасуулна.¹⁰⁰ /орон нутагт мэргэжлийн комисст тухайн аймаг, сумын мал эмнэлэг үржлийн албаны мал эмч, мал зүйч нарыг заавал оролцуулна/

Эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа албаны нохойг өвлийн улиралд 4 цаг, зуны улиралд 6 цагийн үүрэг гүйцэтгүүлж, үүрэг гүйцэтгэж байх хугацаанд 2 цаг тутам 15 минут амраана.

Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа албаны нохойг өдөрт 12 цагийн хугацаатай манааны үүрэг гүйцэтгүүлэн 3 цаг тутамд нохой хөтлөгч хяналт тавьж ажиллана. Жижүүрт 24 цагийн үүрэг гүйцэтгэсэн албаны нохойг 24 цаг амраасны дараа давтан дасгалжуулалтад хамруулна.

Тусгай мэргэжлийн албаны нохойг зориулалтаас бусад чиглэлд ашиглах, сургалтад хамруулахгүй байхыг хориглоно. Нохойн тоног хэрэглэлийг зориулалтын дагуу хэрэглэнэ. Албаны нохойн аюулгүй байдлыг бүрэн хангасан тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслээр зөөж, тээвэрлэнэ.

Албаны нохойн тоног хэрэглэлийг 2 жилд нэг удаа олгоно. Албаны нохой албан үүргээ гүйцэтгэх үед цаг агаарын нөхцөл байдалд нийцсэн гэрэл ойлгогчтой цээживчийг хэрэглэнэ.

Хамгаалж байгаа объектын онцлогоос хамаарч албаны нохойг гүйдэг уяатайгаар ашиглах бөгөөд сул тавьж ашиглах тохиолдолд хүний амь нас, эрүүл мэндэд хор аюул учруулахаар урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Албаны нохой ашиглаж байгаа байгууллага нь **“Анхаар нохойтой”** гэсэн тэмдгийг иргэдэд харагдахуйц газарт байрлуулна.¹⁰¹

Албаны нохойг ашиглахдаа гадаад дотоод саатлыг арилгаж, хүрээлэн буй орчинд дасгах зорилгоор 5-15 минут зугаалуулна. Хэргийн газарт албаны нохой ашиглах боломж бололцоог судлана.

Эрэл мөрдлөгийн албаны нохойг хэргийн газраас илрүүлсэн үнэрийн бичил мөрнөөс мөрдлөг хэлбэрээр ашиглахдаа цээживчээр тоноглон, урт уяаг хэрэглэнэ.

Харуул хамгаалалтын нохойг улсын онц чухал объектод үүрэг гүйцэтгэхэд цаг уурын нөхцөл байдлаас хамгаалсан нохойн байр, хоол тэжээлээр хангана.

Албаны нохойн хүчин чадал, мэргэжлийн ур чадварын түвшинг тогтоох зорилгоор 3 жилд нэг удаа **“Шилдэг нохойн төлөөлөгч, хөтлөгч, эрэлч нохой”** шалгаруулах тэмцээнийг Сургалтын нэгдсэн төв хариуцан зохион байгуулна.

Албаны нохой ашиглах арга зүй

Мал эмнэлэг, ариун цэврийн үзлэгт хамрагдаж, бүртгэлд авагдсан, төрөл бүрийн үүлдэр /жижиг хав хэлбэрийн нохойноос бусад/-ийн нохойг харуул хамгаалалтад ашиглах зорилгоор сонгон авч ажиллуулж болох бөгөөд энэхүү албаны нохойг объектыг хамгаалах, эргүүл шалгалт хийх, гэмт этгээдийг мөрдөн хөөх, саатуулах зорилгоор ашиглана.

Улсын онц чухал объектын харуулын цэгүүд нь албаны нохойтой байна. Албаны нохойд **“Дайр, барь, зогс, суу” зэрэг команд** дохиог заавал сургасан байна.

Ариун цэвэр, эрүүл ахуйн онцгой дэглэм сахиулах шаардлагатай зарим объект /лабораторууд, хөрснөөс бохирдох боломжтой усан сангууд гэх мэт/-д албаны нохой ашиглахыг хориглоно.


Албаны нохойг харуулын цэгт 3 метрээс илүүгүй зайд зориулалтын байр /нохой дотор нь чөлөөтэй эргэх боломжтой, наран талруу харсан хаалгатай, 85 см өндөртэй, 80 см урттай, 80 см өргөнтэй, 3 см-ын зузаан модон банзаар хийсэн, дотор талыг нь дулаалсан, дээвэр нь гурвалжин, нохойн байрны дотор талын хэвтрийг элс, хайрга, керамзетээр давхарлан дулаалсан, хүрэн улаан өнгөөр будсан, хаяаг шороогоор манасан, модоор барьсан/-нд байрлуулна.¹⁰² Албаны нохой, албаны нохойн байрыг 13 дугаар зурагт заасан хэв загвар, байршлаар харуулын цэгт байрлуулж, албаны нохойн байр нь 14 дүгээр зурагт заасан хэв загвараар хийгдсэн байна.

¹⁰⁰ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 5-р зүйлийн 5.6 дахь хэсэг


¹⁰¹ ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх ашиглах хамгаалах журам”-ын 5-р зүйлийн 5.16 дахь хэсэг

¹⁰² “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 149-р тал

Зураг 13. Албаны нохойг байрлуулах



Зураг 14. Албаны нохой байрны хэв загвар



Албаны нохойд дараах тоноглолыг хэрэглэсэн байх шаардлагатай.¹⁰³ Үүнд:

- Тусгай зориулалт /тасарч, хугарахгүй арьсан материалаар хийгдсэн, нохойн хошууг барихгүй, хошуунаас суларч унахгүй, гоцгоо дэгээ нь төмөр сайтай, нохойн биенд шигдэхээргүй/-ын хошуувчтай, 5 метрийн урттай даавуун болон ременэн оосор /нохой хөтлөгчийн гаранд шигдэхээргүй өргөн, тасарч, хугарахгүй, гоцгоо дэгээ нь төмөр сайтай/-той байх;
- Улаан өнгийн даавуун цацагтай, нохойн хоолойг боохооргүй, толгойноос нь мултаргахгүй, тасарч, хугарахгүй ширэн материалтай, улаан өнгийн цацагтай хүзүүвчтэй байх;
- Хүзүүвчний гоцгоо, сэнжиг нь гагнаас сайтай, хугарч, муруйхгүй, нохойн хүзүүнд шигдэж орохооргүйгээр хамгаалагдсан байх гэж тус тус заажээ.

Албаны нохойтой харуулын байранд **“АНХААР НОХОЙТОЙ”** гэсэн анхааруулах тэмдгийг нүдэнд ил харагдах гэрэлтэй хэсэгт тавина.

“АНХААР ХАМГААЛАЛТЫН НОХОЙТОЙ” тэмдгийг хүрэн улаан дэвсгэртэй 60:25 см-ийн харьцаатай төмөр буюу модон дээр цагаан өнгийн гэрэлтдэг будгаар бичиж байрлуулна.



Хамгаалж байгаа объектын онцлогт тохируулж хашааны дагуу, хаалганы хооронд гэх мэт нохойгоор хамгаалах боломжтой газарт нохойг гүйдэг уяагаар уяна. Энэ нөхцөлд нохойны байрыг гүйдэг уяаны төгсгөлд харуулын цэгт аль болох ойр байрлуулна.

Албаны нохойг ашиглахад дараах шаардлага тавигдана гэжээ.¹⁰⁴ Үүнд:

- Албаны нохойг ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Албаны нохой бэлтгэх, ашиглах, хамгаалах журам”-ын 3.1, 3.2, 3.3-т заасан үндэслэл, журмын дагуу эргүүл, харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэхэд ашиглах;
- Харуул, хамгаалалтын чиглэлээр ашиглах нохойг гүйцэтгэх үүрэг, ажлын шаардлагыг харгалзан албаны нохойтой үүрэг гүйцэтгэх алба хаагчийн хамт 40-45 хоногийн сургалтад хамруулах;
- Харуулын /шалган нэвтрүүлэх/ үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагч сэжиг бүхий хүн, объектод үзлэг, нэгжлэг хийхдээ нохойг тодорхой зайд байрлуулан “суу” команд өгч, нөгөө алба хаагчийнхаа хийж буй үзлэгийн явцыг анхааралтайгаар ажиглан туслахад хэзээд бэлэн байдалд байлгах;
- Харуул, хамгаалалтын чиглэлээр нохой ашиглахдаа нохойг гүйлгээ уяанд болон нэг цэгээс уях, хамгаалалт бүхий хашаа байр, объектод харуул хамгаалалтын ажилтны хяналт дор сул чөлөөтэй байлгах бөгөөд нэг нохойг газар, байршлын онцлогоос шалтгаалж, 100-150 метр талбайд ашиглах; /байнга болон түр ашиглах хэлбэртэй байж болно/
- Объектод үзлэг, эргүүл хийх үед харуулын цагдаа нохойг зориулалтын оосроор хөтөлж явах бөгөөд зөвхөн гэмт этгээд халдсан, бүлэглэж дайрсан, тавьсан шаардлага биелүүлээгүй зугтсан тохиолдолд нохойг ашиглах;
- Албаны нохойг ашиглахаас өмнө **“ЗОГС”**, **”НОХОЙ ТАВЬЛАА”** гэсэн анхааруулгыг урьдчилан өгөх;

¹⁰³ “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 150-р тал

¹⁰⁴ “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 151-р тал

- Нохойг хооллох, байрыг цэвэрлэх, ариутгал хийх үед хамгаалалтын бээлий өмсөж хэрэглэх, нохойны ялгадас бохирыг тусгай саванд хийж зайлуулах;

Цагдаагийн алба хаагч нь нохойтой харьцаж ажиллах үед хөдөлмөр хамгааллын дараах шаардлагыг мөрдөнө.¹⁰⁵ Үүнд:

- Нохойг зүүн гар талдаа, богино оосроор хөтөлж явах
- Олон нийтийн газар, тээврийн хэрэгсэлд нохойг авч явахдаа хошуувчийг заавал хэрэглэх ба шаардлагатай үед /мөрдлөг, сонгон ололт, самнан нэгжилт, хөөн барилт, адилтгал/ хошуувчийг авч, урт оосор, цээживч болон дагалдах бусад хэрэгслийг ашиглах
- Нохойг гадны хүнтэй харьцуулахгүй байлгахад анхаарч, гадны хүн ойртсон тохиолдолд нохой зууж болзошгүйг анхааруулах
- Хамгаалалтад байгаа объектод албаны нохой ашиглаж байгаа тохиолдолд “Анхаар нохойтой” гэсэн анхааруулгыг иргэдэд харагдахуйц газарт бичиж байрлуулсан байх

Албаны нохой ашиглахад хориглох зүйл:

- Албаны нохойг сургалтанд хамрагдаагүй ажилтанд хариуцуулж үүрэг гүйцэтгүүлэх;
- Албанд тэнцэхгүй, дутуу сургалттай, ажлын чадвараа алдсан нохойг хэрэглэх;
- Сургалтад хамруулаагүй нохойг хэрэглэх;
- Өндөр настан, насанд хүрээгүй хүүхэд, жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүсийн эсрэг хэрэглэх;

Албаны нохойны нэрийг нууцалж, зөвхөн дэг журам сахиулагч /ээлжийн зохицуулагч/, харуулын цагдаа мэдэж, дүрэмт хувцастай хүмүүсээс бусад хүмүүст дасгах, бусдаар хоол өгүүлэхийг хориглоно.

Нохойг сул тавьж ашиглах тохиолдолд хүний амь нас,эрүүл мэндэд хор аюул учруулах, нохойг хориглосон байранд нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг харуулын цагдаа /нохой ашиглаж байгаа албан тушаалтан/ авна. Дэг журам сахиулагч /ээлжийн зохицуулагч/-ийн зөвшөөрөлгүйгээр, эсхүл зорилгогүй сул тавихыг хориглоно.¹⁰⁶

Албаны нохойг үүрэг гүйцэтгэх явцад хүн нохойд уруулж гэмтэл авсан тохиолдолд эмнэлгийн тусламж үзүүлэх арга хэмжээг нэн даруй авч, шууд захирах даргадаа шуурхай мэдэгдэх үүргийг хүлээнэ.

Дүгнэлт

Цагдаагийн байгууллага нь түүхэн хөгжлийнхөө хугацаанд өөрийн үндсэн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхдээ албаны нохойг ашиглаж ирсэн байх бөгөөд энэхүү үйл ажиллагааг зохицуулж буй эрх зүйн зохицуулалт нь тухайн үеийн улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж өөрчлөгдөн, шинэчлэгдэн сайжирч улам боловсронгуй болж иржээ.

Ном зүй

1. Цагдаагийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017.02.09.
2. ХЗДХС,УЕП-ын хамтарсан 2017.09.06-ны өдрийн А-224/А-102 тоот тушаалын хавсралт “Цагдаагийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар”
3. ЦЕГ-ын даргын 2017.11.01-ний өдрийн А/210 тоот тушаалын 1-р хавсралт “Албаны нохой бэлтгэх, ашиглах, хамгаалах журам”
4. Ш.Чулуун “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” 2019 он

---oOo---

¹⁰⁵ “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 152-р тал

¹⁰⁶ “Цагдаагийн албаны галт зэвсэг, тусгай хэрэгсэл” нэг сэдэвт бүтээл 2019 он 153-р тал

ТӨМӨР ЗАМЫН САЛБАР ДАХЬ ГЭМТ ХЭРЭГ, ХЭВ ЖУРМЫН ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

Р.Баяраа

*Тээврийн Цагдаагийн албаны Төмөр зам дахь Цагдаагийн газрын
Хэв журмын ажил хариуцсан байцаагч, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Монгол улсын Төмөр замын салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл, статистик мэдээг үндэслэн урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлохыг зорьсон.

Түлхүүр үгс: Улаанбаатар Төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг, Төмөр замын Өртөө, Зангилаа, Зорчигч үйлчилгээний төв буудал, Гэмт хэрэг, зөрчил

Улаанбаатар төмөр зам дахь Цагдаагийн газрын түүхэн хөгжил:

XX зууны эхэн буюу Олноо Өргөгдсөн Дөрөвдүгээр /1915/ онд Богд Хаант Улсын Монгол Улс, Хаант Орос Улс, Хятадын Хиагтын хэлэлцээрээр Монгол нутагт төмөр зам тавих асуудлыг хөндөж, тусгай заалт оруулжээ. 1930 онд хуралдсан МАХН-ын 8 дугаар хурлын тогтоолд “Алтанбулаг-Улаанбаатарын төмөр замыг байгуулах газрыг эрж олох, шинжлэх явдлыг таван жилийн төлөвлөгөөнд оруулсан байна. 1930-аад оноос Улаанбаатар хотод Аж үйлдвэрийн комбинат, цахилгаан станц байгуулагдаж Налайхаас зөөвөрлөх чулуун нүүрсний хэрэгцээ асар их өссөнөөр 1935 онд Аж үйлдвэрийн комбинатыг хүлээлцэх 2 улсын Засгийн газрын комиссын ерөнхий акт бичигт Налайх-Аж үйлдвэрийн комбинат хооронд 26 км урттай 755 мм-ын царигийн зам тавих тухай тусгагдсанаар Улаанбаатар-Налайхын хооронд 43 км нарийн төмөр зам баригдаж 1938 онд ашиглалтанд оруулж “Монголын төмөр зам” их айлын үүсэл эхэлжээ. ЗХУ-ын /хуучин нэрээр/ хүч хөрөнгөөр Наушка-Улаанбаатарын чиглэлд 402 км төмөр зам тавьж 1949 оны 11 дүгээр сард ашиглалтанд оруулснаар улс ардын аж ахуйн шинэ салбарт гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амгалан тайван байдлыг сахиулах мэргэжлийн алба байгуулах үүргийг Засгийн газраас Дотоод явдлын яаманд өгчээ.¹⁰⁷

Төр засаг Төмөр замын аюулгүй байдлыг хангахын тулд бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох түүний үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох мэргэжлийн боловсон хүчнийг сургах,бэлтгэх зэрэг олон төрлийн арга хэмжээнүүдийн авсны дотор төмөр замын үйл ажиллагааг хариуцсан мэргэжлийн Прокурор, Шүүх, Аюулаас хамгаалах ба цагдан сэргийлэх зэрэг хууль хяналтын байгууллагуудыг байгуулах тухай шийдвэрийг дэс дараатай гаргаж ирсэн байдаг. Эдгээр байгууллагууд нь төмөр замын зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлогийн хүрээнд үндсэн үүргээ тусгайлан явуулах үүрэг хүлээсэн байна.

Анх 1950 онд ДЯЯ-ны сайд, хошууч генерал Дүйнхоржавын баталсан ДЯЯ-ны харъяа Улсын цагдан сэргийлэх газрын ажиллах орон тооны баримт бичигт “Төмөр замын пункетын дарга 1, цагдаа 9 орон тоог батласан нь одоогийн Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь Цагдаагийн газрын үүсэл тавигдсан гэж үзэж болно.¹⁰⁸

Цагдаагийн байгууллагаас Төмөр замын салбар дахь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх ажил, нөхцөл байдал:

Төмөр зам дахь Цагдаагийн газар нь Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумаас Төв, Говьсүмбэр, Дорноговь гэх 4 аймгийн нутаг дэвсгэрийг дамжин өнгөрч Дорноговь аймгийн Замын-үүд сум хүртэл 1111 км-н урттай төмөр замын харъяа нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр Цагдаагийн байгууллагын хуулинд заасан үндсэн үүргээ хэрэгжүүлж байна. Тус Цагдаагийн газарт төмөр замын хойд чиглэлийн Дархан, урд чиглэлийн Сайншанд дэд хэсгийг 2016 онд ЦЕГ-н даргын тушаалаар хүн хүч орон тоотой нь батлаж өгснөөр үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд ахиц гарсан. Төмөр замын салбарт гарч буй гэмт хэрэг зөрчлийн дийлэнх хувь нь Улаанбаатар, Сүхбаатар, Дархан, Чойр, Сайншанд, Замын-Үүд гэсэн хүн ам шигүү суурьшсан өртөө, зангилаа болон зорчигчийн суудлын галт тэргэнд үйлдэгддэг байна. Мөн Монголын уламжлалт баяр болох Цагаан сар, Улсын их баяр наадам болон их, дээд

¹⁰⁷ Эмхэтгэл: “Төмөр зам дахь Цагдаагийн хэлтсийн Түүхэн товчоо” 2016 он 20 дахь тал

¹⁰⁸ Эмхэтгэл: “Төмөр зам дахь Цагдаагийн хэлтсийн Түүхэн товчоо” 2016 он 21 дахь тал

сургуулийн оюутан, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн хичээл эхлэх үеэр галт тэргээр зорчин явах иргэдийн урсгал ихэссэн үед гэмт хэрэг, зөрчлийн гаралт ихэсдэг. Урин дулаан цаг хавар, зун, намар гадаадын жуулчид, иргэд манай орны үзэсгэлэнт байгалыг үзэх, аялах зорилгоор ирэх үе гэмт хэрэг, зөрчлийн гаралтанд нөлөөлдөг.

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан тушаал, үүрэг, ажлын чиглэлийн дагуу хуулийн хүрээнд тус цагдаагийн газар нь төмөр замын салбар, бүсэд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэсээр байна.

Шинээр батлагдан гарч 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуулинд заасан гэмт хэрэг, зөрчлийг хуулийн хугацаанд нь шалган шийдвэрлэж иргэдээс ирүүлсэн гомдлыг барагдуулж хохирлыг нөхөн төлүүлэх нь цагдаагийн байгууллагын алба хаагчдын анхаарах гол асуудал юм.


Төмөр зам дахь Цагдаагийн газар нь 2018 онд гэмт хэрэг, зөрчлийн талаархи 1596 гомдол мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн байна. Үүнээс:

-Гэмт хэргийн шинжтэй 153 буюу 9.5%

-Зөрчлийн шинжтэй 1447 буюу 90.5% гомдол мэдээлэл эзлэж байна.

Гэмт хэргийн шинжтэй 153 гомдол мэдээлэлийн 103 буюу 67.3 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж 48 буюу 31.4 хувьд хэрэг нээхээс татгалзсан, 2 буюу 1.3 хувийг харъяалалын дагуу шилжүүлж үлдэгдэлтэй гомдол, мэдээлэлгүй байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц хэргийн төрлөөр нь:



Гэмт хэргийн илрүүлэлт 57.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үед 49.1 хувь байснаас 8.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хөнгөн гэмт хэрэг 2017 онд 67 бүртгэгдэж, хэрэг бүртгэлтийн хэрэг 49 үүнээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг 25, илрүүлэлт 51.0 хувьтай, илрээгүй 24

2018 онд 46 хэрэг бүртгэгдэж, хэрэг бүртгэлтийн хэрэг 43, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг 25, илрүүлэлт 58.1 хувьтай, илрээгүй 18

Хүнд гэмт хэрэг 2017 онд 5 бүртгэгдэж хэрэг бүртгэлтийн хэрэг 3, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг 1, илрүүлэлт 33.3 хувьтай, илрээгүй 2

2018 онд 7 хэрэг бүртгэгдэж хэрэг бүртгэлтийн хэрэг 6, үүнээс эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэг 3, илрүүлэлт 50 хувьтай илрээгүй хэрэг 3 байна.¹⁰⁹

¹⁰⁹ Төмөр зам дахь Цагдаагийн газрын 2018 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн танилцуулга

Газрын хэмжээнд 2018 онд 53 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны үеэс 29 хэрэг буюу 35.4 хувиар буурсан, нийт 29555 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үед 18167 байснаас 11388 нэгж буюу 62.7 хувиар өссөн тус тус үзүүлэлттэй байна.

Дүгнэлт

Шинжлэх ухаан, техник технологи хөгжсөн орчин үед Улаанбаатар төмөр зам ХНН-н өртөө, зангилааны зорчигч үйлчилгээний буудал, төмөр замын бүс, зорчигчийн галт тэргэнд камержуулалтын систем муу, байхгүй байгаагаас болж иргэд гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирсон тохиолдолд илрэх магадлал бага байдаг. Сүүлийн үед ачааны болон суудлын галд тэрэгний эд ангид хориотой эд зүйл, ангийн эд эрхтэн нуух зорчигчид биедээ болон ачаа бараандаа хориотой эд зүйлийг нууж хилээр гаргах, оруулах гэмт хэргийн тоо буурахгүй байна.

Төмөр замын аюулгүйн дэглэм зөрчиж гарц, гарамгүй газраар төмөр зам нэвтрэх үедээ галт тэргэнд иргэд дайруулж амь насаа алдах, эд эрхтэнээсээ хагацах, тээврийн хэрэгсэл жолоодож явах үедээ замын хөдөлгөөний дүрэм зөрчиж зөрчил гаргах мөн архидалт, ажилгүйдлээс болж үүсэж байгаа гэмт хэрэг, зөрчил төмөр замын салбар, бүсэд ч гарсаар байна.

Санал

Төмөр замын бүс, ойр орчинд амьдардаг иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлж төмөр замын аюулгүйн дэглэмийг таниулах, үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээнд үндэслэн шалтгаан нөхцлийг нь тогтоож урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг ахиулах

Тээврийн хэрэгсэл жолоодож төмөр замын бүсээр нэвтрэх үедээ анхаарах дохио, тэмдэг, тэмдэглэгээг сайжруулж осол, зөрчил ихээр гардаг гармуудыг нэн түрүүнд хаалттай гарам болгон өөрчлөх, явган хүн нэвтрэх нүхэн гарцыг иргэдийн сууршил хөдөлгөөнд тохируулан гаргах

Зорчигч үйлчилгээний буудал болон суудлын галт тэргэнд хяналтын камертай болгох, одоо байгаа хяналтын камерын чанар, системийг сайжруулах

Архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ нийтийн тээвэр болох суудлын гарт тэргээр иргэдийг зорчуулахгүй байх

Хилээр нэвтэрч байгаа сэжиг бүхий иргэдийн ачаа бараа, эд зүйлд тавих хяналтын цагдаагийн байгууллагаас сайжруулах шаардлагатай байна.

Ном зүй

- “Төмөр зам дахь Цагдаагийн хэлтсийн Түүхэн товчоо” 2016 он
- Төмөр зам дахь Цагдаагийн газрын 2018 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн танилцуулга

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАДСАН АСУУДАЛ

EUROPEAN UNION POLICY ON FOREIGN DIRECT INVESTMENT¹¹⁰

*Ninjin Bataa*¹¹¹

Introduction

The European Union Policy for Investment addresses the issue of sustainable and inclusive development through the lens of private sector-led development. The policy looks at all forms of investment involving all types of firms. A good investment climate is one which provides opportunities for all investors: public and private, large and small, foreign and domestic. The policy could be non-prescriptive, as it is impossible to find an approach that suits all the countries within the European Union (hereinafter EU). The Member States have different private sector development and economic sustainability and efficiency.

The policy recognizes the role of competition in relation to the principle of non-discrimination and national treatment. The importance of foreign investment is directly linked to the fact that the EU is the biggest provider and destination of Foreign Direct Investment (hereinafter FDI) in the world, measured by stocks and flows.¹¹² Needless to say, the statistical data is directly related to the number countries with higher Gross Domestic Product (GDP) in the European Union. Accordingly, the investment creates enormous growth and numerous new jobs both at home and abroad.

The biggest push to the foreign direct investment flow started with the collapse of communism more than 20 years ago. This event unleashed a historically unprecedented process of economic restructuring and political transformation in the former communist countries. Of course, it was a lengthy process which did not happen over a year: there was a transition period.¹¹³ This transition process involved certain changes in the politics and in the economies of the countries involved. As an example, we can mention democratization, institution building and for the economic sector, -marketization, liberalization, restructuring. In the transition process, FDI proved to be the most effective instrument.

Further studies on the economics of the 2004 Enlargement¹¹⁴ of the EU have shown that this prospect of accession has been paramount in mobilizing foreign investments, as western firms responded to the opportunities offered by the opening of the new markets by changing the geographical organization of their production thus initiating a broader process of restructuring for the European industry. As a result, these movements were part of a deeper integration process, reflecting the significant linkages that developed on the ground, which in turn facilitated sizeable technology transfers to the companies of Central and Eastern Europe. But the extent of integration with the local economies has been low, and this was related to the volumes of FDI. The countries were seeing foreign direct investment as a market-capture type and a spatial reorganization of the production system. The latest major step in FDI policy happened in 2009 with the Treaty of Lisbon, which changed the perspective of future developments entirely by giving the Union full competence over foreign investments.

The Treaty of Lisbon and the Member States'-Bilateral Investment Treaties: the conflict and how the EU regulated them

¹¹⁰ „A tanulmány az Igazságügyi Minisztérium jogászképzés színvonalának emelését célzó programjai keretében valósult meg”/ „The study was made under the scope of the Ministry of Justice's programmes on aiming the strengthening of the quality of legal education”

¹¹¹ PhD student at Marton Geza Doctoral School, University of Debrecen

¹¹² The data of World Bank shows the inflows of FDI by countries. Latest data is from 2017.

https://data.worldbank.org/indicator/BX.KLT.DINV.CD.WD?locations=EU&name_desc=false

¹¹³ Vassilis Monastiriotis, Origin of FDI and domestic productivity spillovers: does European FDI have a 'productivity advantage' in the ENP countries? 2014, LSE 'Europe in Question' Discussion Paper Series.

¹¹⁴ Brendon et al, 1999; Kaminski, 2001; Clausing and Dorobantu, 2005; Monastiriotis and Agiomirgianakis, 2009.

In 1957 with the establishment of the European Union (previously European Economic Community/European Community) a Common Commercial Policy (CCP)¹¹⁵ has been created to govern the EU's trade relations with non-EU countries. The purpose of European Economic Community (EEC) Treaty was to establish common market between the Member States of the Community in order to give possibility to people, goods, capital and services to move freely. The creation of a common commercial policy was a logical consequence of the formation of a customs union among its Member States. The European Union's trade policy therefore establishes common rules including, among others, a common customs tariff, a common import and export regime and the undertaking of uniform trade liberalization measures as well as trade defence instruments. In framework of common market, a twelve-year transitional period was introduced. For the sake of cohesion, liberalization at internal level had to be in tune with that at external level and the Community therefore has had sole competence for common commercial policy since the transitional period ended.¹¹⁶

Before getting into Lisbon Treaty and how it changed EU's competence, we should take a brief look at the competences of the Union overall.

EU is a regional and multinational organization which was established by the member states by giving some of their competences to the organization. Based on those competences EU solely can make decisions in certain areas as politics, economics and not only.

The competences of the EU are divided into three categories:

- the EU has exclusive competence (Article 3 TFEU), meaning that only the EU can act upon those areas.
- competences are shared between the EU and the member states (Article 4 TFEU). It is when the member states can act only if the EU has chosen not to. If the competence is shared between EU and MS, then the decision making process takes upon negotiations. But usually, the EU states fundamental principles that should be followed by MS.
- the EU has competence to coordinate, supplement or support the actions of the member states (Article 6 TFEU)– in these areas, the EU may not adopt legally binding acts that require the member states to harmonize their laws and regulations.

The biggest change within the FDI policy of the EU was brought by the Treaty of Lisbon in 2009, which gave the EU power, within the framework of the CCP, to make investment agreements on behalf of the Member States. In terms of new competences, the Lisbon Treaty¹¹⁷ explicitly mentions foreign direct investment as forming part of the EU common commercial policy.¹¹⁸ This includes, among others, the power to regulate investment protection. The Lisbon Treaty explicitly confirmed that the common commercial policy is an area of exclusive EU competences.¹¹⁹ This formal declaration confirms existing case-law of the Court of Justice of the European Union (hereinafter the CJEU)¹²⁰ and means that the Union alone is able to legislate and conclude international agreements in this field, including international investment. After the establishing of the "principle of parallelism" elaborated in the European Laying-Up Fund for Inland Waterway Vessels Case and the CJEU's following Opinion 1/76, the question regarding implicit competence of the European Union was lessened. Precisely, CJEU stated that the European Commission disposes of

¹¹⁵ The Common Commercial Policy presents regulations to govern EU's trade relation with non-EU countries. Now it includes, among others, a common customs tariff, a common import and export regime and the undertaking of uniform trade liberalization measures as well as trade defense instrument.

¹¹⁶ The Common Commercial policy. <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=LEGISSUM%3Aa20000>, para 2.

¹¹⁷ The Lisbon Treaty is the latest amendment of the EU founding Treaties, entered into force in 2009. It resulted in the (current) Treaty on European Union (TEU) [OJ C 326.26.10.2012 p. 13] and Treaty on Functioning of the European Union (TFEU) [OJ C 326.26.10.2012 p. 47].

¹¹⁸ See articles 206 and 207(1) TFEU.

¹¹⁹ Art 188A of Treaty of Lisbon states: "By establishing a customs union in accordance with Articles 23 to 27, the Union shall contribute, in the common interest, to the harmonious development of world trade, the progressive abolition of restrictions on international trade and on foreign direct investment, and the lowering of customs and other barriers." <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex%3A12007L%2FTXT>

¹²⁰ See especially Opinion 1/76 'Draft Agreement establishing a European laying-up fund for inland waterway vessels' [ECLI:EU:C: 1977:63]; Opinion 1/94 'Competence of the Community to conclude international agreements concerning services and the protection of intellectual property'; Opinion 2/00 [ECLI:EU:C: 2001:664].

the complementary internal competence in that specific domain “for the purpose of attaining a specific objective”; and that the Community’s participation is necessary for the realization of that objective.¹²¹

In other words, this opinion confirmed the ruling of the Kramer Case¹²² in the point that the simple existence of the internal competence suffices to establish an analogue external competence provided its necessity. Therefore, a possibility of implicitly conferred powers derived from other Treaty provisions or secondary legislation consequently appears to be as much essential as the taking into account of external ones.

Bilateral Investment Treaties

Before taking effect of the Lisbon Treaty, competence over foreign investment was highly fragmented due to various implied powers the European Union possessed in certain sectors. The previous analysis shows that in the field of investment as a whole not all relevant aspects have been included. By excluding portfolio investments one important component usually contained in International Investment Agreement falls outside the CCP’s scope. The European Union misses an admissible piece in its investment issue which interferes it to conclude all-included agreements as wholesome as conventional Bilateral Investment Treaties (BITs) usually conducted by the Member States (MS). And reason to that would be the EU’s decision to settle questions related to FDI, excluding portfolio investment.

Following the upper mentioned, in order to negotiate future BITs with its all aspects related to investment, the EU must cooperate with the Member States, calling for future for somewhat mixed agreements. On the other hand, since the delegated authority over foreign direct investment has been given to the EU, the Member States will not be able to conclude BITs on their own. Consequently, instead of forming a clear situation and centralization of authority, the predicament of a once again shared competence is established, with neither side being able to conclude a conventional and competitive agreement over investment without the cooperation of the other.

Whether one is in favour of a broad interpretation of the new FDI competence as suggested above or a rather narrow one: in either case various competences provided for in the BITs conducted by Member States with third countries now fall under the exclusive mandate of the European Union which indeed raises the question about the fate of these BITs. It is thus relevant to shed light on the question whether the Member States will be in the legitimate position to fulfil their obligations under their BITs or if they, by doing so, would contravene their responsibilities towards the EU. The following paragraphs shall thus provide a brief survey of the questions of the future legal validity of the existing BITs and, more importantly, what obligations the single MS have with regards to the EU and their international partners.


From all this, one question arises: What to do with Member States’ Bilateral Investment Treaties (BITs)? Over the last 50 years, the Member States of the EU concluded a large number of such bilateral agreements (see Figure 1). There are two types of BITs: treaties between Member States and third countries and; intra-EU agreements.

Figure 1. Overview of the number of Bilateral Investment Treaties concluded by Member States

¹²¹ CJEU Opinion 1/76, part 3 and part 4.

<https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/HTML/?uri=CELEX:61976CV0001&from=EN>

¹²² Kramer Case, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX%3A61976CJ0003>, On the same principle of parallelism, CJEU stated: “flow implicitly from other provisions of the Treaty, from the Act of Accession and from measures adopted within the framework of those provisions, by the Community institutions”.



Source: COM(2010)343 final¹²³

One of the remedies can be found in Article 351 Treaty on the Functioning of the European Union (TFEU) (Ex Article 307 TEC) which states:

“The rights and obligations arising from agreements concluded before 1 January 1958 or, for acceding States, before the date of their accession, between one or more Member States on the one hand, and one or more third countries on the other, shall not be affected by the provisions of the Treaties.”

This article can be used as an analogy to justify the validity of existing BITs. In this regard, the principle *pacta sunt servanda* comes as a core of this remedy. The principle represents obligation by contract shall be respected and parties shall not invoke provisions of their domestic law as premise for failure of performance.¹²⁴ Particularly, the basic intention of Article 351 TFEU is to demonstrate a clear division that exists between agreements entered into before and those concluded after the European Union assumed competence in a specific domain from the MS, leaving the first act intact in essence, whereas the latter would contravene Union law.

Favouring the analogy of Article 351 TFEU, one, however, has to take into account the subsequent paragraph alike. The paragraph further states that:

“To the extent that such agreements are not compatible with the Treaties, the Member State or States concerned shall take all appropriate steps to eliminate the incompatibilities established.”

Without question, this provision commits the Member State to abolish any noncompliance that might arise between their existing BITs and prospective EU provisions regulating the same subject matter, therefore incorporating the duty of loyal cooperation.

Finally, it is obvious that the investment agreements conducted between Member States and third parties have not implicitly been terminated despite the non-provision of a transitional period for the existing BITs on sides of the Treaty of Lisbon or other provisions in EU law. By virtue of the general principles of international law as well as by analogy of Article 351 TFEU the BITs will remain in force for the time being and will thus not contravene existing EU law. However, this situation applies only as long as the BITs in question comply with parallel EU provisions. Consequently, the Member States are obliged to remove any inconsistency that may spring from their proper BITs.¹²⁵

Extra-EU BITs

